



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ХҮНС ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДДАГ ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА

Улаанбаатар хот
2024 он



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ХҮНС ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДДАГ ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА

2024 он

Судалгааг хийсэн:

“Олонлог судалгаа аргачлалын төв”
төрийн бус байгууллага

Судлаачид:

Д.Больтогтох, Ph.D

Б.Бадамхүү, MBA

Ж.Номин-Эрдэнэ, BA

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ.....	3
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	8
ТАЛАРХАЛ	9
ХУРААНГУЙ.....	10
УДИРТГАЛ.....	11
БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА	16
1.1. Макро эдийн засгийн өнөөгийн байдал	16
1.2. Нийгмийн халамжийн үйлчилгээний өнөөгийн байдал.....	23
1.3. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний өнөөгийн байдал	27
БҮЛЭГ 2. ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН	31
2.1. Өрхийн нийгмийн үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал	34
2.2. Өрхийн хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал	38
2.3. Өрхийн хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдийн өнөөгийн байдал	44
2.4. Өрхийн орлого	50
2.4.1 Өрхийн орлогын бүтэц ба орлогын ангилал	50
2.4.2 Өрхийн орлогын статистик үзүүлэлтүүд.....	53
2.5 Хамаарлын шинжилгээ	58
2.5.1 Онцлог өрхүүдийн орлогын харьцуулалтын үр дүн.....	58
2.5.2. Регрессийн шинжилгээний үр дүн	62
2.6. Чанарын судалгааны үр дүн	67
2.6.1. Экспертийн ярилцлагын үр дүн	67
2.6.2 Бүлгийн ярилцлагын үр дүн	78
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	83
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	99
ХАВСРАЛТ	102

ӨМНӨХ ҮГ

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь манай улсын хувьд чухал байна. Иймд нийслэлийн 9 дүүргийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг Нээлттэй нийгэм форумын захиалгаар доктор, профессор Д.Больтогтох ахлагчтай судалгааны баг хийж гүйцэтгэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг санал болгосныг сонирхогч талуудад хүргэж байна.

Судалгаагаар хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд боловсрол, нас, статус буюу өрхийн гишүүний үүрэг болон дүүрэг, хороонд ажил хайгчаар бүртгүүлсэн байдал зэрэг хүчин зүйл нөлөөлж байгаа нь ажиглагдлаа. Судлаачид өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээний талаар зөвлөмж гаргалаа. Тухайлбал, хөдөлмөрийн насны гишүүдийн мэргэжлийн болон зөөлөн ур чадварыг сайжруулах, залуучуудын болон эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг тусгайлан авч үзэх, хөдөлмөр эрхэлж эхэлсэн гишүүдийг ажлын байрандаа тогтвортой ажиллахад нь дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн үйлчилгээг сайжруулах, өрхийн гишүүдэд сэтгэл зүй, гэр бүлийн харилцаа, өрхийн хөгжил, нийгэмшихүйн сургалт, зөвлөгөө үзүүлэх, идэвхжүүлэх, хорооны мэргэжилтний ажлын хүрээг оновчлох, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үр дүнд анхаарах, хөдөлмөрийн биржийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг цогц арга хэмжээг авахыг зөвлөмж болгожээ.

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд энэхүү судалгаа зохих хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна. Судалгааг хийж гүйцэтгэсэн судалгааны баг, судалгааны тайланг сайжруулахад үнэтэй санал шүүмж өгч ажилласан хөндлөнгийн шинжээч С.Баттулга, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам нарт талархал илэрхийлье.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлбар
АХБ	Азийн хөгжлийн банк
АНУ	Америкийн нэгдсэн улс
АМЧБ	Ажил мэргэжлийн чиг баримжаа
БРАК	BRAC-Bangladesh Rural Advancement Committee
ЗГ	Засгийн газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
ТБ	Төрийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын их хурал
ХТДҮҮ	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
ХЭБ	Хүнсний эрхийн бичиг
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Макро эдийн засгийн зарим үзүүлэлт	17
Зураг 2.	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, дүүргээр	18
Зураг 3.	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувиар, нийслэл, насны бүлгээр.....	19
Зураг 4.	Нийслэлийн нэг өрхийн сарын дундаж орлого, төгрөгөөр.....	20
Зураг 5.	Өрхийн нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь болон мөнгөн орлогод цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн эзлэх хувь.....	21
Зураг 6.	Ажиллах хүч, ажилгүй хүн, ажиллах хүчнээс гадуурх хүний тоо, улсын дүнгээр.....	22
Зураг 7.	Ажил эрхлэхгүй байгаа нийтлэг шалтгаан, хувиар, улсын дүнгээр.....	22
Зураг 8.	Тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн нийгмийн халамжийн нийт зарцуулалтын хэмжээнд эзлэх хувь, нийт халамжийн үйлчилгээнд хамрагдагчдын тоо.....	26
Зураг 9.	ХТДҮҮ-нд хамрагдагчид болон зарцуулсан хөрөнгийн хэмжээ, улсын хэмжээгээр	28
Зураг 10.	Судалгааны эх олонлог	32
Зураг 11.	Дүүрэг тус бүрээс хамрагдсан түүврийн хэмжээ	33
Зураг 12.	Өрхийн тэргүүний нас	36
Зураг 13.	Өрхийн тэргүүний гэрлэлтийн байдал	36
Зураг 14.	Өрхийн тэргүүний боловсрол.....	37
Зураг 15.	Хөгжлийн бэрхшээлийн төрөл.....	38
Зураг 16.	Хөдөлмөрийн насны гишүүдийн боловсрол	39
Зураг 17.	Ажиллах хэлбэр.....	42
Зураг 18.	Ажил олгогчийн хариуцлагын хэлбэр.....	42
Зураг 19.	Эрхэлж буй ажлын ангилал	43
Зураг 20.	Эрхэлж буй ажлын салбар	43
Зураг 21.	Хөдөлмөр эрхэлж байсан туршлага.....	45
Зураг 22.	Хөдөлмөр эрхлээгүй шалтгаан, давтамжийн хувиар	46
Зураг 23.	Ажил олох суваг, давтамжийн хувиар.....	47
Зураг 24.	Ажил олдохгүй байгаагийн шалтгаан, давтамжийн хувиар	47
Зураг 25.	Ажлын байрны шаардлагад нийцэхгүй байдал, давтамжийн хувиар .	48
Зураг 26.	Дүүрэг, хорооны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны тохиромжтой байдал, давтамж, харгалзах хувиар	49
Зураг 27.	Хөдөлмөр эрхлэхэд өрхөд тулгамдаж буй бэрхшээл, давтамжийн хувиар	49
Зураг 28.	Өрхийн орлогын бүтэц, эзлэх хувиар	51
Зураг 29.	Өрхийн орлогын дундаж, төгрөгөөр.....	53
Зураг 30.	Өрхийн орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, дүүргээр	59

Зураг 31. Өрхийн орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, өрхийн тэргүүний хүйсээр.....	62
Зураг 32. Хөдөлмөр эрхлэлтийн чиг үүргийн гүйцэтгэл, зарцуулах цагт тулгуурласан эрэмбэ.....	68
Зураг 33. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны давуу талууд, давтамжийн хувиар.....	71
Зураг 34. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны дутагдалтай талууд, давтамжийн хувиар.....	72
Зураг 35. Хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээл, давтамжийн хувиар.....	74
Зураг 36. Хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээл, хөдөлмөр эрхэлдэггүй иргэний хувьд.....	76
Зураг 37. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжууд, давтамжийн хувиар.....	77

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Нийгмийн халамжийн хүрээнд мөрдөгдөж байгаа хуулиуд	23
Хүснэгт 2.	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид ба олгосон зардал, төрлөөр, мянган хүнээр, сая төг	24
Хүснэгт 3.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зардал, хөтөлбөр, тэрбум төг	29
Хүснэгт 4.	Өрхийн тоо, дүүрэг, хороогоор	33
Хүснэгт 5.	Хөдөлмөрийн насны гишүүний эзлэх хувь, насны ангиллаар	34
Хүснэгт 6.	Өрхийн гишүүдийн насны ангилал, дүүргээр	35
Хүснэгт 7.	Өрхийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүний тоо	37
Хүснэгт 8.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн тоо, дүүргээр	37
Хүснэгт 9.	Газрын эзэмшлийн хэлбэр	38
Хүснэгт 10.	Хөдөлмөрийн насны гишүүний тоо, нас, хүйсээр	39
Хүснэгт 11.	Хөдөлмөр эрхэлдэг гишүүний тоо, дүүргээр	40
Хүснэгт 12.	Хөдөлмөр эрхлэлтийн байдал, нас, хүйсээр	41
Хүснэгт 13.	Хөдөлмөр эрхлэлтийн байдал, дүүргээр	41
Хүснэгт 14.	Судалгаанд хамрагдагсдын цалингийн хэмжээ, төгрөгөөр	44
Хүснэгт 15.	Долоо хоногийн ажлын цаг	44
Хүснэгт 16.	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт	45
Хүснэгт 17.	Ажлын байрны зуучлал, дүүргээр	46
Хүснэгт 18.	Өрхийн орлогын ангилал, эзлэх хувиар	51
Хүснэгт 19.	Өрхийн орлогын ангилал, эзлэх хувиар (үргэлжлэл)	52
Хүснэгт 20.	Өрхийн орлогын статистик үзүүлэлтүүд, төгрөгөөр	54
Хүснэгт 21.	Өрхийн орлогын статистик үзүүлэлтүүд (үргэлжлэл)	56
Хүснэгт 22.	Өрхийн орлогын статистик үзүүлэлтүүд, төгрөгөөр (үргэлжлэл)	57
Хүснэгт 23.	Өрхийн орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, өрх толгойлсон байдлаар	60
Хүснэгт 24.	Орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй байдлаар	60
Хүснэгт 25.	Орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, ажил эрхэлдэг гишүүний тоогоор	61
Хүснэгт 26.	Өрхийн орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, өрхийн тэргүүний ажил эрхлэлтээр	61
Хүснэгт 27.	Өрхийн сарын нийт орлогын хэмжээнд нөлөөлөгч хүчин зүйлсийн шугаман загварын үнэлгээний үр дүн	63
Хүснэгт 28.	Өрхийн сарын нийт орлогын хэмжээнд нөлөөлөгч хүчин зүйлсийн шугаман бус загварын үнэлгээний үр дүн	64
Хүснэгт 29.	Хөдөлмөрийн насны гишүүний ажил эрхлэлтэд нөлөөлөх хүчин зүйлсийн ложит загварын үнэлгээний үр дүн	65

Хүснэгт 30. Хөдөлмөрийн насны гишүүний ажил эрхлэлтэд нөлөөлөх хүчин зүйлсийн пробит загварын үнэлгээний үр дүн	66
Хүснэгт 31. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, хувиар	69
Хүснэгт 32. Хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээл, хөдөлмөр эрхэлдэг иргэний хувьд.....	75

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны асуумж.....	102
Хавсралт 2. Фокус бүлгийн ярилцлагын асуулт	113
Хавсралт 3. Экспертийн ярилцлагын асуумж	113
Хавсралт 4. Мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт ба чанарын хяналтын үйл явц	123
Хавсралт 5. Тоологч, судлаачдад зориулсан гарын авлага	125
Хавсралт 6. Хороодын байршлын зураглал.....	140
Хавсралт 7. Регрессийн үр дүн.....	142
Хавсралт 8. Дунджийн харьцуулалтын төстийн үр дүн.....	144

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн Нээлттэй Нийгэм Форумд болон судалгааны ажилд үнэтэй санал, шүүмж өгсөн тус байгууллагын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам болон хөндлөнгийн шинжээч С.Баттулга нарт гүн талархал илэрхийлье.

Мөн судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжиж ажилласан Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар болон нийслэлийн 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн хамт олон, түүвэрт сонгогдсон хороодын Засаг дарга, хөдөлмөр эрхлэлт, халамж хариуцсан мэргэжилтэн, зохион байгуулагч, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарт мөн талархсанаа илэрхийлж байна.

Судалгааны ажлын хүрээнд бидэнтэй цаг гарган ярилцаж, өөрсдийн мэдлэг туршлагаа хуваалцсан хороодын хөдөлмөр эрхлэлт, халамж хариуцсан мэргэжилтнүүд болон салбарын төлөөлөл болсон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдэд талархаж байна.

Эцэст нь энэхүү судалгаанд оролцож мэдээлэл өгсөн болон бидний урилгын дагуу хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлаар өөрсдийн санал бодлоо хуваалцаж, нээлттэй ярилцсан өрхийн төлөөлөл, сонгогдсон хороодын иргэдэд баярлаж талархсанаа илэрхийлье.

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны хүрээнд Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ (ХТДҮҮ)-нд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлах, цаашид эдгээр гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэхэд зайлшгүй анхаарах шаардлагатай асуудлуудыг илрүүлэх зорилго дэвшүүлэв. Судалгаанд нийслэлийн 9 дүүргийн ХТДҮҮ-нд хамрагддаг хөдөлмөрийн насны гишүүд болон хороодын хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүд, салбарт үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон дотоодын төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий салбарын экспертүүдийг оролцуулсан.

Өрхийн онцлог, хөдөлмөрийн насны гишүүдэд хөдөлмөр эрхлэхтэй холбоотой гардаг бэрхшээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжууд болон өрхийн орлого, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлохдоо тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан хэрэглэсэн ба тодорхойлохдоо болон дүгнэлтийн статистикууд, эконометрикийн загварууд ашиглан тархалт болон нөлөөллийг үнэлж дүгнээд, зөвлөмж боловсруулсан болно. ХТДҮҮ-нд хамрагдаж буй өрхийн дийлэнх нь олон хүүхэдтэй, орлого багатай, 30 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй, хөдөлмөр эрхэлдэг гишүүн нь хөдөлмөрийн үнэлэмж багатай байна.

ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд гишүүний боловсрол, нас, статус буюу өрхийн гишүүний үүрэг, дүүрэг, хороонд ажил хайгчаар бүртгүүлсэн байдал зэрэг хүчин зүйл нөлөөлж байгаа нь судалгаанаас харагдлаа.

Хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Цогц арга хэмжээнд гишүүдийн мэргэжлийн болон зөөлөн ур чадварыг нэмэгдүүлэх, залуучуудын болон ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг тусгайлан дэмжих, хөдөлмөр эрхэлж буй гишүүдийг ажлын байрандаа тогтвортой ажиллахад нь дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн үйлчилгээг сайжруулах, өрхийн гишүүдэд сэтгэл зүй, гэр бүлийн харилцаа, өрхийн хөгжил, нийгэмшихүйн сургалт, зөвлөгөө үзүүлэх, идэвхжүүлэх, хорооны мэргэжилтний ажлын хүрээг оновчлох, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үр дүнд анхаарах, хөдөлмөрийн биржийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг олон ажлыг авч үзэх боломжтой.

УДИРТГАЛ

Улсын их хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Монгол Улс 2050 он гэхэд нийгэм, эдийн засаг, иргэдийн амьдралын чанараар Азидаа тэргүүлэгч орон болохын тулд 9 зорилго дэвшүүлсний нэг нь өрх, иргэн бүрд тэгш хүртээмжтэй эдийн засагтай орон болно гэж тусгасан. Уг тогтоолд хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой 2023 он хүртэлх хугацаанд “Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдал нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин буурч, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн байна” гэсэн зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлснээр ядуурлын түвшинг 15, ажиллах хүчний оролцооны түвшинг 65, ажилгүйдлийн түвшинг 7 хувьд хүргэнэ гэж заасан.

Олон улсын туршлагаас харахад нийгмийн хамгааллын зардал өндөр байх тусам ядуурал буурах хандлагатай байдаг. Африк, Ази, Төв болон Зүүн Европ, Латин Америкт мөнгөн тэтгэмжийн хөтөлбөр хэрэгжүүлснээр ядуурлыг амжилттай бууруулж чадсан гэж үздэг¹. Бодит байдал дээр мөнгөн тэтгэмжийн хэмжээ иргэдийн хэрэгцээт түвшнээс доогуур байдаг хэдий ч мөнгөн тэтгэмжийг зохистой түвшинд тогтоон олгосноор иргэдийг ядуурлаас гаргах, мөн ядуурлын гүнзгийрэлтийг багасгахад үр нөлөөтэй аж. Тодруулбал, цөөнгүй улс оронд нийгмийн хамгааллын механизмыг хөдөлмөрийн зах зээлийн бодлого, үйлчилгээтэй уялдуулснаар ажилгүй хүмүүс хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлсэн туршлагууд бий. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхүүдэд мөнгөн тэтгэмж олгосон нь АНУ-д тэдгээр өрхүүдийн ажиллах цаг нэмэгдэж, сарын орлого өсөхөд, Латин Америк болон Өмнөд Африкт хөдөлмөр эрхлэх чадамжаа сайжруулан, илүү сайн ажил хийх боломжийг бүрдүүлэхэд, мөн Энэтхэг, Угандад иргэдэд ажил хайх, чанартай сургалтад хамрагдаж, ур чадвараа хөгжүүлэх, жижиг тариалан, үйлдвэрлэл эрхлэхэд нь чухал дэмжлэг болжээ.

Манай оронд сүүлийн жилүүдэд халамжийн зардлыг тогтмол нэмэгдүүлсэн бөгөөд 2021 оноос нийгмийн халамжийн сангийн зарцуулалт огцом өссөнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээ

1 Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Бүх нийтийн нийгмийн хамгаалал, Нийгмийн хамгааллыг өргөжүүлснээр хөгжилд үзүүлэх нөлөө

нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. 2023 оны 3 дугаар сарын нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын тайланг харвал, нийт зарцуулалтын 69 хувийг хүүхдийн мөнгөн тэтгэмж эзэлж байна. Харин ядууралд өртсөн, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд зориулсан ХТДҮҮ-ний зардалд нийт зардлын 1 хувь ногдож байна². Өөрөөр хэлбэл, Монгол Улсад нийгмийн халамжийн зардал өсөн нэмэгдэж байгаа боловч санхүүжилтийн дийлэнх хувь нь хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулагдаж байна.

Нийгмийн халамжийн тогтолцоо нь зорилтот өрхийн орлогын баталгааг нэмэгдүүлснээр ядуурлын тэгш бус байдлыг бууруулах, эрүүл мэнд, боловсролын орчин, үр дүнг сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цаашлаад хүний хөгжил, бүтээмжийг дээшлүүлж, улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэгтэй. Гэтэл манай оронд зорилтот бүлгийн амьжиргаанд чиглэсэн халамжийн үйлчилгээ, түүнд ногдох санхүүжилт хязгаарлагдмал байна. 2017-2021 оны нийгмийн халамжийн үзүүлэлтүүдээс харвал энэ төрлийн халамжийн үйлчилгээ хүртэгчийн тоо 314,931-ээс 167,280 болж, улмаар санхүүжилт нь буурчээ³.

Хэдийгээр хүүхдийн мөнгөн тэтгэмж нь өрхийн амьжиргааг дэмжих мөнгөн дэмжлэг, туслалцааны нэг хэлбэр боловч иргэдийнхээ эдийн засгийн идэвх оролцоог дэмжих зорилгоор өндөр хөгжилтэй орнуудад болзол тавилгүйгээр хүүхэд бүрт мөнгөн тэтгэмжийг олгодог туршлагауд бий. Харин ядуурлын түвшин нь 27.8 хувьтай хөгжиж буй манай орны хувьд, нэн тэргүүнд ядуурлын түвшнээс доогуур амьдарч буй иргэдийнхээ амьжиргааг дээшлүүлэхэд халамжийн бодлогыг чиглүүлэхийн оронд гол санхүүжилтээ зорилтот хүн амын 91 хувь нь хүртдэг хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулахын зэрэгцээ нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрхүүдэд болзол тавьж, тэдэнд зориулсан санхүүжилтээ бууруулж буй нь халамжийн бодлогын хэрэгжилт Засгийн газрын “Халамжаас хөдөлмөрт шилжих” бодлоготой уялдахгүй буй мэт дүр зураг харагдаж байна.

Дэлхийн олон улс оронд мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг гол шалтгаан нь мөнгөн тэтгэмж олгох нь ядууралтай тэмцэх үр дүнтэй аргуудын нэгд зүй ёсоор тооцогддог бөгөөд тухайн улсын эдийн засгийг

2 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ, төрлөөр, сар, жилээр мэдээллээс тооцоолов. https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2200_010V4

3 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт [2022] Монгол Улсын нийгмийн халамжийн үзүүлэлтүүд 2017-2021 он

эргэлтэд оруулах эерэг нөлөөтэй гэж үздэг. Тиймдээ ч Австри, Герман, Финланд зэрэг өндөр хөгжилтэй орнуудад хүүхдийн мөнгөн тэтгэмжийг бүх хүүхдэдээ ялгалгүйгээр олгодог жишээ бий.⁴

Харин буурай хөгжилтэй, хөгжиж буй орнуудын хувьд бэлэн мөнгөний дэмжлэгийг хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн хамгааллын бодлогуудтай уялдуулан хэрэгжүүлснээр тухайн салбарын олон асуудлыг шийдвэрлэх гарц болсон олон улсын туршлага байдаг. Тухайлбал, Бангладеш Улс дахь ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг БРАК (BRAC) олон улсын байгууллага нь өөрийн хөтөлбөрт хамрагдсан иргэдэд мөнгөн дэмжлэгийг, ур чадвар олгох үйл ажиллагаатай хослуулан хэрэгжүүлснээр олон сая хүнийг ядуурлаас гаргасан байдаг. БРАК-ийн “Төгсөлтийн аргачлал” нь ядуурлыг бууруулахын тулд нэн ядуу өрхүүдэд нийгэм, эдийн засгийн хүнд байдлыг даван туулах чадварыг бий болгох боломжийг олгодог, цаг хугацаа, дэс дараалалтай, нэгдсэн, цогц арга хэмжээ юм.

Энэ загварыг анх Бангладеш Улсад нэвтрүүлсэн бөгөөд туршилтыг амжилттай хийж, арга зүйг өргөжүүлснээр одоо тус байгууллага нь улс орнуудын Засгийн газруудад уг загварыг нэвтрүүлэхэд нь техникийн туслалцаа үзүүлж байна. Өнөөдөр дэлхийн 40 гаруй оронд, 90 гаруй “Төгсөлтийн аргачлал”-ын төсөл 3.1 сая гаруй өрхөд (14 сая хүн) хэрэгжиж байна. 2030 он гэхэд “Төгсөлтийн аргачлал” 12.3 сая өрх буюу 53.2 сая иргэнд хүрнэ гэсэн тооцоо бий.

Монгол Улс нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ны “Халамжаас хөдөлмөрт” хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 6 дугаар сараас Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн ХТДҮҮ-нд хамрагддаг 1520 өрхөд “Төгсөлтийн аргачлалын туршилтын төсөл”-ийг Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна.⁵

Халамжийн бодлого, түүний хэрэгжилт нь хөдөлмөрийн зах зээл, ажил эрхлэлтэд хэрхэн нөлөөлж буйг судалсан судалгааны ажлууд манайд цөөнгүй бий. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх судалгааны тайлангуудаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ялангуяа залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дүгнэсэн үр дүнгүүдийг доор авч үзэв.

ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн хөдөлмөр эрхлэлтийн талаар 2022 онд АХБ-ны санхүүжилттэй “Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн

4 Unicef, 2020, Universal child benefits

5 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудас, <https://mlsp.gov.mn/content/detail/1512>

чадавх бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс судалгаа нийтэлжээ. Уг судалгаа нь ХТДҮҮ-нд хамрагдаж буй иргэдийн үндсэн шинж байдал, хамрагдсан хугацаа, хөдөлмөр эрхлэлтийн түүх, ур чадвар, хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлт, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдаж буй байдалд үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн байдалд дүгнэлт, санал зөвлөмж өгсөн байна. Энэхүү судалгааны гол үр дүнгээс дурдвал, ХТДҮҮ-нд хамрагдаж буй өрхүүдийн дийлэнх нь ядуу, нэн ядуу бөгөөд тэдгээрийн ажилгүйдлийн түвшин өндөр байгаа бөгөөд уг үйлчилгээнд хамрагдсанаар иргэд хөдөлмөр эрхлэхгүй болж байгаа гэх нотолгоог олоогүй байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийн албанаас санал болгож буй ажлын байрыг хүлээж аваагүй тохиолдолд хүнсний эрхийн бичиг олголтыг зогсоох нь учир дутагдалтай бөгөөд өрхөд эрсдэлтэй гэж үзсэн ба ийнхүү саналаас татгалзахад өрхөд олгох мөнгөн тэтгэмжийг зогсоох бус, харин ажлын саналд татгалзах шалтгааныг тодруулж, бэрхшээлийг арилгахад чиглэж ажиллах хэрэгтэй гэж дүгнэсэн байна.

Мөн Монголбанкны эдийн засагч С.Мөнхчимэгийн “Нийгмийн халамжийн бодлогын хөдөлмөрийн зах зээл, ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөө” судалгаагаар халамжийн нийт зардал нэмэгдсэн нь ажиллах хүчний оролцооны түвшин, ажил эрхлэлт, бодит дундаж цалин, ажилгүйдэл зэрэгт нөлөөгүй гэж тодорхойлон дүгнэсэн бөгөөд тэрбээр цаашид нийгмийн халамжийн хөтөлбөр бүрийн хувьд микро түвшний тоон мэдээллийг бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээл болон эдийн засаг дахь нөлөөг нарийвчлан авч үзэхийг санал болгосон байна.

Иймд ядуурал, тэгш бус байдлыг бууруулах, зохистой хөдөлмөр эрхлэлт, хүртээмжтэй орлогын өсөлтийг дэмжихийн тулд бүх нийтийн, ялангуяа зорилтот өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжуудыг судлах, энэ чиглэлээр баримталж буй бодлогын баримт бичигт тусгах, үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Энэхүү судалгаа нь ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлах, цаашид эдгээр гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэхэд зайлшгүй анхаарах шаардлагатай асуудлуудыг илрүүлэх зорилготой. Энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

1. ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн нийгэм, эдийн засгийн байдал, орлогын бүтэц болон мөнгөн тэтгэмжийн өрхийн орлогод эзлэх хувь нэмрийг

өрхийн тэргүүний нас, амьдарч буй нөхцөл, өрхийн гишүүдийн бүтэц, өрх толгойлсон байдал, хөдөлмөр эрхэлж буй гишүүдийн тоо зэрэг категориудаар ялган тодорхойлох;

2. ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, хөдөлмөр эрхлээгүй шалтгаан, тулгамдаж буй бэрхшээл, өнөөгийн хэрэгцээ шаардлага, иргэнд тохирох ажлын байр болон ажлын нөхцөл, өрхөд хандсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны сэтгэл ханамжийг боловсрол, мэргэжил, насны ангилал, хүйс, ажил олгогчийн статус, бусад онцлог, хөдөлмөр эрхлэлтийн төрөл зэрэг категориудаар ялган судлах;
3. ХТДҮҮ-нд хамрагддаг өрхүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжуудыг судлах.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА


1.1. Макро эдийн засгийн өнөөгийн байдал

Улс орнууд эдийн засгийн нөхцөл байдалтайгаа уялдуулан нийгмийн салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөж хэрэгжүүлдэг. Нийгмийн халамж нь эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа бөгөөд эдийн засгийн өсөлт, инфляц, ядуурал, цалин, хөлс, ажилгүйдлээс хамаарч халамж шаардлагатай иргэдийн тоо болон халамжид зарцуулагдах мөнгөн хэмжээ шууд хамаарч байдаг. Иймд эдийн засгийн нөхцөл байдлын талаар товч авч үзье.

Сүүлийн 5 жилд “Ковид-19” цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн өсөлт саарсан бөгөөд 2022 оноос эхлэн эдийн засаг өсөлттэй байгаа ч инфляц хоёр оронтой тоотой, ядуурлын хамралтын хүрээ 27 хувьтай хэвээр байна. Инфляцын түвшин буурахгүй байгаа нь иргэдийн худалдан авах чадварт нөлөөлж, ялангуяа эмзэг, бага орлоготой иргэдийн хувьд наад захын хэрэгцээг хангахад хүндрэлтэй болгож байна. Тодруулбал, Зураг 1-д харуулснаар, 2021 онд огцом буурсан ДНБ-ий цэвэр өсөлт сүүлийн жилүүдэд дахин сэргэж, аажмаар өссөн төдийгүй ажилгүйдлийн түвшин буурах хандлагатай байхад инфляцын түвшин 10 хувьтай хэвээр байна. Түүнчлэн, хүн амын хэдэн хувийг ажиллагчид эзэлж байгааг харуулдаг хөдөлмөр эрхлэлтийн түвшин улсын хэмжээнд 54 хувьтай байна. Монгол Улсын хэмжээнд ядуурлын түвшин 2020 оны байдлаар 27.8 хувьтай байгаа нь 2018 онтой харьцуулахад 0.6 нэгж хувиар ялимгүй буурсан үзүүлэлт болж байна⁶.

6 Тойм (worldbank.org)

Зураг 1. Макро эдийн засгийн зарим үзүүлэлт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 2023 оны III улирлын хөдөлмөр эрхлэлтийн түвшин, улсын дүнгээр авсан. Ядуурлын хамрагдалтын хүрээний түвшинг 2 жил тутамд ҮСХ, Дэлхийн банк хамтран тооцдог ч 2022 онд мэдээлэгдээгүй байна.

Нийслэлийн хувьд, сүүлийн 5 жилд хөдөлмөр эрхлэлтийн түвшин тогтвортой өсөлттэй бус, 46-51 хувь хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд дунджаар 49 хувь байгаа нь улсын дунджаас бага байна. Тэр тусмаа, Багануур, Багахангай дүүрэгт хөдөлмөр эрхлэлт хамгийн бага түвшинтэй ба буурах хандлагатай байхад Сүхбаатар дүүрэгт 2021 оноос хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдэх чиг хандлагатай байна. Бусад дүүргийн хувьд уг түвшин ойролцоо хувьтай бөгөөд хэлбэлзэл ихтэй харагдаж байна (Зураг 2).


Зураг 2. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, дүүргээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн насны иргэдийн насны ангиллаар авч үзэхэд сүүлийн 5 жилийн хугацаанд 35-39 насныхны хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурсан, 44-54 насныхны хувьд дунджаар 13 хувиар өссөн, 2022 оны байдлаар 45-49 насныхны хөдөлмөр эрхлэлт улсын дунджаас хамгийн өндөр буюу 77 хувьтай байна.

Зураг 3. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувиар, нийслэл, насны бүлгээр




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Иргэдийн цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ инфляцтай уялдаж нэмэгддэггүйтэй холбоотойгоор өрхийн орлого хангалттай хэмжээнд хүрч өсөхгүй байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд улсын хэмжээнд нэг өрхийн сарын дундаж орлогын дундаж өсөлт 1.1, нийт орлогод эзлэх мөнгөн орлого 92 хувьтай, цалин, хөлсний өсөлт 1.12,

тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт 1.21 байгаа бөгөөд аль ч орлогын төрөлд дорвитой өөрчлөлт ороогүй байна (Зураг 4).


Зураг 4. Нийслэлийн нэг өрхийн сарын дундаж орлого, төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Өрхийн сарын нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь сүүлийн 5 жилд дунджаар 0.34 хувь өсөж, мөнгөн орлогод эзлэх цалин, хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн орлогын өсөлт харгалзан дунджаар 0.44 болон 1.22 хувьтай байгаа нь иргэдийн амьжиргааг төдийлөн нэмэгдүүлэхүйц байж чадахгүй байна. Өрхийн нийт орлогод тэтгэвэр, тэтгэмжийн эзлэх хувь 2017 оноос 2021 он хүртэл өсөлттэй, 2022 онд 5 хувийн бууралттай байна.

Зураг 5. Өрхийн нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь болон мөнгөн орлогод цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн эзлэх хувь




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ажиллах хүчний хувьд сүүлийн 4 жилийн хугацаанд дунджаар 1 сая 250 орчим мянган хүн байгаа бөгөөд ажилгүй хүний тоо 105,614-аас 84,736 болтол буурсан эерэг үр дүн харагдаж байгаа боловч ажиллах хүчнээс гадуурх⁷ хүн амын тоо дунджаар 6,600 орчим хүнээр нэмэгдсэн байна.

7 Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэдэг нь сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн ам юм гэж 2019 онд ҮСХ, ХНХЯ зэрэг байгууллагын хамтран гаргасан “Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-д тайлбарласан байдаг.


Зураг 6. Ажиллах хүч, ажилгүй хүн, ажиллах хүчнээс гадуурх хүний тоо, улсын дүнгээр




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ҮСХ-ноос ажилгүй иргэдийг ажилгүй байгаа 25 шалтгаанаар ангилан мэдээлдэг. Улсын хэмжээнд шалтгаан тус бүрээр ажилгүй иргэдийн нийт ажилгүйчүүдэд эзлэх хувиар эрэмбэлэн авч үзвэл 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 77 орчим хувийг 6 шалтгаан эзэлж байна (Зураг 7). Үүнд ажил хайгаад олдохгүй байгаа гэсэн шалтгаан хамгийн их буюу 31 хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн 4 жилийн байдлаар мэргэжил, дадлага туршлага байхгүй гэсэн шалтгаан 6 хувиас 10 хувь болтлоо өсжээ.

Зураг 7. Ажил эрхлэхгүй байгаа нийтлэг шалтгаан, хувиар, улсын дүнгээр





Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.2. Нийгмийн халамжийн үйлчилгээний өнөөгийн байдал

Монгол Улсад 1995 онд нийгмийн халамжийн багц хууль батлагдаж, нийгмийн зүгээс зайлшгүй дэмжлэг туслалцаа шаардлагатай бие даан амьдрах, өөртөө үйлчлэх чадваргүй эмзэг бүлгийн иргэдийн амьдралын баталгааг алдагдуулахгүй байх зорилгоор нийгмийн халамжийн тогтолцоо анх бий болжээ. Өнөөдөр нийгмийн халамжийн 6 үндсэн хуулийн хүрээнд Засгийн газраас иргэддээ халамжийн үйлчилгээг хүргэдэг (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Нийгмийн халамжийн хүрээнд мөрдөгдөж байгаа хуулиуд

№	Хуулиуд	Он
1	Нийгмийн халамжийн тухай	2012, шинэчилсэн найруулга
2	Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай	2017, шинэчилсэн найруулга
3	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай	2010
4	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай	2017
5	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай	1994
6	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2011

Эх сурвалж: ХНХЯ-ны цахим хуудас

Нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь тэтгэвэр, тэтгэмж, халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэсэн 4 төрөлтэй бөгөөд тэтгэвэр, тэтгэмжийн, нийгмийн үйлчилгээний гэсэн 2 сангаар дамжин иргэдэд хүрч байна. Үүнд, 5 төрлийн тэтгэвэр, 4 төрлийн асаргааны

тэтгэмж, 6 төрлийн онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 9 төрлийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд 6 төрлийн тусламж, хөнгөлөлт, эх хүүхэд, нийгмийн эмзэг бүлгийг дэмжих чиглэлээр үзүүлсэн 4 төрлийн зэрэг нийт 34 төрлийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийг олгож байна. 2022 оны байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 1,356,049 иргэн хамрагдаж, 515,941 сая төгрөгийн зардал гаргасан байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид ба олгосон зардал, төрлөөр, мянган хүнээр, сая төг

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Нийгмийн халамжийн тэтгэвэр	хүн	65,108.00	62,640.00	60,359.00	74,571.00	65,615.00
	сая төг	90,081.90	111,569.50	162,897.20	184,421.00	182,936.00
Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж	хүн	67,373.00	65,109.00	64,769.00	65,191.00	65,865.00
	сая төг	37,468.40	47,677.90	58,555.80	59,434.00	59,396.10
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	хүн	57,861.00	53,986.00	58,130.00	58,967.00	59,944.00
	сая төг	25,049.20	30,246.00	40,897.70	45,256.20	47,668.10
Эхийн алдар одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламж	хүн	220,403.00	222,427.00	231,452.00	239,303.00	246,686.00
	сая төг	28,777.60	29,273.70	29,775.20	30,465.70	31,009.20
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	хүн	19,258.00	15,294.00	10,906.00	9,118.00	10,177.00
	сая төг	3,584.00	1,696.60	1,746.50	2,074.40	2,590.20
Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	хүн	370.00	434.00	446.00	446.00	471.00
	сая төг	180.70	180.70	278.00	225.00	856.60

ХҮНС ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДДАГ
ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	хүн	237,164.00	294,110.00	261,340.00	211,644.00	279,493.00
	сая төг	25,858.20	30 206.3	28,510.10	16,936.50	25,984.10
Насны хишиг	хүн	131,313.00	138,383.00	146,327.00	157,697.00	168,201.00
	сая төг	20,526.90	21,754.30	22,754.00	24,028.60	25,062.80
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж	хүн	318,363.00	294,087.00	292,349.00	298,922.00	283,220.00
	сая төг	110,989.10	115,468.30	116,281.90	114,674.80	108,786.10
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	хүн	54,067.00	60,773.00	53,931.00	46,083.00	50,789.00
	сая төг	11,064.30	11,496.20	10,836.10	9,296.90	10,150.20
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	хүн	5,691.00	5,557.00	2,781.00	2,479.00	3,245.00
	сая төг	5,131.50	5,164.00	5,141.90	442.30	686.40
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	хүн	253,468.00	242,349.00	264,422.00	167,280.00	121,959.00
	сая төг	26,268.70	35,810.10	55,451.60	30,966.00	19,957.70
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	хүн	950,000.00	100,057.00	1,186,289.00	1,220,158.00	-
	сая төг	209,022.20	229,592.00	1,053,045.80	1,454,704.40	-
Цаатан иргэний тэтгэмж	хүн	392.00	368.00	397.00	395.00	384.00
	сая төг	565.30	655.80	745.80	804.70	857.60
НИЙТ	хүн	2,380,831.00	2,456,074.00	2,633,898.00	2,552,254.00	1,356,049.00
	сая төг	594,568.00	670,791.00	1,586,918.00	1,973,730.00	515,941.00

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын үзүүлэлтүүд, ХНХЯ⁸

Төрөөс нийгмийн халамжийн зардлыг тогтмол нэмэгдүүлсэн бөгөөд 2021 оноос нийгмийн халамжийн сангийн зарцуулалт огцом өссөнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. 2023 оны 3 дугаар сарын нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын тайланг харвал, нийт зарцуулалтын 69 хувийг хүүхдийн мөнгөн тэтгэмж эзэлж байна. Харин ядууралд өртсөн, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд зориулсан ХТДҮҮ-ний зардалд нийт зардлын 1 орчим хувь ногдож байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн нийт хэмжээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн эзэлж буй хувийг сүүлийн 5 жилийн байдлаар доорх зурагт үзүүлээ.

Зураг 8. Тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн нийгмийн халамжийн нийт зарцуулалтын хэмжээнд эзлэх хувь, нийт халамжийн үйлчилгээнд хамрагдагчдын тоо



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийгмийн халамжийн тогтолцоо нь зорилтот өрхийн орлогын баталгааг нэмэгдүүлснээр ядуурлын тэгш бус байдлыг бууруулах, эрүүл мэнд, боловсролын орчин, үр дүнг сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цаашлаад хүний хөгжил, бүтээмжийг дээшлүүлж, улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэгтэй. Гэтэл манай оронд зорилтот бүлгийн амьжиргаанд чиглэсэн халамжийн үйлчилгээ, түүнд ногдох санхүүжилт хязгаарлагдмал байгаа нь хэрэв ядуурлын түвшин буурч, иргэдийн амьдрал ахуй сайжирсан гэх шалтгаантай биш бол энэ бүлгийн иргэдийн амьжиргааг дэмжихэд төдийлөн ач холбогдол өгөхгүй байна гэсэн таамаглал дэвшүүлэхэд хүргэж байна.

1.3. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний өнөөгийн байдал

Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.1.1-д заасан хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг олгохоор болсон. Энэ хүрээнд 2008 онд хүнсний барааны өсөлтийг нэн ядуу иргэд даван туулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүнсний тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ” (ХТДҮҮ) хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн нь амьжиргааны түвшний үнэлгээ нь тухайн онд ХТДҮҮ-нд хамруулахаар баталсан босго оноотой тэнцүү буюу түүнээс доогуур байгаа иргэн байх бөгөөд⁹ НХХЯ-наас ХТДҮҮ-нд хамрагдах боломжтой өрхүүдийг тодорхойлж, иргэдэд дэмжлэг үзүүлж эхэлсэн байна.


2012 онд Нийгмийн халамжийн тухай хуулиар байнгын хөтөлбөр болсон бөгөөд 2023 оны 6 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд нийт 147,250, нийслэлийн хэмжээнд 68,609 иргэн ХТДҮҮ-нд хамрагдаж байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд хүнсний эрхийн бичиг олгох босго оноог орон нутагт 310.0, нийслэлд 292.5 ба түүнээс доош гэж тодорхойлсон ба өрхийн гишүүн-иргэнд сар бүр насанд хүрсэн хүнд 16,000 төгрөг, хүүхдэд 8,000 төгрөгийн үндсэн хэрэглээний дэмжлэг үзүүлнэ гэж тусгасан (ХНХЯ, Хүнсний эрхийн бичиг олгох журам, 2021).

2020 онд ХТДҮҮ-нд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэний хувьд хамгийн их буюу 55.45 тэрбум төгрөгийн дэмжлэгийг 264,420 иргэн авсан байна.

⁹ Хүнсний эрхийн бичиг олгох журам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103-р тушаал

Зураг 9. ХТДҮҮ-нд хамрагдагчид болон зарцуулсан хөрөнгийн хэмжээ, улсын хэмжээгээр



Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ийнхүү зорилтот өрхийн гишүүнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2008 оноос эхлэн хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг олгож ирсэнд иргэдийн бэлэнчлэх сэтгэлгээг өөгшүүлээ гэх зэргээр олон нийт шүүмжлэлтэй ханддаг бөгөөд иргэдийг өөрсдөө хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх шаардлага, нөхцөл тавьж, журамд тодорхой зохицуулалтууд хийсэн. ХТДҮҮ-нд хамрагдаж буй хөдөлмөрийн чадвартай хөдөлмөрийн насны иргэдэд “тухайн иргэн хөдөлмөр эрхлэх эсвэл хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд (ажлын байрны чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, орон нутгийн засаг захиргаанаас зохион байгуулагдсан олон нийтийн ажил, нийтийг хамарсан ажил гэх мэт) оролцсон байх ёстой” гэсэн шаардлага 2018 онд, “хэрэв ХТДҮҮ-нд хамрагдсан өрхийн гишүүн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлээгүй, хоёр удаа ажлын саналаас татгалзсан бол дэмжлэг олгохоос татгалзана” гэж 2021 онд өргөтгөж оруулсан. Эдгээр өөрчлөлт нь ХТДҮҮ нь түр хугацаагаар дэмжлэг үзүүлж буй хэлбэр учраас иргэдийг ажил хайх, хөдөлмөр эрхлэлтэд нь түлхэц болох өөрчлөлт орсон гэж үзэж байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт нийт 24 байгууллагын 34 төсөл хэрэгжиж, зарим нь дууссан байна. Эдгээр төсөл, хөтөлбөрүүд нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гаар дамжин санхүүжигдэж байна.

ХЭДС-гийн орлогын гол эх үүсвэр нь улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө болон гадаад иргэнийг ажиллуулсан ажил олгогчийн төлөх

ажлын байрны төлбөр бөгөөд 2022 онд нийт 59.9 тэрбум төгрөг санд төвлөрч, Сангийн яамны мэдээлснээр 11 хөтөлбөрт 73.8 тэрбум төгрөгийн зардал гаргасан бөгөөд үүнээс “Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” болон “Жижиг зээл болон дотоод эх үүсвэрээс олгосон зээл”-д 41.3 тэрбум төгрөгийн зардал гаргажээ.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл (ХЭҮЗ)-ийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөр”-ийг дараах 7 чиглэлээр 2022 оны 2 дугаар сард баталсан бөгөөд энэхүү хөтөлбөрүүд хэрэгжилтийн шатандаа явж байна¹⁰.

Хүснэгт 3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зардал, хөтөлбөр, тэрбум төг

Хөтөлбөрийн нэр	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	11.2	13.7	9.8	9.9	21.3
Жижиг зээл болон дотоод эх үүсвэрээс олгосон зээл	15.9	8.0	2.2	-	20.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	3.6	3.5	3.4	6.4	9.6
“Ногоон ажлын байр” хөтөлбөр	-	-	-	-	7.1
Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	1.2	1.6	1.2	1.4	5.5
Засгийн газар, ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлогдсон бусад төсөл, хөтөлбөр	4.9	2.1	-	6.4	3.0
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал	3.3	3.1	2.1	3.8	2.9
Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	1.0	0.9	0.2	0.5	1.4
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2.7	5.2	1.2	0.8	1.2
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	1.0	1.3	0.7	0.8	1.2
Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	-	-	-	-	0.6
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	5.8	5.5	2.3	-	-
Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд хуваарилах суралцагчдын тэтгэлэг	-	18.6	45.7	56.7	-
Нийт	50.6	63.6	68.7	86.8	73.8

Эх сурвалж: Сангийн яам

10 Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөр батлах тухай, 2022.02

Дээрх хүснэгтээс харвал, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд хуваарилах суралцагчдын тэтгэлгийн зардал нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нийт зардлын хамгийн их буюу 35 хувийг эзэлж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн хөтөлбөрүүдийн хувьд, аж ахуй эрхлэлтийг дэмжих болон жижиг зээлийн зардалд тус сангийн зардлын 32 хувь ногдож байхад, зарим хөтөлбөр, тэр тусмаа хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр хийгээд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зардал хамгийн бага буюу тус бүр сангийн нийт зардлын 1 хүртэлх хувь байна.

БҮЛЭГ 2. ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгааны хүрээ, арга зүй

Судалгаанд нийслэлийн 9 дүүрэг дэх ХТДҮҮ-нд хамрагддаг өрхүүдийн хөдөлмөрийн насны гишүүдийг олон шатлалт, бүлэглэсэн түүвэрлэлтийн аргаар сонгож хамруулсан бөгөөд түүврийн үндсэн нэгж нь өрхийн насанд хүрсэн гишүүн болно. Судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан хэрэглэсэн.

Тоон судалгааг хийхдээ асуумжийн аргаар Кобо аппликейшныг ашиглан мэдээллийг цуглуулсан ба асуумж нь өрхийн нийгэм, эдийн засгийн мэдээлэл, хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны өнөөгийн байдлыг үнэлэх агуулгатай 3 бүлэг, 60 асуулттай. Хавсралт 1-ээс асуумжийг харна уу.

Чанарын судалгааг хийхдээ фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээллийг цуглуулсан ба 3 бүлгийг оролцуулсан. Үүнд:

- Фокус бүлгийн ярилцлагыг өрхийн хөдөлмөр эрхэлдэг, хөдөлмөр эрхэлдэггүй боловч ажил идэвхтэй хайдаг болон ажил хайдаггүй гэсэн бүлгүүдээр зохион байгуулж, нийт 15 оролцогчийг хамруулав (Хавсралт 2-оос фокус бүлгийн ярилцлагын асуултыг харна уу).
- Экспертийн ярилцлагад олон улсын байгууллага, дүүрэг, хороо, ТББ-ын хөдөлмөр эрхлэлт, халамжийн талбарт ажиллаж буй 12 экспертийг сонгон оролцуулав (Хавсралт 3-аас экспертийн ярилцлагын асуумжийг харна уу).
- Ганцаарчилсан ярилцлагад ХТДҮҮ-нд хамрагддаг 5 оролцогчийг судалгааны үр дүнг сайжруулах, баталгаажуулах, тодруулах зорилгоор сонгон оролцуулсан болно.

Судалгааны мэдээллийн боловсруулалтад SPSS, Excel, Eviews програмуудыг ашигласан ба тодорхойлогч болон дүгнэлтийн статистикууд, эконометрикийн загварууд тодорхойлсноор тархалт болон нөлөөллийг үнэлж, дүгнэсэн. “Түүвэр судалгааны үр дүн” бүлгээс дэлгэрэнгүйг харна уу. Мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт ба чанарын хяналтын явцын үр дүнг Хавсралт 4-өөс үзнэ үү.

Түүвэрлэлт


ХНХЯ-ны судалгаагаар 2023 оны 6 сарын байдлаар нийслэлийн хэмжээнд ХТДҮҮ-нд 68,609 иргэн хамрагдаж байна. Түүврийн найдвартай

байдлыг 95 хувийн магадлалтайгаар алдааны хязгаарыг 5 хувь байхаар түүврийн хэмжээг тооцоход 381 иргэн судалгаанд хамрагдах үр дүн гарсан. Түүвэрт хамрагдах 381 иргэний тоог дүүрэг бүрт дараах байдлаар харгалзуулсан. Үүнд:

а) Дүүргийн нийт хүн амд хөдөлмөрийн насны иргэдийн эзлэх хувьд тулгуурлан ХТДҮҮ-нд хамрагддаг иргэдийн тооноос хөдөлмөрийн насны иргэдийн тоог ялгасан.

б) Дүүрэг бүрийн ХТДҮҮ-нд хамрагддаг, хөдөлмөрийн насны иргэдийн эзлэх хувьд харгалзуулан 381 иргэнийг хуваасан. Мэдээлэл цуглуулалтын явцтай холбогдуулан сүүлийн өдрүүдэд Сонгинохайрхан, Баянзүрх, Налайх дүүргээс бусад дүүрэгт цөөн иргэнийг шилжүүлсэн¹¹.

Зураг 10. Судалгааны эх олонлог




Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын статистик-2022, www.1212.mn

11 Өрхийг шилжүүлэхэд нөлөөлсөн хүчин зүйлс:

- Багахангай дүүргийн өрхийн тоо судалгааны дүгнэлт хийхэд хэт цөөн байсан.
- Сонгинохайрхан дүүргийн 26-р хороо ажлын байрандаа засвар хийж байсан тул богино хугацаанд мэдээлэл цуглуулах шаардлагатай болсон.
- Мэдээлэл цуглуулалтын хугацаанд үерийн нөхцөл байдлын улмаас Баянзүрх дүүргийн 27-р хороонд ажиллах боломжгүй болсон тул 35-р хороогоор сольсон.
- Сонгинохайрхан, Баянзүрх, Налайх дүүргээс хасагдсан тоог бусад дүүрэгт түүвэрт эзлэх хувийн жинг хадгалан нэмж өгсөн.

Зураг 11. Дүүрэг тус бүрээс хамрагдсан түүврийн хэмжээ



Улаанбаатар хот 9 дүүрэг 204¹² хороотой. Судалгаанд хамрагдах иргэдийг сонгохдоо 381 иргэн өөрийн өрхийг төлөөлнө гэж үзээд 381 өрхийг сонгох зорилго тавьсан. ХТДҮҮ-нд хамрагддаг өрх олонтой дүүрэг болох Сонгинохайрхан дүүргийг 3, Баянзүрх дүүргийг 2 кластер, бусад дүүргийг 1 кластер болгон, нийт 12 кластер үүсгэсэн. Кластер бүрээс 25 болон түүнээс дээш тооны өрх нь ХТДҮҮ хөтөлбөрт хамрагддаг 1 хороог сонгосон ба энэ нь олон шатлалт түүвэрлэлтийн арга зүйд тулгуурласан сонголт юм. Хүснэгт 4-т сонгогдсон хорооны дугаар, байршил, ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн тоог харуулсан. Баянзүрх дүүргийн 27-р хороо сонгогдсон байсан боловч үерийн нөхцөл байдлаас шалтгаалан өрхийн гишүүдийг судалгаанд хамруулах боломжгүй болсон тул 35-р хорооны иргэдийг судалгаанд хамруулсан. Хорооны байршлын зураглалыг Хавсралт 5-аас харна уу.

Хүснэгт 4. Өрхийн тоо, дүүрэг, хороогоор

Дүүрэг	Хамрагдсан хорооны дугаар	Байршил, хамрагддаг хэсгүүд	ХТДҮҮ-нд хамрагдсан өрхийн тоо
Багануур	4	Багануур	92
Багахангай	1	Багахангай	26
Баянгол	23	3-р хорооллын арын гэр хороолол	36
Баянзүрх	23	Улиастай	190
	35	Улиастайн шинэ эцэс	152
Налайх	1	Налайх	77

12 Эх үүсвэр: www.ubstat.mn

Дүүрэг	Хамрагдсан хорооны дугаар	Байршил, хамрагддаг хэсгүүд	ХТДҮҮ-нд хамрагдсан өрхийн тоо
Сонгинохайрхан	26	Их наран	572
	22	Баруун салаа	462
	7	Баянхошуу	333
Сүхбаатар	16	Дамбадаржаа	118
Хан-Уул	8	Яармаг	116
Чингэлтэй	16	Хайлааст	189

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Хэдийгээр 381 хөдөлмөрийн насны иргэнийг судалгаанд хамруулах тооцоолол гарсан ч тухайн сонгогдсон иргэн өрхөө төлөөлж чадах тул өрхийн хөдөлмөрийн насны 1-5 гишүүний (6, 7 дахь гишүүний мэдээллийг хассан) хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг цуглуулах боломж бүрдэж, хөдөлмөрийн насны 1,063 иргэний мэдээллийг цуглуулсан. Энэ нь ХТДҮҮ-нд хамрагддаг 68,609 иргэний 0.56 хувийг судалгаанд хамруулах байсныг 1.55 хувь болгож, түүврийн хэмжээг нэмэгдүүлсэн.

Хөдөлмөрийн насны иргэдийг насны ангилал тус бүрт эх олонлогийн насны тархалттай ойролцоо хувиар хамруулсан ба Хүснэгт 5.-д 2023 оны 2-р улирлын байдлаар ХТДҮҮ-нд хамрагдсан, 15-60 насны иргэдийн насны ангилал тутамд харгалзах эх олонлогт эзлэх хувь болон түүвэрт эзэлсэн хувийг харуулав.

Хүснэгт 5. Хөдөлмөрийн насны гишүүний эзлэх хувь, насны ангиллаар

Үзүүлэлт	15-24 нас	25-34 нас	35-44 нас	45-55 нас	56-60 нас
Эх олонлогт эзлэх хувь	42.2%	15.2%	22.6%	16.4%	3.6%
Түүвэрт эзлэх хувь	32.8%	16.4%	28.1%	19.1%	3.6%

Эх сурвалж: www.mlsp.gov.mn

ХТДҮҮ-нд хамрагдсан иргэдийн мэдээлэл (dashboard), 2023 оны 9 дүгээр сар

2.1. Өрхийн нийгмийн үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал

2016 онд баталсан “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал”-аар өрхийн амьжиргааг 13 бүлгийн 100 гаруй үзүүлэлтээр тодорхойлдог бөгөөд ам бүлийн тоо, ам бүлийн бүтэц, хөгжлийн бэрхшээл, өрхийн тэргүүний боловсрол, ажил эрхлэлт, сууцны төрөл, өмчлөл, үйлчилгээ, газар эзэмшил зэрэг нь голлох үзүүлэлтүүд юм. Уг аргачлалыг 2023 онд шинэчлэн боловсруулж, “Орлогыг

орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал” нэрээр баталжээ.


Энэхүү тайланд ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн нийгэм, эдийн засгийн байдал, орлогын бүтэц болон мөнгөн тэтгэмжийн өрхийн орлогод эзлэх хувь нэмрийг өрхийн тэргүүний нас, өрх толгойлсон байдал, амьдарч буй нөхцөл, гишүүдийн бүтэц, хөдөлмөр эрхэлж буй гишүүдээр нь ялган тодорхойлох судалгааны зорилгын хүрээнд судалгаанд хамрагдсан өрхүүдийн дараах нийгмийн үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэв. Эдгээр нь ам бүлийн тоо, өрхийн бүтэц, өрхийн тэргүүний шинж чанар, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй эсэх, оршин суугаа газрын эзэмшлийн хэлбэр зэрэг болно. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн ам бүлийн тоо дунджаар 6 байсан бөгөөд эдгээр өрх хамгийн багадаа 2, хамгийн ихдээ 12 гишүүнтэй байна.

Өрхийн бүтцийн хувьд хамрагдсан өрхийн нийт гишүүний тоо 2249 байсан бөгөөд тэдгээрийг насны ангиллаар авч үзвэл, нийт гишүүний 47 хувь нь хүүхэд, 48 хувь нь хөдөлмөрийн насны иргэд, харин 5 хувь нь тэтгэврийн насны иргэд байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Өрхийн гишүүдийн насны ангилал, дүүргээр

Дүүрэг	0-5 настай хүүхдийн тоо	6-14 настай хүүхдийн тоо	Хөдөлмөрийн насны иргэдийн тоо	Тэтгэврийн насны иргэдийн тоо	Өрхийн нийт гишүүдийн тоо
Багануур	13 (23%)	16 (29%)	24 (43%)	3 (5%)	56 (100%)
Багахангай	3 (12%)	7 (28%)	11 (44%)	4 (16%)	25 (100%)
Баянгол	6 (9%)	25 (38%)	32 (49%)	2 (3%)	65 (100%)
Баянзүрх	55 (15%)	124 (35%)	162 (45%)	17 (5%)	356 (100%)
Налайх	9 (11%)	23 (29%)	40 (50%)	8 (10%)	80 (100%)
Сонгино- хайрхан	132 (14%)	299 (33%)	446 (49%)	41 (4%)	918 (100%)
Сүхбаатар	31 (15%)	69 (34%)	92 (46%)	9 (4%)	201 (100%)
Хан-Уул	38 (19%)	51 (26%)	99 (50%)	10 (5%)	198 (100%)
Чингэлтэй	51 (15%)	115 (33%)	166 (47%)	18 (5%)	350 (100%)
Нийт	338 (15%)	729 (32%)	1072 (48%)	112 (5%)	2251 (100%)


Зураг 12. Өрхийн тэргүүний нас



Нийт өрхийн 59.3 хувь нь эрэгтэй, 40.7 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй байна. Өрхийн тэргүүний насны ангиллын хувьд, нийт өрхийн тэргүүний 36.2 хувь нь 35-44 насны, 32 хувь нь 45-54 насны, 17.1 хувь нь тэтгэврийн насны иргэд байна.


Үүний зэрэгцээ, өрхийн тэргүүний гэрлэлтийн байдлыг авч үзвэл 45.4 хувь нь гэрлэсэн бөгөөд гэрлэлтээ батлуулсан, 15 хувь нь хамтран амьдардаг боловч гэрлэлтээ батлуулаагүй, 14.4 хувь нь огт гэрлээгүй бол үлдсэн 25.2 хувь нь бэлэвсэн, салсан болон тусдаа амьдардаг байна.

Зураг 13. Өрхийн тэргүүний гэрлэлтийн байдал



Боловсролын хувьд, нийт өрхийн тэргүүний 1.8 хувь нь дээд, 66.1 хувь бүрэн дунд боловсролтой өрхийн тэргүүн зонхилж байна.

Зураг 14. Өрхийн тэргүүний боловсрол



Судалгаанд хамрагдсан 131 өрх (нийт өрхийн 34.4 хувь) нь хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүнтэй бөгөөд эдгээр өрхийн 81 хувь нь нэг, 17.6 хувь нь хоёр, 1.5 хувь нь гурван хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй байна.

Хүснэгт 7. Өрхийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүний тоо


Хөгжлийн бэрхшээлтэй гишүүний тоо	Өрхийн тоо	Өрхийн эзлэх хувь
1	106	80.9%
2	23	17.6%
3	2	1.5%
Нийт	131	100%

Хүснэгт 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн тоо, дүүргээр

Дүүрэг	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо	Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн тоо	Дүүргийн нийт өрхөд эзлэх хувь
Багануур	4	3	37.5%
Багахангай	3	3	60.0%
Баянгол	6	5	41.7%
Баянзүрх	26	21	33.3%
Налайх	11	8	66.7%
Сонгинохайрхан	59	51	31.9%
Сүхбаатар	18	15	42.9%
Хан-Уул	15	12	38.7%
Чингэлтэй	16	13	23.6%
Нийт	158	131	34.4%

Судалгаанд хамрагдсан өрхийн 158 гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд тэдгээр иргэдэд тохиолдох тэргүүлэх бэрхшээл нь оюуны (27 хувь) болон хөдөлгөөний (23 хувь) бэрхшээл байна.

Зураг 15. Хөгжлийн бэрхшээлийн төрөл



Судалгаанд хамрагдсан 381 өрхийн 57.2 хувь нь өөрийн газарт амьдардаг бол 30.4 хувь нь хүний газар дээр үнэгүй, 8.7 хувь нь түрээсийн газарт харин үлдсэн өрхүүд нь нийтийн эзэмшлийн болон зөвшөөрөлгүй газарт амьдардаг байна.

Хүснэгт 9. Газрын эзэмшлийн хэлбэр

Үзүүлэлт	Тоо	Харгалзах хувь
Өөрийн	218	57.2%
Нийтийн эзэмшлийн	7	1.8%
Албан газрын	2	0.5%
Хүний газар, түрээсийн	33	8.7%
Хүний газар, үнэгүй	116	30.4%
Түр эзэмшлийн	1	0.3%
Зөвшөөрөлгүй	4	1.0%
Нийт	381	100%

2.2. Өрхийн хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал

ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, хөдөлмөр эрхлээгүй шалтгаан, тулгамдаж буй бэрхшээл, өнөөгийн хэрэгцээ шаардлага, иргэнд тохирох ажлын байр болон ажлын нөхцөл, өрхөд хандсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийг хүйс, насны ангилал, гишүүдийн боловсрол, мэргэжил, ажил олгогчийн статус, бусад онцлог гэсэн категориудаар ангилан дүгнэлээ. Энэ бүлэг нийт 18 асуулттай бөгөөд зарим асуултад хөдөлмөр эрхэлдэг эсэхээс үл хамааран хариулт авсан болно. Хөдөлмөр эрхэлдэг гишүүдээс ерөнхий мэдээлэл, ажил эрхлэлттэй холбоотой 8 асуултаар судалгааг авсан.

Гишүүдийн ерөнхий мэдээлэл


Түүвэрт багтсан 381 өрхөд 1063 хөдөлмөрийн насны иргэн амьдарч байна. Тэдгээрийг насны ангиллаар авч үзвэл, 15-24 насны иргэн хамгийн их буюу 32.8 хувь, 25-34 насны иргэн 16.4 хувь, 35-44 насны иргэн 28.1 хувь, 45-55 насны иргэн 19.1 хувь болон 56-60 насны иргэн 3.6 хувь тус тус байна.

Хүснэгт 10. Хөдөлмөрийн насны гишүүний тоо, нас, хүйсээр

Үзүүлэлт		15-24 нас	25-34 нас	35-44 нас	45-55 нас	56-60 нас	Нийт
Эрэгтэй	Тоо	172	69	122	92	24	479
	Эрэгтэйчүүдэд эзлэх хувь	(35.9%)	(14.4%)	(25.5%)	(19.2%)	(5.0%)	(45.1%)
Эмэгтэй	Тоо	177	105	177	111	14	584
	Эмэгтэйчүүдэд эзлэх хувь	(30.3%)	(18.0%)	(30.3%)	(19.0%)	(2.4%)	(54.9%)
Нийт	Тоо	349	174	299	203	38	1063
	Нийтэд эзлэх хувь	(32.8%)	(16.4%)	(28.1%)	(19.1%)	(3.6%)	(100%)

Хөдөлмөрийн насны иргэдийн 59.6 хувь нь бүрэн дунд; 16.8 хувь нь суурь; 7.8 хувь нь мэргэжлийн боловсролтой, харин дээд боловсролтой иргэн 6.4 хувь байна.

Зураг 16. Хөдөлмөрийн насны гишүүдийн боловсрол



Судалгаанд хамрагдсан өрхийн 18.9 хувь нь хөдөлмөр эрхэлдэг гишүүнгүй байсан бол бусад өрхийн хувьд 2-4 хөдөлмөр эрхэлдэг өрхийн гишүүнтэй байна.

Хүснэгт 11. Хөдөлмөр эрхэлдэг гишүүний тоо, дүүргээр

Дүүрэг	Үзүүлэлт	0	1	2	3	4	Нийт өрх
		гишүүн	гишүүн	гишүүн	гишүүн	гишүүн	
Багануур	тоо	0	6	2	0	0	8
	дүүргийн нийт өрхөд эзлэх %	0.0%	75.0%	25.0%	0.0%	0.0%	100.0%
Багахангай	тоо	1	2	2	0	0	5
	дүүргийн нийт өрхөд эзлэх %	20.0%	40.0%	40.0%	0.0%	0.0%	100.0%
Баянгол	тоо	2	8	2	0	0	12
	дүүргийн нийт өрхөд эзлэх %	16.7%	66.7%	16.7%	0.0%	0.0%	100.0%
Баянзүрх	тоо	22	34	7	0	0	63
	дүүргийн нийт өрхөд эзлэх %	34.9%	54.0%	11.1%	0.0%	0.0%	100.0%
Налайх	тоо	1	4	4	2	1	12
	дүүргийн нийт өрхөд эзлэх %	8.3%	33.3%	33.3%	16.7%	8.3%	100.0%
Сонгино- хайрхан	тоо	31	77	43	7	2	160
	дүүргийн нийт өрхөд эзлэх %	19.4%	48.1%	26.9%	4.4%	1.3%	100.0%
Сүхбаатар	тоо	6	16	8	3	2	35
	дүүргийн нийт өрхөд эзлэх %	17.1%	45.7%	22.9%	8.6%	5.7%	100.0%
Хан-Уул	тоо	5	13	11	2	0	31
	дүүргийн нийт өрхөд эзлэх %	16.1%	41.9%	35.5%	6.5%	0.0%	100.0%
Чингэлтэй	тоо	4	19	25	4	3	55
	дүүргийн нийт өрхөд эзлэх %	7.3%	34.5%	45.5%	7.3%	5.5%	100.0%
Нийт	тоо	72	179	104	18	8	381
	нийт өрхөд эзлэх %	18.9%	47.0%	27.3%	4.7%	2.1%	100.0%

Өрхийн хөдөлмөр эрхэлдэг гишүүдийг нас, хүйсний ангиллаар авч үзвэл дараах үр дүн гарч байна. Хөдөлмөрийн насны 1063 иргэний 41 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагийн дийлэнх нь эрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт 49.7 хувьтай байхад, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт 33.7 хувь байна. Насны хувьд, 35-44 насны ангиллын иргэдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр буюу 55.9 хувь байна.

Хүснэгт 12. Хөдөлмөр эрхлэлтийн байдал, нас, хүйсээр

Үзүүлэлт		Хөдөлмөр эрхэлсэн		Хөдөлмөр эрхлээгүй	
		Тоо	Хувиар	Тоо	Хувиар
15-24 нас	Эрэгтэй	49	28.5%	123	71.5%
	Эмэгтэй	28	15.8%	149	84.2%
	Нийт	77	22.1%	272	77.9%
25-34 нас	Эрэгтэй	52	75.4%	17	24.6%
	Эмэгтэй	36	34.3%	69	65.7%
	Нийт	88	50.6%	86	49.4%
35-44 нас	Эрэгтэй	87	71.3%	35	28.7%
	Эмэгтэй	80	45.2%	97	54.8%
	Нийт	167	55.9%	132	44.1%
45-55 нас	Эрэгтэй	44	47.8%	48	52.2%
	Эмэгтэй	52	46.8%	59	53.2%
	Нийт	96	47.3%	107	52.7%
56-60 нас	Эрэгтэй	6	25.0%	18	75.0%
	Эмэгтэй	1	7.1%	13	92.9%
	Нийт	7	18.4%	31	81.6%
Ерөнхий нийт	Эрэгтэй	238	49.7%	241	50.3%
	Эмэгтэй	197	33.7%	387	66.3%
	Нийт	435	41%	628	59%

Дүүргээр нь авч үзвэл хөдөлмөр эрхлэлт хамгийн бага байгаа нь Баянзүрх байна. Налайх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр гэсэн судалгааны үр дүн гарсан байна.

Хүснэгт 13. Хөдөлмөр эрхлэлтийн байдал, дүүргээр

Дүүрэг	Сүүлийн 1 жил хөдөлмөр эрхэлсэн гишүүн		Сүүлийн долоо хоног хөдөлмөр эрхэлсэн гишүүн	
	Тоо	Хувиар	Тоо	Хувиар
Багануур	10	41.7%	8	33.3%
Багахангай	6	46.2%	4	30.8%
Баянгол	12	37.5%	12	37.5%
Баянзүрх	48	31.6%	47	30.9%
Налайх	22	55.0%	19	47.5%
Сонгинохайрхан	192	43.4%	180	40.7%
Сүхбаатар	49	53.3%	40	43.5%
Хан-Уул	41	41.8%	37	37.8%
Чингэлтэй	93	54.7%	89	52.4%
Нийт	473	44.5%	435	40.9%

Хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 60 хувь нь байнгын ажлын байртай бол, үлдсэн өрхүүдийн хувьд улирлын чанартай түр ажилладаг, мөн цалин хөлстэй тохиолдлын ажилтан болон дадлагажигч хийдэг байна.

Зураг 17. Ажиллах хэлбэр



Хөдөлмөр эрхлэгч өрхийн гишүүдийн ажил олгогчийн 50 хувь нь компани, 22 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч бөгөөд үлдсэн нь бусад төрлийн хариуцлагын хэлбэртэй байгууллагад ажилладаг байна.

Зураг 18. Ажил олгогчийн хариуцлагын хэлбэр




Дээрх иргэдийн эрхэлж буй ажил, мэргэжлийн дийлэнх нь ур чадвар бага шаардах энгийн ажил, үйлдвэрлэлийн болон худалдаа, үйлчилгээний ажил байна.

Зураг 19. Эрхэлж буй ажлын ангилал



Харин эрхэлж буй ажлын салбарын хувьд, барилга болон үйлчилгээний салбарын ажил зонхилж байна.

Зураг 20. Эрхэлж буй ажлын салбар



Хөдөлмөр эрхлэгч гишүүдийн цалингийн хэмжээ сард 290,000-3,000,000 төгрөгийн хооронд байгаа бөгөөд дундаж цалингийн хэмжээ 946,078₮ байна.

Хүснэгт 14. Судалгаанд хамрагдагсдын цалингийн хэмжээ, төгрөгөөр

Дүүрэг	Хүний тоо	Доод	Дээд	Дундаж	Вариацийн коэффициент
Багануур	8	537,000	900,000	692,125	15.5%
Багахангай	4	700,000	1,500,000	925,000	41.5%
Баянгол	12	500,000	2,000,000	929,167	44.5%
Баянзүрх	47	420,000	1,800,000	928,511	39.7%
Налайх	19	500,000	2,000,000	931,579	45.1%
Сонгинохайрхан	180	290,000	3,000,000	914,944	50.5%
Сүхбаатар	40	300,000	3,000,000	1,256,000	69.3%
Хан-Уул	37	290,000	3,000,000	894,054	49.2%
Чингэлтэй	88	300,000	3,000,000	929,625	46.9%
Нийт	435	290,000	3,000,000	946,078	52.7%

Ажиллах цагийн хувьд долоо хоногт багадаа 8 цаг, ихдээ 96 цаг, дунджаар 51.35 цаг ажиллаж байна. Ажлын цагийн вариацийн коэффициентийн утга 20.1-34.9 хувь байна.

Хүснэгт 15. Долоо хоногийн ажлын цаг

Дүүрэг	Хүний тоо	Доод	Дээд	Дундаж	Вариацийн коэффициент
Багануур	8	9	40	36.13	30.3%
Багахангай	4	25	56	40.25	31.5%
Баянгол	12	34	80	54.67	30.3%
Баянзүрх	47	8	84	52.51	34.9%
Налайх	19	40	72	55.37	20.1%
Сонгинохайрхан	180	20	96	54.01	25.6%
Сүхбаатар	40	24	77	51.15	23.3%
Хан-Уул	37	12	70	46.38	28.2%
Чингэлтэй	88	12	70	48.05	24.6%
Нийт	435	8	96	51.35	27.4%

2.3. Өрхийн хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдийн өнөөгийн байдал

ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлээгүй шалтгаан, тулгамдаж буй бэрхшээл, өнөөгийн хэрэгцээ, шаардлага, иргэнд тохирох ажлын байр болон ажлын нөхцөл, өрхөд хандсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэв. Хөдөлмөр эрхлээгүй гишүүдээс ерөнхий мэдээлэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн

байгууллагатай холбоотой байдал, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан гэсэн 3 бүлэг, 11 асуултаар өнөөгийн байдлыг дүгнэсэн болно.

Хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдийн 49 хувь нь өмнө нь ажил хийж байсан бөгөөд одоогоор ажиллах боломжгүй байгаа, харин 2 хувь нь ажил хайж байгаа аж.

Шинээр ажил хайхдаа эдгээр иргэний 48.6 хувь нь танил, хамаатан, найз нөхдөөсөө ажил сурагладаг гэж хариулсан бол удаад нь интернэт болон зарын сониноос ажлын зар хайдаг гэж хариулжээ.

Зураг 21. Хөдөлмөр эрхэлж байсан туршлага



Өрхүүдийн хөдөлмөрийн насны гишүүдийн 72.6 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл огт төлдөггүй байна. Эдгээр иргэдийн 41 хувь нь хөдөлмөр эрхэлдэг боловч, хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 52 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлж байна.

Хүснэгт 16. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт

Үзүүлэлт	Хөдөлмөр эрхэлдэг		Хөдөлмөр эрхэлдэггүй		Бүгд	
	Тоо	Хувиар	Тоо	Хувиар	Тоо	Хувиар
Нийт цалингаасаа нийгмийн даатгал төлдөг	208	47.8%	19	3.0%	227	21.4%
Цалингийнхаа тодорхой хувиас нийгмийн даатгал төлдөг	5	1.1%	3	0.5%	8	0.8%
Хувиараа сайн дурын нийгмийн даатгал төлдөг	10	2.3%	29	4.6%	39	3.7%
Улсаас нийгмийн даатгал төлж өгдөг	3	0.7%	14	2.2%	17	1.6%
Огт төлдөггүй	209	48.0%	563	89.6%	772	72.6%
Нийт	435	100.0%	628	100.0%	1063	100.0%


Хөдөлмөрийн насны иргэдийн 9.3 хувь нь дүүрэг, хорооны дэмжлэгтэйгээр түр ажлын байранд зуучлагдсан бол 5 хувь нь байнгын ажлын байранд зуучлагдсан гэж хариулжээ.

Хүснэгт 17. Ажлын байрны зуучлал, дүүргээр

Дүүрэг	Дүүрэг, хорооны дэмжлэгтэйгээр түр ажлын байранд зуучлагдсан хүний тоо		Дүүрэг, хорооны дэмжлэгтэйгээр байнгын ажлын байранд зуучлагдсан хүний тоо	
	Тоо	Хувиар	Тоо	Хувиар
Багануур	12	50%	7	29.2%
Багахангай	3	23%	3	23.1%
Баянгол	3	9%	0	0.0%
Баянзүрх	17	11%	13	8.6%
Налайх	2	5%	0	0.0%
Сонгинохайрхан	34	8%	15	3.4%
Сүхбаатар	8	9%	3	3.3%
Хан-Уул	6	6%	3	3.1%
Чингэлтэй	14	8%	9	5.3%
Нийт	99	9.3%	53	5.0%

Хөдөлмөр эрхэлдэггүй хөдөлмөрийн насны иргэдийн ажил эрхлээгүй байгаагийн тэргүүлэх шалтгаан нь бусдыг асардаг, өөрөө эрүүл мэндийн асуудалтай мөн суралцдаг зэрэг болно.

Зураг 22. Хөдөлмөр эрхлээгүй шалтгаан, давтамжийн хувиар




Судалгаанд хамрагдагсад ихэвчлэн танил тал, хамаатан болон найз нөхдөөрөө дамжуулан ажил олдог бөгөөд интернэт болон зарын сонинг ажил олоход мөн түлхүү ашигладаг байна.

Зураг 23. Ажил олох суваг, давтамжийн хувиар



Өрхүүд тохирох ажлаа олж чадахгүй байгаа үндсэн шалтгаанд нас тохирохгүй, ажлын цаг урт, цалин бага, мэдлэг, ур чадваргүй, ажлын шаардлага өндөр зэрэг шалтгааныг дурджээ.

Зураг 24. Ажил олдохгүй байгаагийн шалтгаан, давтамжийн хувиар



Харин ажил олгогчоос тавьдаг шаардлагууд дундаас дипломгүй, англи хэлний мэдлэг сул болон ачаалалтай ажиллах боломжгүй байдал, ажилласан жил цөөн, техникийн ур чадвар доогуур байх нь ажил эрхлэхэд саад болдог гэж үзсэн байна.

Зураг 25. Ажлын байрны шаардлагад нийцэхгүй байдал, давтамжийн хувиар




Үүний зэрэгцээ, судалгаанд оролцогчдын 70.1 хувь нь төрөөс хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн талаар мэдлэг, ойлголтгүй гэж хариулсан бол үлдсэн иргэдийн хамгийн сайн мэддэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр болон хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр зэрэг байна.

Мөн өрхүүдийн 24 хувь нь орон нутгийн болон олон улсын төрийн бус байгууллагын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн төсөл хөтөлбөр, үйл ажиллагаанд хамрагддаг байна.

Түүнчлэн, өнгөрсөн нэг жилийн хугацаанд өрхүүдийн 43 хувь руу нь хороо, дүүргээс өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр холбогджээ.

Судалгаанд оролцогч өрхүүдийн 51.2 хувь нь хороо, дүүргээс хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг “оновчтой, өрхийн нөхцөлд тохиромжтой” гэж үзсэн бол, 15.2 хувь нь “зарим талаараа тохиромжтой”, харин 7.6 хувь нь “төхиромжгүй”, үлдсэн 26 хувь нь “мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн байна.

Зураг 26. Дүүрэг, хорооны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны тохиромжтой байдал, давтамж, харгалзах хувиар



Хөдөлмөр эрхлээгүй өрхийн гишүүдийн хувьд нэн тэргүүнд бага насны хүүхдээ харж ханддаг (48 хувь) тул хөдөлмөр эрхлэх боломжгүй байна. Түүнчлэн 19.2 хувь нь асаргаа шаардлагатай өрхийн гишүүнээ асардаг тул хөдөлмөр эрхлэх боломжгүй байна. Мөн нийт өрхийн 24.7 хувь нь үнэмлэх, дипломгүй тул хөдөлмөр эрхлэхэд бэрхшээлтэй тулгардгаа илэрхийлсэн бол ажлын олгогчдын шаардлага өндөр, ажлын цаг урт, цалин бага гэж үзсэн өрхүүд ч цөөнгүй байна.

Зураг 27. Хөдөлмөр эрхлэхэд өрхөд тулгамдаж буй бэрхшээл, давтамжийн хувиар



2.4. Өрхийн орлого

ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн эдийн засийн байдал, орлогын бүтэц болон мөнгөн тэтгэмжийн өрхийн орлогод эзлэх хувь нэмрийг өрхийн тэргүүний онцлог, өрхийн амьдарч буй нөхцөл, гишүүдийн бүтэц, хөдөлмөр эрхэлж буй гишүүдийн тооны ангиллаар ялган дүгнэлт өглөө.

Өрхийн орлогыг цалин хөлс, тэтгэвэр, төрөөс сар бүр болон улирал, жилд нэг удаа хүлээн авдаг тэтгэмж, хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээ, тогтмол бус буюу бусад, гадаад шилжүүлэг, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээ, бусдын дэмжлэг буюу бусдаас үнэгүй хэрэглэсэн бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээ гэсэн ангиллаар судалсан болно. Өрх сар бүр болон жилд нэг удаа нийгмийн халамжийн 5 төрлийн тэтгэвэр, 8 төрлийн тэтгэмж, 2 төрлийн халамжийн үйлчилгээ, 13 төрлийн хөгжлийн үйлчилгээ¹³ төрөөс авч байгаа бөгөөд эдгээр тэтгэвэр, тэтгэмжүүдийг өрхийн орлогын тэтгэвэр, тэтгэмжийн орлого гэсэн бүлэгт ангилж оруулсан болно. Үүнд сар бүр олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмж мөн орж тооцогдсон болно. Дээрх ангиллуудаар судалж, өрхийн орлогын бүтэц, орлогын ангиллыг тодорхойлж, орлогын дундаж, хамгийн их, хамгийн бага утга, медиан, квантил, децил, моод, вариацийн коэффициент статистик үзүүлэлтүүдийг тооцсон. Үр дүнд тулгуурлан өрхийн онцлогийг илрүүлж, харьцуулалтуудыг хийсэн болно.

2.4.1 Өрхийн орлогын бүтэц ба орлогын ангилал

Орлогын бүтцийг харвал цалин хөлсний, тэтгэмжийн, тэтгэврийн орлого нь дунджаар нийт орлогын 97 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 49 хувь нь цалин хөлсний, 36 хувь нь тэтгэмжийн, 10 хувь нь өндөр настны тэтгэврийн орлого байна. Харин хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээ буюу бизнесийн орлого нь нийт орлогын 0.6 хувийг эзэлж байна. Өөрийн аж ахуйгаас болон бусдаас үнэгүй хэрэглэсэн бүтээгдэхүүнийг үнэлж үзэхэд харгалзах нийт орлогын 1.3, 0.4 хувийг эзэлсэн байна.

13 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, төрлөөр, сар, жилээр, ҮСХ

Зураг 28. Өрхийн орлогын бүтэц, эзлэх хувиар



Өрх тухайн ангиллын орлоготой эсэхийг тооцоолж харвал өрх бүр сар тутам ямар нэг тэтгэмж хүлээн авдаг ба улирал, эсвэл жилд нэг удаа олгодог тэтгэмжийг нийт өрхийн 53 хувь нь хүлээн авсан байна. Нийт өрхийн 80.8 хувь нь цалингийн, 25.5 хувь нь тэтгэврийн, 6.3 хувь нь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн орлого олсон байна.

Багануур, Баянзүрх дүүрэгт цалингийн орлоготой өрх цөөн, Налайх дүүрэгт улирал болон жилд нэг удаа олгодог тэтгэмж авдаг өрх олон байна. Хотоос алслагдмал байршиж буй Багахангай дүүрэгт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн орлого олж буй өрх 20 хувьтай, харин Налайх, Багануур дүүрэгт 0 хувьтай байна.

Хүснэгт 18. Өрхийн орлогын ангилал, эзлэх хувиар

Өрхийн байршил	Цалин хөлсний орлоготой өрхийн эзлэх хувь	Тэтгэврийн орлоготой өрхийн эзлэх хувь	Сар бүр тэтгэмж авдаг өрхийн эзлэх хувь	Улиралд болон жилд тэтгэмж авдаг өрхийн эзлэх хувь	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлоготой өрхийн эзлэх хувь
Нийт өрх	80.8%	25.5%	100.0%	53.0%	1.6%
Багануур	100.0%	25.0%	100.0%	25.0%	0.0%
Багахангай	60.0%	40.0%	100.0%	40.0%	20.0%
Баянгол	83.3%	16.7%	100.0%	50.0%	0.0%
Баянзүрх	65.1%	23.8%	100.0%	57.1%	1.6%
Налайх	83.3%	58.3%	100.0%	83.3%	0.0%
Сонгинохайрхан	83.8%	21.3%	100.0%	48.8%	1.9%
Сүхбаатар	88.6%	31.4%	100.0%	51.4%	0.0%
Хан-Уул	74.2%	25.8%	100.0%	51.6%	0.0%
Чингэлтэй	87.3%	29.1%	100.0%	61.8%	1.8%

Нийт өрхийн 4.7 хувь нь хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлснээр орлого олж байгаа ба Баянгол, Баянзүрх, Налайх дүүрэгт уг хувь өндөр байна. Нийт өрхийн 9.4 хувь нь тогтмол бус орлого олдог ба энэ хувь Баянзүрх дүүрэгт хамгийн өндөр буюу 30.2 хувьтай байна. Нийт өрхийн 1 хувьд гадаадад ажиллаж, амьдардаг хамаарал бүхий хүнээс мөнгөн орлого шилжин ирж байна. Нийт өрхийн 12.1 хувь нь өөрийн аж ахуйгаас хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэг, 14.2 хувь нь бусдын дэмжлэг, туслалцааг хүлээн авдаг буюу бусдаас үнэгүй бүтээгдэхүүн авч хэрэглэж байна. Төвийн дүүргийн өрхүүдийн хувьд бусдын дэмжлэг, туслалцаа авдаг байдал олонтаа байна.

Хүснэгт 19. Өрхийн орлогын ангилал, эзлэх хувиар (үргэлжлэл)

Өрхийн байршил	Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлоготой өрхийн эзлэх хувь	Тогтмол бус орлоготой өрхийн эзлэх хувь	Гадаадаас шилжүүлгийн орлоготой өрхийн эзлэх хувь	Өөрийн аж ахуйгаас хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэг өрхийн эзлэх хувь	Бусдаас үнэгүй бүтээгдэхүүн хүлээн авдаг өрхийн эзлэх хувь
Нийт өрх	4.7%	9.4%	1.0%	12.1%	14.2%
Багануур	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Багахангай	0.0%	0.0%	0.0%	40.0%	0.0%
Баянгол	16.7%	0.0%	8.3%	16.7%	25.0%
Баянзүрх	12.7%	30.2%	0.0%	1.6%	4.8%
Налайх	16.7%	16.7%	8.3%	0.0%	25.0%
Сонгинохайрхан	0.6%	5.0%	0.0%	23.8%	11.3%
Сүхбаатар	0.0%	5.7%	0.0%	2.9%	20.0%
Хан-Уул	6.5%	6.5%	0.0%	0.0%	22.6%
Чингэлтэй	5.5%	5.5%	3.6%	3.6%	23.6%

2.4.2 Өрхийн орлогын статистик үзүүлэлтүүд

Судалгаанд хамрагдсан нийт өрх нь төрөөс мөнгөн тэтгэмж хүлээн авагч өрх бөгөөд өрхийн онцлогоос хамааран цалин хөлс, тэтгэвэр, тогтмол бус орлого, улирал, жилд нэг удаа төрөөс хүлээн авдаг мөнгөн тэтгэмж, хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээнээс олдог орлого, гадаадад ажиллаж буй өрхийн хамаарал бүхий гишүүнээс шилжин ирдэг орлого, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнс болон бусдаас үнэгүй хэрэглэсэн бүтээгдэхүүн зэрэг нь тухайн өрхийн орлогын тодорхой хэсэг болохгүй тул эдгээр үзүүлэлтийн хувьд дундаж болон вариацийн коэффициентийг тооцож дүгнэсэн.

Зураг 29. Өрхийн орлогын дундаж, төгрөгөөр



Нийт өрхийн хувьд тооцоолсон цалин хөлсний орлого дунджаар 976,199.5, ахмадуудын тэтгэврийн хэмжээ дунджаар 177,841.3, улирал болон жилд нэг удаа авдаг мөнгөн тэтгэмжийн дундаж 223,021 төгрөг байна.

Хүснэгт 20. Өрхийн орлогын статистик үзүүлэлтүүд, төгрөгөөр

Статистик үзүүлэлтүүд	Сар бүрийн тэтгэмжийн орлого	Нийт орлого	Өрхийн нэг гишүүнд ногдох орлого	Сар тутмын нийт мөнгөн тэтгэмжийн орлого	Нийт орлогод сарын мөнгөн тэтгэмжийн эзлэх хувь	
Дундаж	513,766.93	1,734,667	313,586	532,352	36.3	
Медиан	468,000	1,604,333	299,278	488,000	28.3	
Моод	464,000	1,428,333	85,000	472,333	100.0	
Вариацийн коэффициент	52%	44.8%	48%	52%	67%	
Хамгийн бага утга	24,000	89,333	14,889	32,000	2.1	
Хамгийн их утга	1,722,000	5,286,667	1,255,750	1,772,000	100.0	
Перцентиль	10	198,400	843,200	149,689	200,000	13.9
	20	288,000	1,121,833	197,867	296,133	18.3
	25	337,000	1,186,833	213,333	340,000	19.5
	30	364,000	1,270,300	231,060	377,133	21.4
	40	400,000	1,453,733	259,968	426,000	24.5
	50	468,000	1,604,333	299,278	488,000	28.3
Перцентиль	60	531,800	1,824,500	322,480	572,333	34.5
	70	616,400	2,023,833	355,107	637,200	41.4
	75	658,000	2,141,667	371,125	692,000	46.4
	80	716,200	2,276,600	391,173	740,000	50.4
	90	868,800	2,742,067	490,213	900,000	67.5

Өрхүүд сар бүр багадаа 24,000 төгрөг, ихдээ 1,722,000 төгрөг, дунджаар 513,766.9 төгрөгийн тэтгэмжийг төрөөс хүлээн авч байна. Нийт өрхийн 20 хувь нь 24,000-аас 288,000 төгрөгийн, 20 хувь нь 716,200-1,722,000 төгрөгийн тэтгэмжтэй байна. Харин сарын нийт мөнгөн тэтгэмжийн хэмжээ дунджаар 532,352 төгрөг байгаа ба 32,000-1,772,000 төгрөг байна. Өрх толгойлсон, олон хүүхэдтэй эцэг, эхчүүд улирал тутам 550,000 төгрөгийн тэтгэмжийг авч байна. Өндөр тэтгэмж бүхий 10 хувьд харгалзах 38 өрх жилд 868,800-1,722,000 төгрөгийн тэтгэмжтэй байна.

Өрхийн сарын нийт орлого дунджаар 1,734,667 төгрөг, медиан утга 1,604,333 төгрөг буюу нийт өрхийн тал хувь нь медиан утгаас бага орлоготой, үлдэх тал хувь нь медиан утгаас өндөр орлоготой байна. Нийт орлого 89,333 төгрөгөөс 5,286,667 төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа ба вариацийн коэффициент 44.8 хувь гарсан нь өрхүүдийн орлогын

хэмжээ ялгаа ихтэй болохыг илтгэж байна. Өрхийн бага орлого бүхий 10 хувь нь 843,200 төгрөгөөс доош, өндөр орлого бүхий 10 хувь нь 2,742,067 төгрөгөөс, өндөр орлого бүхий 20 хувь нь 2,276,600.0 төгрөгөөс дээш орлоготой байна.

Өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлогыг авч үзвэл дундаж 313,586, медиан 299,1278 төгрөг, моод 85,000, хамгийн бага утга 14,889, хамгийн их утга 1,255,750 төгрөг байна. Өрхийн нэг гишүүнд ногдох орлого багатай 10 хувь нь 149,689 төгрөгөөс доош, өндөр ногдох орлого бүхий 10 хувь нь 490,213 төгрөгөөс дээш өрхийн нэг гишүүнд ногдох орлоготой байна.

Өрх бүр сар тутмын нийт мөнгөн тэтгэмжийг хүлээн авч байгаа бөгөөд дунджаар сард 532,352 төгрөгийг хүлээн авч байна. Нийт өрхийн 50 хувь нь сард 488,000-аас доош, үлдэх 50 хувь нь 488,000-аас дээш төгрөгийн тэтгэмжийн орлоготой байна.

Өрхийн сарын мөнгөн тэтгэмжийн орлогын нийт орлогод эзлэх дундаж хувь 36.3 хувь байна. Нийт өрхийн тал хувьд мөнгөн тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь 30.3 хувь хүртэл, үлдэх тал хувьд уг хувь 30.3 хувиас дээш байна. Нийт өрхийн тэтгэмжийн орлого багатай 25 хувийн сарын мөнгөн тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь нь 0.94-19.5 хувь, тэтгэмжийн орлого өндөртэй 25 хувийн сарын мөнгөн тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь нь 46.4 хувиас дээш утгатай байна. Нийт өрхийн тэтгэмжээс бусад орлого багатай 10 хувьд сарын мөнгөн тэтгэмжийн орлого нь нийт орлогын 67.5-100 хувийг бүрдүүлж байна.

Цалингийн орлого, үйлдвэрлэл, үйлчилгээний зэрэг орлоготой онцлог өрхийг ялган тооцоолсон статистикуудыг доор хүснэгтээр харуулж, дүгнэсэн.

Хүснэгт 21. Өрхийн орлогын статистик үзүүлэлтүүд (үргэлжлэл)

Статистик үзүүлэлтүүд		Цалин хөлсний орлого	Тэтгэврийн орлого	Улиралд болон жилд авдаг тэтгэмжийн орлого	Тогтмол бус орлого
Дундаж		1,207,571	693,031	420,649	1,894,777.78
Медиан		1,000,000	550,000	100,000	816,000.00
Моод		800,000	550,000	100,000	100,000
Вариацийн коэффициент		54%	43%	140%	132%
Хамгийн бага утга		200,000	325,000	50,000	20,000
Хамгийн их утга		4,200,000	1,540,000	2,400,000	10,000,000
Перцентиль	10	548,700	440,000	100,000	100,000
	20	700,000	500,000	100,000	290,000
	25	700,000	540,000	100,000	370,000
	30	800,000	550,000	100,000	455,000
	40	900,000	550,000	100,000	595,200
	50	1,000,000	550,000	100,000	816,000
	60	1,250,000	550,000	200,000	1,068,000
	70	1,500,000	680,000	300,000	2,000,000
	75	1,500,000	880,000	370,750	2,300,000
	80	1,600,000	1,000,000	600,000	3,000,000
90	2,006,500	1,100,000	1,650,000	6,720,000	

Цалингийн орлоготой өрхүүдийн цалингийн орлого дунджаар 1,207,571 төгрөг ба ажиллаж буй гишүүдийн тал хувь нь 1,000,000 төгрөгөөс дээш, үлдэх 50 хувь нь 1,000,000-аас доош төгрөгийн цалинтай байна. Хамгийн бага цалинтай 10 хувь нь 200,000-548,700 төгрөгийн цалин авдаг бол өндөр цалин авдаг 10 хувь нь 2,006,500-4,200,000 төгрөгийн цалинтай байна.

Ахмадуудын тэтгэврийн хэмжээ 325,000-аас 1,540,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа ба дунджаар 693,031 төгрөг байна. Ахмадуудын хагас хувь нь 550,000 хүртэл, үлдэх 50 хувь нь 550,000-аас дээш төгрөгийн тэтгэвэртэй, бага тэтгэвэр бүхий 10 хувь нь 325,000-440,000 төгрөгийн, өндөр тэтгэвэр бүхий 10 хувь нь 1,100,000-1,540,000 төгрөгийн тэтгэвэр авч байна.

Тогтмол бус орлого буюу түр орлого олж байгаа өрхүүдийн хувьд орлогын дундаж нь 1,894,778 төгрөг, эдгээр өрхийн 60 хувь нь 20,000-1,068,000 төгрөгийн, үлдэх 40 хувь нь 1,068,000-10,000,000 төгрөгийн,

өндөр орлого олсон 10 хувь болох 38 өрх нь 6,720,000-10,000,000 төгрөгийн орлого олж байна.

Дээрх орлогуудын вариацийн коэффициентийн доод утга 43 хувь, дээд утга 140 хувь байгаа нь аль ч орлогын хэмжээ ялгаа ихтэй байгааг харуулж байна.

Хүснэгт 22. Өрхийн орлогын статистик үзүүлэлтүүд, төгрөгөөр (үргэлжлэл)

Статистик үзүүлэлтүүд	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Гадаад шилжүүлгийн орлого	Өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний үнэлгээ	Дэмжлэг, тусалцаа	
Дундаж	2,066,667	2,000,000	1,650,000	616,174	382,370	
Медиан	1,750,000	1,000,000	1,250,000	500,000	200,000	
Моод		1,000,000		1,000,000	200,000	
Вариацийн коэффициент	95.9%	168.9%	101.2%	76.3%	109.9%	
Хамгийн бага утга	100,000	50,000	100,000	14,000	14,000	
Хамгийн их утга	5,000,000	12,000,000	4,000,000	1,500,000	2,000,000	
Перцентиль	10	100,000	50,000	100,000	70,000	100,000
	20	140,000	200,000	100,000	164,000	110,000
	25	175,000	275,000	325,000	200,000	180,000
	30	280,000	300,000	550,000	220,000	190,000
	40	840,000	520,000	1,000,000	384,000	200,000
	50	1,750,000	1,000,000	1,250,000	500,000	200,000
	60	2,720,000	1,080,000	1,500,000	667,200	300,000
	70	3,490,000	1,290,000	2,750,000	1,000,000	350,000
	75	3,950,000	1,625,000	3,375,000	1,000,000	500,000
	80	4,440,000	2,200,000		1,040,000	500,000
90		10,200,000		1,380,000	1,000,000	

Өрхийн хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого бүхий 24 өрхийн тус орлогын хэмжээ харгалзан 100,000-5,000,000, 50,000-12,000,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа ба орлогын дундаж харгалзах дүн 2,066,667 ба 2,000,000 төгрөг байна. Нийт өрхийн 50 хувийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого

100,000-1,750,000 төгрөг, үлдэх 50 хувийн тус орлого 1,750,000-5,000,000 төгрөг байгаа нь бага орлоготой өрх олон болохыг харуулж байна.

Орлогын бүтцэд нь гадаад шилжүүлгийн орлого тооцогдож буй 4 өрхийн хувьд жилийн хугацаанд 100,000-4,000,000 төгрөгийг гадаад шилжүүлгээр хүлээн авдаг.

Өөрийн аж ахуйгаас хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэг өрхүүдийн жилийн хэрэглээний дундаж үнэлгээ 616,174 төгрөг ба 14,000-1,500,000 төгрөгийн бүтээгдэхүүн хэрэглэсэн байна.

Харин бусдын дэмжлэг, туслалцаа буюу үнэгүй хэрэглэсэн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэлгээ нь 382,370 төгрөг ба эдгээр өрхийн тал хувь нь 14,000-200,000 төгрөгийн, үлдэх тал хувь нь 200,000-2,000,000 төгрөгийн дэмжлэг туслалцааг хүлээн авч байна.


Хүснэгт 22.-д харуулсан орлогуудын вариацийн коэффициент 76-169 хувийн хооронд утгатай байгаа нь өрхүүдийн дурдсан орлогын хэмжээ ялгаа ихтэй байгааг харуулж байна.

2.5 Хамаарлын шинжилгээ

2.5.1 Онцлог өрхүүдийн орлогын харьцуулалтын үр дүн

Орлогын хэлбэр бүрийн хувьд өрхийн байршил, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй эсэх, ажил эрхэлдэг гишүүний тоо, өрх толгойлсон байдал, амьдарч буй газрын эзэмшлийн хэлбэр, өрхийн тэргүүний хүйс, нас, ажил эрхлэлт зэрэг өрхийн онцлогууд орлогын хэмжээнд нөлөөтэй эсэхийг вариацийн шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, орлогын хэмжээнд нөлөөтэй болон нөлөөгүй үзүүлэлтүүдийг ялган харуулсан. Дунджийн харьцуулалтын вариацийн шинжилгээний үр дүнг Хавсралт 7.-оос харна уу.

Зураг 30. Өрхийн орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, дүүргээр



Өрхийн сар бүрийн тэтгэмж, нийт орлого нь дүүргийн байршил, онцлогоос хамааран ялгаатай байна. Өрхийн сар бүр төрөөс хүлээн авч буй тэтгэмж Сүхбаатар дүүрэгт хамгийн бага, Баянгол дүүрэгт хамгийн их байна. Нийт орлого дунджаар Багануур дүүрэгт хамгийн бага, Налайх дүүрэгт хамгийн их хэмжээтэй байна. Налайх дүүргийн өрхүүдэд цалингийн, тэтгэврийн болон тэтгэмжийн орлоготой өрх олон байсан нь нийт орлого өндөр, Багануур дүүргийн өрхүүд цалингийн орлоготой боловч тэтгэвэр, тэтгэмжийн орлоготой өрх цөөн байсан нь бага орлоготой байхад нөлөөлсөн байна.

Өрхийн цалин хөлсний орлого, улирал, жилд нэг удаа хүлээн авдаг тэтгэмж, нийт орлого, нийт тэтгэмжийн орлогод эзлэх хувь нь өрх толгойлсон эсэхээс хамааран ялгаатай байна. Өрх толгойлсон эцэг, эхтэй өрхийн тэтгэмж, нийт мөнгөн тэтгэмжийн хэмжээ хамтын амьдралтай өрхийнхөөс өндөр, хамтын амьдралтай өрхийн цалин, хөлсний болон нийт орлого, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний үнэлгээ нь өрх толгойлсон эцэг, эхтэй өрхийнхөөс өндөр байна. Харин мөнгөн тэтгэмжийн орлогод эзлэх хувь өрх толгойлсон эцэг, эхтэй өрхөд өндөр байна.

Хүснэгт 23. Өрхийн орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, өрх толгойлсон байдлаар

Өрхийн онцлог	Цалин хөлсний орлого	Өрхийн тэтгэмж /жилд 1 удаа/	Өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн бүтээгдэхүүний үнэлгээ	Нийт орлого	Нийт орлогод мөнгөн тэтгэмжийн эзлэх хувь
Нийт өрх	976,199	223,021	39,587	1,734,667	36.3
Өрх толгойлсон эцэг, эхтэй	765,156	378,813	21,354	1,533,986	41.9
Хамтын амьдралтай	1,047,288	170,544	46,267	1,802,265	34.4

Өрхийн цалин хөлсний орлого, сар бүр хүлээн авдаг тэтгэмж, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнс, сарын нийт мөнгөн тэтгэмж, нэг гишүүнд ногдох орлого, мөнгөн тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого нь өрх хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй эсэхээс хамааран ялгаатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн тэтгэмж, тэтгэмжийн орлогод эзлэх хувь өндөр, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнгүй өрх хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлоготой бөгөөд нэг гишүүнд ногдох орлого өндөртэй байна.

Хүснэгт 24. Орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй байдлаар

Өрхийн онцлог	Цалин хөлсний орлого	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн бүтээгдэхүүний үнэлгээ	Өрхийн нэг гишүүнд ногдох орлого	Мөнгөн тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь
Нийт өрх	976,199	32,546	39,587	313,586	36.3
Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй	861,084	0	9,307	340,247	43.1
Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнгүй	1,036,520	49,600	56,234	299,615	32.7

Өрхийн ажил эрхэлдэг гишүүний тооноос хамааран цалин хөлс, тогтмол бус орлого, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний

бүтээгдэхүүний үнэлгээ, нийт орлого, нэг гишүүнд ногдох орлого, мөнгөн тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь ялгаатай байна. Нэгээс дээш тооны гишүүн нь ажил эрхэлдэг бол өрхийн цалин хөлсний, нийт, нэг гишүүнд ногдох орлого нийт өрхийн дунджаас өндөр байна.

Хүснэгт 25. Орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, ажил эрхэлдэг гишүүний тоогоор

Өрхийн онцлог	Цалин хөлсний орлого	Нийт орлого	Өрхийн нэг гишүүнд ногдох орлого	Нийт орлогод мөнгөн тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь
Нийт өрх	976,199	1,734,667	313,586	36.3
Ажил эрхэлдэг гишүүнгүй	201,024	1,112,257	225,320	61.1
Ажил эрхэлдэг 1 гишүүнтэй	887,000	1,628,177	315,506	33.3
Ажил эрхэлдэг 2 гишүүнтэй	1,547,701	2,209,268	369,205	23.6
Ажил эрхэлдэг 3 гишүүнтэй	1,965,000	2,689,421	383,268	21.7
Ажил эрхэлдэг 4 гишүүнтэй	3,587,500	4,266,417	480,251	13.2


Өрхийн тэргүүний ажил эрхлэлт нь цалин хөлс, тогтмол бус орлого, нийт болон өрхийн нэг гишүүнд ногдох орлого, нийт орлогод мөнгөн тэтгэмжийн эзлэх хувьд нөлөөтэй байна. Өрхийн тэргүүн ажил эрхэлдэг бол цалин хөлс, нийт, нэг гишүүнд ногдох болон тогтмол бус орлого өрхийн тэргүүн ажил эрхэлдэггүй өрхийнхөөс өндөр байна. Мөн өрхийн тэргүүн ажил эрхэлдэггүй бол тэтгэмжийн эзлэх хувь өндөр байна.

Хүснэгт 26. Өрхийн орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, өрхийн тэргүүний ажил эрхлэлтээр

Өрхийн онцлог	Цалин хөлсний орлого	Тогтмол бус орлого /жилээр/	Нийт орлого	Өрхийн нэг гишүүнд ногдох орлого	Нийт орлогод мөнгөн тэтгэмжийн эзлэх хувь
Нийт өрх	976,199	179,034	1,734,667	313,586	36.3
Өрхийн тэргүүн ажил эрхэлдэг	1,281,861	68,656	1,925,382	339,176	30.1
Өрхийн тэргүүн ажил эрхэлдэггүй	666,103	368,279	1,413,019	267,301	47.3

Өрхийн цалин хөлс, улирал, жилд нэг удаа хүлээн авдаг тэтгэмж, нийт орлого болон сарын мөнгөн тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь нь өрхийн тэргүүний хүйсээс хамааран ялгаатай байна. Эрэгтэй тэргүүнтэй өрхийн хувьд цалин хөлсний болон нийт орлого нь өндөр, эмэгтэй тэргүүнтэй өрхийн тэтгэмжийн орлого болон нийт орлогод мөнгөн тэтгэмжийн эзлэх хувь өндөр байна.

Зураг 31. Өрхийн орлого, тэтгэмжийн харьцуулалт, төгрөгөөр, өрхийн тэргүүний хүйсээр



Өрхийн өөрийн эрхэлдэг үйлдвэрлэл, үйлчилгээний орлого нь дүүргийн байршил, өрхийн тэргүүний хүйс, өрхийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй, өрх толгойлсон, ажил эрхэлдэг гишүүнтэй эсэхээс хамаарах ялгаагүй байна. Газрын эзэмшлийн хэлбэр болон өрхийн тэргүүний нас нь аль ч орлогын хэмжээнд нөлөө үзүүлэхгүй байна. Үр дүнг Хавсралт 5-аас харна уу.

2.5.2. Регрессийн шинжилгээний үр дүн

Санзидур Рахман¹⁴, Ву Ти Кюн Чи, Тай Ти Тай Нгуен¹⁵ нарын судлаачид өрхийн хүн ам зүй, эдийн засгийн онцлог нь өрхийн орлогод нөлөөлж байна гэж дүгнэжээ. “Орлого орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал”-ыг 2022, 2023 онд шинэчлэн боловсруулж иргэдийг ХТДҮҮ-нд хамруулж байгаа

14 Sanzidur Rahman, Factors Influencing Household Income in Poor Urban Slum Settlements in Bangladesh, Journal of Poverty Alleviation and International Development, 8(2)

15 Vu Thi Quynh Chi and Thai Thi Thai Nguyen, Analysis of the Factors Affecting the Household Income of Ethnic Groups in VoNhai District, Thai Nguyen Province, European Journal of Development Studies, 2023

бөгөөд аргачлалд өрхийн шинж чанар голлох хүчин зүйл болдог. Энэ нь зорилтот бүлгийн өрхөд чиглэсэн нийгэм, эдийн засгийн арга хэмжээг зохистой тодорхойлоход чухал ач холбогдолтой. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн нийт орлогод өрхийн шинж чанар хэрхэн нөлөөлж буйг регрессийн загварчлалын аргаар тодорхойлох зорилготойгоор дараах шинжилгээнүүдийг хийж дүгнэсэн болно. Үүнд, өрхийн нийт орлого, нийт орлогын өөрчлөлт болон хөдөлмөрийн насны гишүүний ажил эрхлэх эсэхэд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлж, дүгнэсэн.

а) Өрхийн сарын нийт орлогын хэмжээнд нөлөөлөгч хүчин зүйлсийн шугаман загвар

Хүснэгт 27. Өрхийн сарын нийт орлогын хэмжээнд нөлөөлөгч хүчин зүйлсийн шугаман загварын үнэлгээний үр дүн

Хувьсагчууд	Тэмдэглэгээ	Үнэлэгдсэн коэффициент	t-ажиглалтын утга	prob
Сарын нийт орлого	NO			
Сул гишүүн		509,136.9	(3.59)	0.0004
Бага насны (0-5 нас) хүүхдийн тоо	HUUN	142,875.9	(7.91)	0.0000
Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхэлж буй гишүүний тоо	ET	933,017.2	(19.3)	0.0000
Тэтгэврийн насны гишүүний тоо	TET	468,065.7	(6.11)	0.0000
NO=509,136.9+142,875.9HUUN+933,017.2ET+458,065.7TETT00+u				
R²=0.52 F_{statistic}=136.22 F(Prob)=0.0000				

Өрхийн сарын нийт орлогыг тайлбарлагдагч хувьсагчаар авч шугаман загвараар үнэлэхэд бага насны (0-5 нас) хүүхдийн тоо, сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхэлж буй гишүүний тоо, тэтгэврийн насны гишүүний тоо гэсэн хүчин зүйлүүдийн үнэлэгдсэн коэффициент 95 хувийн итгэх түвшинд ач холбогдолтой гарч, өрхийн ам бүлийн тоо, 9-14 насны хүүхдийн тоо, дүүргийн байршил, хөдөлмөрийн насны гишүүний тоо, газрын эзэмшлийн хэлбэр, гэрлэлтийн байдал, өрх толгойлсон байдал, өрхийн тэргүүний нас, хүйс, ажил эрхлэлт, боловсрол, өөрийн аж ахуйгаас болон бусдаас үнэгүй хэрэглэсэн бүтээгдэхүүний үнэ, үйлдвэрлэл, үйлчилгээний орлого гэсэн үзүүлэлтүүдийн коэффициент ач холбогдолгүй гарсан учир эдгээр үзүүлэлтийг загвараас хасаж үнэлгээг хийсэн болно.

Регрессийн шугаман загварчлалын үр дүнд өрхийн нийт орлогын хэмжээнд бага насны (0-5 нас) хүүхдийн тоо, хөдөлмөр эрхэлж буй

гишүүний тоо, тэтгэврийн насны гишүүний тоо нь эерэг нөлөөг үзүүлж байна. Бага насны хүүхдийн, хөдөлмөр эрхэлж буй болон тэтгэврийн насны гишүүний тоо нэгжээр нэмэгдэхэд нийт орлого харгалзан 142,875.9, 933,017.2, 458,065.7 төгрөгөөр нэмэгдэхээр байна.

б) Өрхийн нийт орлогын өөрчлөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийн шугаман бус загвар

Хүснэгт 28. Өрхийн сарын нийт орлогын хэмжээнд нөлөөлөгч хүчин зүйлсийн шугаман бус загварын үнэлгээний үр дүн

Хувьсагчууд	Тэмдэглэгээ	Үнэлэгдсэн коэффициент	t-ажиглалтын утга	prob
Сарын нийт орлогын логарифм	LOG(NO)			
Сул гишүүн		10.62	(7.34)	
Сарын тэтгэмжийн орлогын логарифм	LOG(TGSAR)	0.23	(7.91)	0.0000
Хөдөлмөрийн насны гишүүний тоо	ET	0.51	(9.76)	0.0000
Тэтгэврийн насны гишүүний тоо	TET	0.32	(24.37)	0.0000
LOG(NO)=10.62+0.23LOG(TGSAR)+0.32TET+0.51ET+u				
R²=0.65		F_{statistic}=124.62		F(Prob)=0.0000

Өрхийн сарын нийт орлогыг тайлбарлагдагч хувьсагчаар авч, шугаман бус загвараар үнэлэхэд сарын тэтгэмжийн орлогын логарифм, хөдөлмөрийн насны гишүүний тоо, тэтгэврийн насны гишүүний тоо гэсэн хүчин зүйлүүдийн үнэлэгдсэн коэффициент 95 хувийн итгэх түвшинд ач холбогдолтой гарч, өрхийн ам бүлийн тоо, 0-5 насны, 9-14 насны хүүхдийн тоо, дүүргийн байршил, хөдөлмөр эрхэлдэг гишүүний тоо, газрын эзэмшлийн хэлбэр, гэрлэлтийн байдал, өрх толгойлсон байдал, өрхийн тэргүүний нас, хүйс, ажил эрхлэлт, боловсрол, өөрийн аж ахуйгаас болон бусдаас үнэгүй хэрэглэсэн бүтээгдэхүүний үнэ, үйлдвэрлэл, үйлчилгээний орлого гэсэн үзүүлэлтүүдийн үнэлэгдсэн коэффициент ач холбогдолгүй гарсан учир эдгээр хүчин зүйлийг хасаж үнэлгээг хийсэн болно.

Загварчлалын үр дүнд өрхийн нийт орлогын өөрчлөлтөд тэтгэмжийн орлогын өөрчлөлт, тэтгэврийн болон хөдөлмөрийн насны гишүүний тоо нь эерэг нөлөөг үзүүлж байна. Сар бүрийн тэтгэмжийн орлого 1 хувиар нэмэгдэхэд 0.23 хувиар, тэтгэврийн болон одоо ажил эрхэлж байгаа

гишүүний тоо нэгжээр нэмэгдэхэд нийт орлого харгалзан 0.32, 0.51 хувиар нэмэгдэж байна.

Хөдөлмөрийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаануудад ахмад хүмүүсийн хувьд нас нь гол бэрхшээл байдаг бол залуу насныхны хувьд бизнесийн мөчлөгтэй холбоотой асуудал байдаг¹⁶. Мөн иргэд хөгжлийн бэрхшээлтэй байх нь хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, дутуу ажил эрхлэлтэд нөлөөлдөг болохыг тогтоосон байна¹⁷. Иргэдээс яагаад ажил эрхлэхгүй байгаа талаар судалгаа авахад эрүүл мэндийн байдал муу эсвэл хөгжлийн бэрхшээлтэй, тэтгэвэрт гарсан, гэрийн үүрэг хариуцлага, сургуульд явсан, ажил олж чадаагүй болон бусад шалтгаануудыг дурджээ¹⁸. Дээрх судалгаануудад үндэслэн хөдөлмөрийн насны иргэдийн ажил эрхлэх эсэхэд ямар хүчин зүйлүүд нөлөөлж буйг тогтоох зорилгоор доорх регрессийн шинжилгээг хийж дүгнэсэн болно.

г) Хөдөлмөрийн насны гишүүний ажил эрхлэх эсэхэд нөлөөлөгч хүчин зүйлсийн хязгаарлагдмал тайлбарлагдагч хувьсагчтай (ложит) загвар

Хүснэгт 29. Хөдөлмөрийн насны гишүүний ажил эрхлэлтэд нөлөөлөх хүчин зүйлсийн ложит загварын үнэлгээний үр дүн

Хувьсагчууд	Тэмдэглэгээ	Үнэлэгдсэн коэффициент	t-ажиглалтын утга	prob
Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн эсэх (1=ажил эрхэлсэн, 0=үгүй)	AENOW			
Сул гишүүн		-2.37		
Өрхийн амьдарч буй дүүрэг	DI	0.099	(4.29)	0.0000
Гишүүний боловсролын түвшин	MEDUC	0.16	(3.01)	0.0026
Гишүүний нас	MAGE		(4.51)	0.0000
Гишүүний статус	MRE	-0.10	(-2.19)	0.0288
AENOW=1-@CLOGISTIC(-(-2.37+0.099DI+0.16MEDUC-0.10MRE+0.27MAGE))+u				
R²=0.042		LR_{statistic}=60.84		LR(Prob)=0.0000

16 Hita Axelrad, Miki Malul and Israel Luski, Unemployment among younger and older individuals: does conventional data about unemployment tell us the whole story?, Journal for Labour Market Research, 2018

17 Steven J. La Grow, Factors that Affect the Employment Status of Working-Age Adults with Visual Impairments in New Zealand, JVIB, September, 2004

18 Steven F. Hipple, People who are not in the labor force: why aren't they working?, Beyond the Numbers, 2015

Сүүлийн 7 хоног ажил эрхэлсэн эсэх нь тайлбарлагдагч хувьсагч бөгөөд ложит загвараар үнэлэхэд өрхийн амьдарч буй дүүрэг, гишүүний боловсролын түвшин, гишүүний статус, гишүүний нас гэсэн хүчин зүйлүүдийн үнэлэгдсэн коэффициент 95 хувийн итгэх түвшинд ач холбогдолтой гарч, гишүүний хүйс, нийгмийн даатгалын төлөлтийн хэлбэр, дүүрэг, хороонд ажил хайгчаар бүртгүүлсэн байдал, дүүрэг, хорооноос зохион байгуулсан мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан байдал, өрхийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй байдал, 0-5 насны хүүхдийн тоо гэсэн үзүүлэлтүүд ач холбогдолгүй гарсан учир загвараас хасаж үнэлгээг хийсэн болно.

Загварчлалын үр дүнгээс харахад өрхийн гишүүний одоогийн ажил эрхлэх эсэх нь гишүүний боловсрол, нас, өрхийн гишүүний статус ямар байхаас хамаарч байна. Одоо ажил эрхлэх магадлалыг хувьсагчдын хослол бүрт тооцох боломжтой бөгөөд цөөн тохиолдлыг сонирхвол, одоо ажил эрхлэх магадлал нь Хан-Уул дүүрэгт амьдардаг, 45-55 насны, дипломын боловсролтой, өрхийн тэргүүний хувьд 0.69, Чингэлтэй дүүрэгт амьдардаг, 45-55 насны, дипломын боловсролтой, эхнэрийн хувьд 0.68, Баянзүрх дүүрэгт амьдардаг, 45-55 насны, бакалаврын зэрэгтэй, өрхийн тэргүүний хувьд 0.56, Сонгинохайрхан дүүрэгт амьдардаг, 15-24 насны, бакалаврын зэрэгтэй, ач, зээгийн хувьд 0.25, Сонгинохайрхан дүүрэгт амьдардаг, 25-34 насны, мэргэжлийн боловсролгүй, ач, зээгийн хувьд 0.14 байна.

д) Хөдөлмөрийн насны гишүүний ажил эрхлэх эсэхэд нөлөөлөгч хүчин зүйлсийн хязгаарлагдмал тайлбарлагдагч хувьсагчтай (пробит) загвар

Хүснэгт 30. Хөдөлмөрийн насны гишүүний ажил эрхлэлтэд нөлөөлөх хүчин зүйлсийн пробит загварын үнэлгээний үр дүн

Хувьсагчууд	Тэмдэглэгээ	Үнэлэгдсэн коэффициент	t-ажиглалтын утга	prob
Сүүлийн 1 жилд ажил эрхэлсэн эсэх (1=ажил эрхэлсэн, 0=үгүй)	AEYEAR			
Сул гишүүн		1.69		
Дүүрэг, хороондоо ажил хайгчаар бүртгүүлсэн эсэх	BE	-0.49	{-2.02}	0.0429
Нийгмийн даатгал төлсөн хэлбэр	ND	-0.41	{-6.23}	0.0000
$AEYEAR=1-\text{@CNORM}(-\{1.69-0.49BE-0.41ND\})+u$				
$R^2=0.10$ $LR_{\text{statistic}}=47.86$ $LR(\text{Prob})=0.0000$				

Сүүлийн нэг жилд ажил эрхэлсэн эсэх нь тайлбарлагдагч хувьсагч бөгөөд пробит загвараар үнэлэхэд дүүрэг, хороондоо ажил хайгчаар бүртгүүлсэн эсэх, нийгмийн даатгал төлсөн хэлбэр гэсэн хүчин зүйлүүд 95 хувийн итгэх түвшинд ач холбогдолтой гарч, гишүүний хүйс, нас, боловсрол, өрхийн ямар гишүүн байх, дүүрэг, хорооноос зохион байгуулсан мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан байдал, өрхийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй байдал, 0-5 насны хүүхдийн тоо гэсэн үзүүлэлтүүд ач холбогдолгүй гарсан учир загвараас хасаж үнэлгээг хийсэн болно.

Пробит загварчлалын үр дүнгээс харахад өрхийн хөдөлмөрийн насны гишүүний дүүрэг, хороонд ажил хайгчаар бүртгүүлсэн болон нийгмийн даатгал төлж байгаа эсэх нь сүүлийн нэг жилд ажил эрхлэх магадлалд нөлөөлж байна. Ажил хайгчаар бүртгүүлсэн болон бүртгүүлээгүй хувиараа нийгмийн даатгал төлдөг гишүүний хувьд тууштай ажил эрхлэх магадлал нь харгалзан 0.49, 0.29 байна. Ажил хайгчаар бүртгүүлсэн, улсаас нийгмийн даатгалыг нь төлдөг гишүүний хувьд тууштай ажил эрхлэх магадлал нь 0.3+2 байна. Нийгмийн даатгал огт төлдөггүй хөдөлмөрийн насны гишүүдийн хувьд тууштай ажил хийх магадлал нь ажил хайгчаар бүртгүүлсэн бол 0.19, бүртгүүлээгүй бол 0.09 байна.

2.6. Чанарын судалгааны үр дүн

2.6.1. Экспертийн ярилцлагын үр дүн

Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын 9 дүүргийн 12 хорооны хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон ТББ-ын эксперт тус бүртэй ярилцлага хийсэн. Уг судалгааг ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга замыг тодруулах зорилгоор хийсэн ба үр дүнг мэргэжилтнүүдийн ажлын ачаалал, төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, хөдөлмөр эрхлэлтийн талбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын харилцаа, холбоо, иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйл, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга зам гэсэн агуулгаар нэгтгэн дор харууллаа.

Мэргэжилтнүүдийн ажлын ачаалал

Төрөөс хөдөлмөр эрхлэлт, халамжийн чиглэлээр анхан шатны нэгж болох өрхтэй ажиллаж байгаа хорооны мэргэжилтнүүд уг ажлын байран дээрээ дунджаар 5 жил ажилласан байна. Мэргэжилтний хариуцан ажилладаг өрх, иргэний тоо нь дүүргийн байршил, хүн амын нягтаршлаас хамааран ялгаатай байдаг ба хариуцаж буй өрхийн тоо хамгийн бага нь

225, хамгийн их нь 3065, иргэний тоо хамгийн бага нь 1237, хамгийн их нь 14000 байна.

Мэргэжилтнүүд хөдөлмөр эрхлэлт, халамжийн чиглэлээр үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй ажиллаж байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүд халамжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ажилдаа дунджаар нийт ажлынхаа 77 хувийг зарцуулж байна гэж хариулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чиглэлд мэргэжилтнүүдийн ажил үүргийн хуваарьт багтсан үндсэн 8 төрлийн ажил үүрэг тутамд зарцуулж буй хугацаанд тулгуурлан эрэмбэлэх асуултын хариултад иргэдийг мэдээллээр хангаж туслалцаа үзүүлэх, тайлан, судалгаа гаргаж хүргүүлэх, нийтлэг үйлчилгээ, төсөл, хөтөлбөрт хамруулах ажил нь эхний дугааруудад, ажлын байрны сул орон тооны бааз үүсгэх, шинэ ажлын байрны захиалгыг бүртгэх ажлууд нь сүүлийн дугааруудад эрэмбэлэгдсэн [Зураг 32].

Зураг 32. Хөдөлмөр эрхлэлтийн чиг үүргийн гүйцэтгэл, зарцуулах цагт тулгуурласан эрэмбэ



Шигтгээ 1

...Манай хороо хүн ам олонтой. Хорооны мэргэжилтэн хуулийн дагуу заавал үзүүлэх ёстой халамжийн үйлчилгээгээ үзүүлсээр байтал хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талын ажил үүргүүдээ гүйцэтгэх цаг завгүй болдог тул зарим ажлаа ажлын бус цагаар буюу орой гэртээ сууж амжуулдаг. Мэргэжилтний ачааллыг тэнцвэртэй байлгахад анхаарах хэрэгтэй...

Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ш.Э

Төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй зарим төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн түвшинг мэргэжилтнүүдээр 1-маш муугаас 5-маш сайн гэсэн оноогоор үнэлүүлсэн ба хэрэгжилтийн дундаж хувиас үзэхэд хороодод эмэгтэйчүүд, ахмадууд, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрүүд сайн хэрэгжилттэй гэж хариулсан. Нийт хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж хувь 68 гэж үнэлэгдсэн байна. “Маш сайн” болон “сайн хэрэгжсэн” гэж хариулсан хувиар Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хамгийн өндөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр хамгийн доогуур үнэлгээтэй байна.

Хүснэгт 31. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, хувиар

Хөтөлбөрүүд	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Дундаж хувь	Мэдэхгүй
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2021-2022 оны хөтөлбөр	20%	40%	10%	20%	0%	66%	10%
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 2021	30%	30%	20%	10%	0%	70%	10%
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, 2021	10%	10%	50%	10%	0%	52%	10%

Хөтөлбөрүүд	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Дундаж хувь	Мэдэхгүй
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, 2017-2021	20%	20%	20%	10%	30%	62%	0%
Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	40%	20%	10%	10%	0%	66%	20%
Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр	40%	20%	20%	20%	0%	76%	0%
Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	40%	20%	30%	10%	0%	78%	0%
“Ногоон ажлын байр” хөтөлбөр	40%	10%	30%	0%	0%	66%	20%
Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	40%	30%	10%	20%	0%	78%	0%


Хөдөлмөр эрхлэлтийн талбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын харилцаа, холбоо

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нэмэгдүүлэх талбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага, олон улсын болон төрийн бус байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн давуу ба дутагдалтай талын тухай мэргэжилтэн болон экспертүүд дараах үнэлгээг өгсөн.

Салбарын төрийн байгууллага, олон улсын болон төрийн бус байгууллагуудын аль аль нь мэргэжлийн чиг баримжаа олгох тал дээр ажилладаг нь давуу талтай. Мөн төрийн байгууллагын үйл ажиллагааны хувьд ажлын байр бий болгох, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, төрийн бус байгууллага нь өрхийн гишүүдэд тохирсон үйлчилгээ үзүүлэх, олон улсын байгууллагын хувьд өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаараа бусад байгууллагаас давуу талтай гэж хариулсан байна.

Оролцогчдын 30-40 хувь нь бусад байгууллагуудын төсөл, хөтөлбөрийн талаар мэдээлэлгүйн улмаас давуу талыг тодорхойлоогүй байна.


Зураг 33. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны давуу талууд, давтамжийн хувиар



Дутагдалтай талуудад, төрийн байгууллагын хувьд бэлэнчлэх сэтгэлгээг нэмэгдүүлдэг, тухайн үедээ хэрэгжээд өнгөрдөг, үр дүн нь мэдээлэгддэггүй, төрийн бус байгууллага төдийлөн олон нийтэд танигдаагүй, хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн талаар төрийн байгууллагад мэдээлдэггүй, нэг удаагийн дэмжлэг үзүүлдэг, олон улсын байгууллагын хувьд цөөн буюу сонгогдсон өрхүүд дээр хэрэгждэг, нэг удаагийн дэмжлэг үзүүлдэг, тухайн үедээ зөвхөн хэрэгжээд өнгөрдөг зэргийг дурдсан байна.

Оролцогчдын 25 хувь нь “мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн байна.

Зураг 34. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны дутагдалтай талууд, давтамжийн хувиар



Мэргэжилтнүүд нэмж дүгнэхдээ, олон улсын байгууллага нь зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд дангаараа ажиллахдаа илүү богино хугацаанд үр дүнтэй ажилладаг бол төрийн болон бусад байгууллагатай хамтарч ажиллах тохиолдолд төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц удаан болох, хүлээх бэрхшээлтэй тулгардаг гэж үзсэн байна. Зарим тохиолдолд хороон дээр олон улсын байгууллага хариуцсан тусгай ажилтантай байдаг нь давуу тал болдгийг дурдсан.

Мөн оролцогчид байгууллагууд бие биедээ төсөл, хөтөлбөрийн талаар нээлттэй тайлагнадаггүй, зарим тусламж, дэмжлэг нь бэлэнчлэх сэтгэлгээг нэмэгдүүлдэг, нэг нутаг дэвсгэрт хэд хэдэн төсөл зэрэг хэрэгждэг, хоорондоо уялдаа холбоо муутай ажилладаг, материаллаг дэмжлэг үзүүлдэг боловч сэтгэл зүй, сэтгэлгээнд нь хөдөлмөр эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх итгэл үнэмшил өгч чаддаггүй талууд ажиглагддаг гэж дүгнэсэн байна.

Төрийн бус байгууллагын хувьд нөлөөллийн сургалтыг явуулдаг нь давуу тал болдог боловч, хүний нөөц муу, засаглал сул зэрэг нь тогтвортой, хүртээмжтэй үйл ажиллагаа явуулахад бэрхшээл болж байгааг экспертүүд онцлон дурдсан.

Экспертүүд ярилцлагын явцад төрийн байгууллага нь ажил олгогчдыг урамшуулах, ажлын байрны стандарт гаргах, ажил олгогчийг сургах гэх мэтээр ажил олгогчтой хамтарч ажилласнаар иргэдэд ажлын байр шинээр бий болгох тал дээр давуу талтай болохыг, төсөл, хөтөлбөр хэрэгжих шатандаа дамжлага ихтэй, албан тушаалтнууд байнга солигддог, улс төрийн оролцоотой, мэргэжилтний чадавх сул, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаа явагдаж байгаа нь харагддаг боловч үр дүн нь тодорхой биш, анхан шатны мэргэжилтнүүдийн гаргасан судалгаан дээр үндэслэж хөтөлбөрөө хэрэгжүүлдэггүй зэрэг дутагдалтай тал ажиглагддаг болохыг дурдсан байна.

Шигтгээ 2

... ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн хувьд юуны түрүүнд хувийн бизнес эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдах гэхээсээ илүүтэй ажлын байранд тогтвортой ажиллаад өрхийн орлогоо нэмэгдүүлэх нь илүү боломжтой гэж дүгнэдэг. Яагаад гэвэл эдгээр өрх нь банкны зээлийн шалгуурыг хангахгүй байна...

Налайх дүүргийн 1дүгээр хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Э

Иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйл

Хөдөлмөр эрхлэхэд иргэдийн зүгээс цалин, хөлсний хэмжээ, иргэдийн сэтгэл зүйн байдал хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж байна гэж судалгаанд оролцогчдын 66.7 хувь нь хариулсан байна. Дараагийн хүчин зүйлээр иргэдийн нас болон нийгэм, эдийн засгийн хямралыг онцолсон байна. Харин татварын хувь, хэмжээ, намын харьяалал иргэдийн хөдөлмөр эрхлэхэд бэрхшээл болно гэж цөөн эксперт хариулсан байна (Хүснэгт 35).

Ажил олгогчид ажлын агуулга, ажлын байранд тавигдах шаардлагаас хамаарч цалин, хөлсийг харилцан адилгүй олгож байгаа ч, ХТДҮҮ-нд хамрагддаг иргэдийн хувьд ажил олгогч, ажилтны хооронд албан ёсны гэрээ хийдэггүй, амласан цалин, хөлсөө өгдөггүй, хэт урт цагаар ажиллуулдаг, илүү цагийн хөлс өгдөггүй зэрэг хүчин зүйлүүд нийтлэг тохиолддогийг онцолсон. Энэ нь иргэдийн хувьд хөдөлмөр эрхлэх сонирхолгүй болгох, тууштай ажиллахгүй байх, сэтгэл зүйн асуудалд орох зэрэгт нөлөөлж байгааг дурдсан.

Зураг 35. Хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээл, давтамжийн хувиар



Хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөх хүчин зүйлсийг хөдөлмөр эрхэлдэг болон хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдийн хувьд ялган тодорхойлох ярилцлагын үр дүнг доорх хэсгүүдэд харууллаа.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг, хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд: Хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд хэдийгээр хөдөлмөр эрхэлж байгаа ч нэг байгууллагад тогтвор суурьшилтай ажиллах нь бага, оршин сууж буй хорооны ойр орчимд тохирох ажлын байр хомс буюу ажилдаа ирж, очихдоо цаг их зарцуулдаг, мөн ар гэрийн нөхцөл байдлаас шалтгаалан ихэвчлэн хагас цагаар эсвэл түр ажил хийдэг нь тэдний хувьд бэрхшээлтэй байдаг гэж экспертүүдийн 40-50 хувь нь хариулсан байна.

Мөн ур чадвар бага шаарддаг, цалин хөлс багатай ажил эрхэлдэг, ихэвчлэн үндсэн ажилтнаар ажиллаж чаддаггүй, эрүүл мэндээсээ шалтгаалан урт цагаар ажиллах боломжгүй байдаг, орон нутгаас шилжин суурьшиж байгаатай холбоотой дасан зохицох хугацаа шаарддаг зэрэг шалтгаануудыг дурдсан байна.

Хүснэгт 32. Хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээл, хөдөлмөр эрхэлдэг иргэний хувьд

№	Нөлөөлөх хүчин зүйл	Давтамжийн хувь
1	Ажилдаа ирж очихдоо цаг их зарцуулдаг	50.0%
2	Нэг байгууллагад тогтвортой ажиллах нь бага байдаг	50.0%
3	Ар гэрийн нөхцөл байдлаас шалтгаалан ихэвчлэн хагас цагаар, түр ажил хийдэг	41.7%
4	Ихэвчлэн ур чадвар бага шаарддаг ажил хийдэг учир цалин багатай байдаг	33.3%
5	Ихэвчлэн үндсэн ажилтан биш байдаг	25.0%
6	Эрүүл мэндийн шалтгаанаас болоод ихэвчлэн бага цагаар, түр ажил хийдэг	25.0%
7	Нэмэлт орлого олох боломж бага байдаг	16.7%
8	Орон нутгаас шилжин ирсэн учир дасан зохицоход хугацаа шаарддаг	8.3%

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг, хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдийн хувьд: Хөдөлмөрийн чадвартай боловч хөдөлмөр эрхэлдэггүй өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгааныг экспертүүд ажил идэвхтэй хайдаггүй, ихэвчлэн бага, дунд боловсролтой, асаргаа шаардлагатай өрхийн гишүүнтэй, бага насны хүүхдээ хардаг зэрэг гэж үзсэн байна. Бусад бэрхшээлийг доорх зургаас харна уу.

Зураг 36. Хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээл, хөдөлмөр эрхэлдэггүй иргэний хувьд



Мөн ярилцлагын явцад нэмэлтээр эдгээр иргэд ажлын байранд тавигдах шаардлага хангадаггүй, ажиллах дургүй, цалин хөлсөө бага байна гэж үздэг, хулгай хийдэг, бэлэнчлэх сэтгэлгээтэй, хувь хүний хандлага сул, амьжиргаа доогуур буюу ХТДҮҮ-нд хамрагддаг гэсэн сэтгэлгээнээсээ гарч чаддаггүй, өөрийгөө сайн таньж мэдээгүй, хүрээлэл


багатай, анхдагч хэрэгцээгээр өөрийгөө хайрцагласан байдалтай байдаг зэрэг нь ажил эрхлэхэд гардаг бэрхшээл болдог гэж үзсэн байна.

Сонсголын болон харааны бэрхшээлтэй иргэдийн хувьд дохионы хэл, баррель бичгийг нийтлэг мэддэггүй, баррель бичигт ашиглах хэрэгсэл байхгүй зэрэг ойлголцоход хүндрэлтэй тал олон тохиолддог гэж дүгнэсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга зам

ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар ямар үйл ажиллагаа явуулбал үр дүнтэй байх талаар мэргэжилтнүүдтэй туршлага хуваалцахад дараах арга замуудыг санал болгосон. Үүнд, өрхийн гишүүн тус бүрийн оролцоог нэмэгдүүлэх, сэдэлжүүлэх, ажил олгогчтой хамтран ажиллах, нийгмийн харилцаанд үр дүнтэй ороход нь саад учруулдаг сэтгэл зүйн асуудлуудаа даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэдийг сэтгэл зүйн сургалтад хамруулах зэрэг нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд зайлшгүй авах арга хэмжээ гэж оролцогчдын 66.7 хувь нь хариулсан. Мөн гэрээсээ ажиллах боломжтой ажлын байрыг нэмэгдүүлэх, зуучлах, дүүрэг, хорооны орчинд ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг арга замуудыг дурдсан байна.

Зураг 37. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжууд, давтамжийн хувиар



2.6.2 Бүлгийн ярилцлагын үр дүн

Фокус бүлгийн ярилцлагыг Баянзүрх дүүргийн 27 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн төлөөлөл болох 15 иргэнийг “Хөдөлмөр эрхэлдэг бүлэг”, “Хөдөлмөр эрхэлдэггүй бүлэг” болгон урьдчилан бэлдсэн асуултын дагуу нээлттэй ярилцлага хийх замаар зохион байгуулсан. Энэхүү ярилцлага судалгааг дараах 3 агуулгын хүрээнд өрнүүлж, иргэдийн үзэл бодлыг нээлттэй сонсож, нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

- Ажлын байрны олдоц, ажил олгогчийн зүгээс тавьдаг шаардлага
- Ажлын байранд тавигддаг шаардлагад иргэдийн нийцэх байдал
- Бэлэн мөнгөний дэмжлэгийн ач холбогдол, түүний хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө

Ажлын байрны олдоц, ажил олгогчийн зүгээс тавьдаг нийтлэг шаардлага

Иргэдийн үзэж буйгаар ажлын байр их боловч ажил олгогчдоос тавьдаг шаардлага иргэдийн бодит байдал, өнөөгийн нөхцөлтэй нийцэх нь бага тул эдгээр өрхийн гишүүд ажиллах хүсэл ихтэй боловч ажилд орж чаддаггүй байна. Тодруулбал,

- **Шинээр ажилд ороход хүндрэлтэй байна.** Ажил олгогчдын зүгээс нас заадаг шаардлага нь 40-өөс дээш насныхны хувьд хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлаж байна. Түүнчлэн, их дээд сургууль төгсөж, шинээр ажилд орохоор хандсан залуучуудыг ажлын туршлагагүй хэмээн ажилд авахгүй байгаа нь тэдгээр иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлж чадахгүй байна гэж үзжээ.
- **Ажил олгогчийн хариуцлага муу байна.** Судалгаанд хамрагдсан өрхүүдийн хамгийн их ажилладаг салбар болох барилга болон үйлчилгээний салбарын ажил олгогчид бага үнэлгээгээр ажиллуулдаг, цалингаа бүрэн боддоггүй, хугацаанд нь өгдөггүй зэргээр хөдөлмөрийн гэрээгээ зөрчдөг, цаашлаад хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй үзэгдэл түгээмэл байдаг нь иргэдийн ажил эрхлэх хүсэл сонирхлыг бууруулдаг байна.
- **Ажлын нөхцөл болон ар гэрийн нөхцөл байдал нийцэхгүй байна.** Иргэдийн хэлж буйгаар ажил олгогчид хэт их ачаалалтайгаар ажиллуулдаг, нэг хүнээр 2-3 хүний ажлыг гүйцэтгүүлэх зэргээр өндөр ачаалал өгөх нь ар гэртээ тавих анхаарал, халамжийг бууруулдаг. Ингэснээр эцсийн дүндээ иргэд ажлаа орхиж, гэртээ

суудаг байна. Энэ үйл явдал нь эмэгтэйчүүдийн хувьд илүү түгээмэл аж. Учир нь бага насны хүүхдээ харах, бага сургуульд сурдаг хүүхдээ хичээлд зөөх зэрэг нь ачаалалтай ажлын хажуугаар боломжгүй гэж иргэд үзсэн. Үүний зэрэгцээ, судалгааны зорилтот иргэд нь гэр хороололд, хотын төвөөс алслагдсан байршилд амьдардаг, оройтож тардаг, бага цалинтай үйлчилгээний салбарынханы хувьд өдөр бүр гэр рүүгээ таксигаар харих нь маш өндөр зардал гардаг учир тэр бүр үргэлжлүүлэн ажиллах сонголт хийхгүй байхад нөлөөлдөг байна.

Шигтгээ 3

...Ажил олгогчид гэрээний биелэлтийг ер хангадаггүй. Миний хувьд тогоочийн ажлын байранд ажилладаг боловч үүрэгт ажлынхаа хажуугаар ихэнхдээ бэлтгэгч, заримдаа угаагч хүртэл хийж ажилладаг. Бидний насныхан үүнийг тоохоо больсон гэхэд залуу үеийнхэн ажил олгогчийн бусдын хөдөлмөрийг үнэгүйдүүлсэн байдлыг хүлээн авч чадахгүй байгаа юм...

Сүхбаатар дүүргийн иргэн Б.Х

Шигтгээ 4

...Ажлын байр байгаа боловч ажиллах нөхцөл нь тухайн хүнд тохирохгүй байна. Цалин боломжийн боловч нөхцөл нь таарахгүй гэсэн нэг шалтгаан байна. Миний хувьд хөгжлийн бэрхшээлтэй. Би ажил их хайж хөөцөлддөг. Өөрийн гэсэн орон байргүй, түрээслэгч хүн. Бүх төрлийн борлуулалтын ажил үл хөдлөх барьцаалахыг шаарддаг. Цалин гайгүй гээд барилгын ажил хийе гэтэл цалингаа өгдөггүй. Төсөвт байгууллагад ажиллая гэхээр ажил олддоггүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо гүйцсэн гээд авдаггүй. Тэгээд том дэлгүүрт худалдагч хийж үзсэн. Тухайн үед 900'000 төгрөгийн цалин авсан ч бараа дутсан гэж хэлээд хассаар байгаад гарт 500'000 төгрөг л өгсөн. Онлайн ажлууд бас их найдваргүй, залилан ихтэй байна...

Баянзүрх дүүргийн иргэн Д.О

Ажлын байранд тавигддаг шаардлагад иргэдийн нийцэх байдал

Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан иргэдийн үзэж буйгаар иргэд ажил олгогчийн шаардлагад нийцэхгүй байгаа дараах 3 нийтлэг шалтгаан байна. Үүнд:

- **Иргэдийн ур чадвар дутмаг, мэргэжил, боловсролгүй байдал.** Хөдөлмөр эрхлэхэд иргэдийн зүгээс тулгамдаж буй тэргүүлэх шалтгаан нь ур чадвар сул байдал гэж үзжээ. Хөдөлмөрийн зах зээл дээр зарлагдаж буй олон ажлын байран дээр дунд эргэм

насны иргэдийн мэдлэг, ур чадвар дулимаг, харин залуу үеийнхэн мэргэжил, боловсролтой боловч сурсан зүйл, эзэмшсэн ур чадвар бага шалтгаанаар ажилд тэнцэхгүй байна гэж хариулсан байна. Гэртээ суудаг ажилгүй, мэргэжил, боловсролгүй иргэдэд хороо, дүүргээс үнэ төлбөргүй мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулдаг ч, ар гэр дэх асрахуйн ажил, үүргээ орхигдуулахгүйн тулд хэдий үнэ төлбөргүй боловч сурч чадахгүй байх тохиолдол их байдаг байна.

- **Хандлагатай холбоотойгоор тогтвортой ажиллаж чадахгүй байна.** Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан иргэд санал нэгтгэйгээр залуу үеийн хөдөлмөр эрхлэлтийн асуудалд санаа зовж буйгаа илэрхийлсэн юм. Нэг талаас шинээр төгсөгч залуу үеийнхэн хялбар аргаар орлого олох, хурдан мөнгөтэй болох хүсэлтэй байгаа нь өнөөдрийн хөдөлмөрийн зах зээл дэх ажлыг голж, гадаадад ажиллах эсвэл илүү өндөртэй цалинтай ажилд орохын тулд үргэлжлүүлэн суралцах шийдвэр гаргахад нөлөөлж байна. Үүний зэрэгцээ, залуучуудын хувьд ажлын байрны тодорхойлолтод заасан үүргийг зөвхөн ажлын цагт багтаан гүйцэтгэх сонирхолтой байдаг. Гэтэл ажил олгогчийн зүгээс гэрээний дагуу ажиллуулдаггүй, удирдлагын үзэмжийн дагуу нэмэлт ажил хийлгэдэг, илүү цагийн мөнгө олгодоггүй, уртасгасан цагаар ажиллуулдаг зэрэг нь залуучуудын хүлээлтэд нийцэхгүйн дээр тогтвортой ажиллах хүсэл сонирхлыг нь мохоож байна гэж иргэд дүгнэжээ.
- **Ар гэрийн нөхцөл байдал нь хөдөлмөр эрхлэх шаардлагад нийцэхгүй байна.** Ярилцлагад хамрагдсан ажилгүй болон түр ажил эрхэлдэг иргэдийн хувьд түр эсвэл байнгын хөдөлмөр эрхлэх сонирхолтой боловч хүүхэд харах, хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүнээ асрах зэргээр гэртээ чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үүнийг нь орлох хэн нэгнийг хөлсөлж, өөрөө хөдөлмөр эрхлэх нь эдийн засгийн хувьд ямар ч ашиггүй учир гэртээ байх шийдвэр гаргасан байна. Тэдгээр өрхийн хувьд, ажил олгогчийн зүгээс тавьдаг наад захын шаардлага болох ажлын 8 цагт бүтэн ажиллах шаардлагыг хангахгүй байна гэж үзсэн.

Шигтгээ 5

... Өнөөдрийн нийгэм ээж нарыг хүүхэдгүй юм шиг ажиллаж, ажилгүй юм шиг хүүхдээ асрахыг шаардаж байна. Ээж нар ажилд ороод яваад өгөхөөр хүүхдэд тавих анхаарал, халамж буурдаг. Тэгээд хүүхдийн дархлаа нь унана, өвдөнө. Авсан бага цалингаа буцаад хүүхдийнхээ эмчилгээнд зарцуулах хэрэгтэй болдог. Хүүхдээ асрах зуураа өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй байдаг ч бид хөтөлбөрийн шаардлагыг огт хангадаггүй. Олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөрүүд дандаа босго тавьдаг. Ер нь бол нийтийн байр хүртэл олон хүүхэдтэй айл оруулахгүй гэсэн босго тавьж байна...

Сүхбаатар дүүргийн иргэн Э.Н

Шигтгээ 6

...Дүүргээс зохион байгуулж буй мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудад бага насны хүүхдээ хардаг, сургуульд зөөдөг эмэгтэйчүүд хамрагдах хүсэлтэй байдаг боловч сургалт гэрээс нь хол байршилд зохион байгуулагддаг тул хамрагдах боломжгүй болдог. Ийм учраас сургалтыг эдгээр иргэнд ойр, мөн чанартай болгоход анхаарах хэрэгтэй...

Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.С

Бэлэн мөнгөний дэмжлэгийн ач холбогдол, түүний хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө

Төрөөс олгож буй бэлэн мөнгөний дэмжлэгүүд нь эдгээр өрхийн амьдрал, аж байдалд маш их эерэг нөлөө үзүүлдэг гэж иргэд хариулж байна. Тодруулбал, ар гэрт гүйцэтгэх асрахуйн ажил, үүрэгтэй холбоотойгоор эдгээр өрхийн хувьд хөдөлмөр эрхэлдэг өрхийн гишүүн цөөн байгаа үед бэлэн мөнгөний дэмжлэг нь өрхийн амьжиргаагаа залгуулахад чухал үүрэгтэй байна. Ярилцлагад хамрагдсан өрхүүдийн хувьд тухайлбал, хүүхдийн мөнгийг ахуй амьдралдаа зарцуулдаг бөгөөд энэ нь тэдгээрийн хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бууруулдаггүй гэж хариулсан. Харин хүүхдээ харж хандах үүрэг нь хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлаж байгаа аж.

Үүний зэрэгцээ, иргэдийн хэлж буйгаар цөөн тооны өрх л бэлэн мөнгөний дэмжлэгийг зориулалтын бусаар, магадгүй архинд зарцуулах тохиолдол гарч байна. Энэ нь бүх өрхийг төлөөлөхгүй бөгөөд ойролцоогоор 10 өрх тутмын 1 нь гэж үзэж байна.

Шигтгээ 7

...Бэлэн мөнгөний дэмжлэгийн үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд хяналтаа сайн тавих хэрэгтэй. Ингэхдээ тухайн өрхийн нөхцөл байдлаас хамааран, архины хамааралтай гэх мэт асуудалтай өрхтэй тулж ажиллан, мөнгийг нь яаж зарцуулж байгааг хянах хэрэгтэй. Түүнээс биш халамж авдаг бүх өрхийн зардлыг хянана гэдэг утгагүй...

Баянзүрх дүүргийн иргэн А.Ц

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Өрхийн ерөнхий шинж чанарын талаарх дүгнэлт

“Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын дагуу тухайн өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээ нь баталсан босго оноотой тэнцүү эсвэл бага бол өрх нь “Хүнсний эрхийн бичгийн хөтөлбөр”-т хамрагдаж байгаа бөгөөд ингэхдээ өрхийн гишүүн тус бүрээр тэтгэмж авдаг ба өрх бүрт очих тэтгэмжийн хэмжээ нь тухайн өрхийн ам бүлийн тооноос хамааран харилцан адилгүй байдаг.

Судалгаанд нийслэлийн 9 дүүргийн ХТДҮҮ-д хамрагддаг 381 өрхийн 2251 иргэнийг хамруулсан бөгөөд өрхүүдийн ам бүлийн дундаж нь 6, дээд тал нь 12 гишүүнтэй байгаа нь нийслэлийн өрхийн ам бүлийн дунджаас их байна. Насны бүтцийн хувьд, нийт гишүүний 47 хувь нь 0-14 насны хүүхэд, 48 хувь нь хөдөлмөрийн насны иргэн, харин 5 хувь нь тэтгэврийн насны иргэн байна. Түүнчлэн, нийт өрхийн 40.7 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна. Үүний зэрэгцээ өрхүүдийн 34.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүнтэй байгаа бөгөөд тэдгээр иргэдэд тохиолдож буй нийтлэг бэрхшээл нь оюуны болон хөдөлгөөний бэрхшээл байна. Судалгаанд оролцогч өрхүүд нь ам бүл олонтой, үүний дээр цөөнгүй тооны өрх толгойлсон эмэгтэйчүүд олон хүүхэдтэйгээ амьдардаг ерөнхий дүр зураг харагдаж байна. Мөн гурван өрх тутмын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүнтэй байгаа нь эдгээр өрхөд эрүүл мэндийн асуудал нийтлэг тулгамдаж буйг харуулж байна.

Өрхийн тэргүүний хувьд, дийлэнх өрхүүдийг идэр насны иргэд тэргүүлж буй боловч өрхийн амьжиргааг залгуулах, гол ажиллах хүч болсон өрхийн гишүүн нь эзэмшсэн мэргэжил, ур чадвар доогуур байна.

Амьжиргааны хувьд, судалгаанд хамрагдсан өрхүүдийн 80.8 хувь нь цалингийн орлоготой бөгөөд цалин хөлсний орлого нийт өрхийн хувьд дунджаар 976,199.5 төгрөг, цалингийн орлоготой өрхийн хувьд 1,207,571 төгрөг байна. Түүнчлэн, газар эзэмшлийн хувьд нийт өрхийн 42.8 хувь нь өөрийн гэсэн газаргүй байна. Хэдийгээр ихэнх өрх цалингийн орлоготой боловч ам бүлийн тоотой харьцуулбал мөнгөн дүн нь хангалттай бус юм. Нэмж хэлэхэд, тус цалингийн орлого нь өрхөд ногдох халамжийн тэтгэмжийн орлогоос даруй 4 дахин их байгаа нь эдгээр өрх дан ганц халамжийн орлогоор амьдардаггүй болохыг илтгэж байна.

Судалгаанд хамрагдсан өрхийн сарын нийт орлогод тэтгэмжийн эзлэх хувь дунджаар 36.3 хувьтай байгаа нь улсын дундажтай харьцуулахад өндөр, сарын нийт орлого нь улсын болон нийслэлийн дунджаас

харгалзан 215, 440 мянган төгрөгөөр доогуур байгаа нь ХТДҮҮ-нд хамрагддаг өрхүүд орлого багатай өрх болохыг харуулж байна.

Үүнээс гадна өрхүүдийн 18.9 хувь нь хөдөлмөр эрхэлдэг өрхийн гишүүнгүй, хөдөлмөрийн насны гишүүний тоо дунджаар 3 байгаа боловч, хөдөлмөр эрхэлдэг 1 гишүүнтэй өрх 47 хувь, 1-2 гишүүнтэй өрх 74.3 хувийг эзэлж байгаагаас харахад өрхүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин харьцангуй доогуур байна.

Эндээс дүгнэвэл, судалгаанд хамрагдсан ихэнх өрх нь ам бүл олонтой, олон хүүхэдтэй, өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй хийгээд ажилгүй, бага орлоготой байгаагаас харахад эдгээр өрх нь ХТДҮҮ хөтөлбөрт шалгуур хангасан өрхүүд болох нь харагдаж байна. Нөгөө талаас ихэнх өрх нь цалингийн орлоготой байгаа нь халамж хавтгайрсан, халамжийн мөнгөөр амьдардаг гэх ойлголтын эсрэг байна. Учир нь халамжийн орлого нь амьжиргааны түвшин доогуур өрхийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх төдий байгаа болохоос биш, өрхийн үндсэн орлого болж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, өрхийн зарим нийгмийн үзүүлэлт нь амьжиргааны түвшин доогуур байх шалтгаан болж байгаа хэдий ч өрхийн гишүүд зөвхөн халамжид найдаж суух биш, харин ч хөдөлмөр эрхлэн, өрхийн орлогоо нэмэгдүүлэхийг зорьж байна.

Зөвлөмж:

- **“Хүнс тэжээлийн дэмжлэг, туслалцаа” хөтөлбөр болон зорилтот өрхөд хандсан бусад халамжийн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэх** – Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг олгох төдийгүй асаргааны тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох нь зорилтот өрхүүддээ хүрч чадаж буйгаас гадна тэдгээрийн амьжиргаанд бодитой хувь нэмэртэй байна. Иймээс зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээс гадна нийгмийн янз бүрийн нөхцөл байдал, ялгаатай хэв шинж бүхий өрхүүдийн нөхцөл байдлыг судлан, түүнд тулгуурласан зайлшгүй шаардлагатай нийгмийн тусламж, үйлчилгээг хүргэх нь зөв юм.
- **Зорилтот өрхийн газар эзэмших, өмчлөх боломжийг нэмэгдүүлэх** – Газар өмчлөл нь өрхийн тогтвортой амьжиргаанд дэмжлэг үзүүлэх чухал хүчин зүйлд тооцогддог. Учир нь өөрийн өмчлөлийн газар нь хүний аюулгүй аж төрөх үндсэн хэрэгцээг хангахаас гадна, нийгмийн үйлчилгээ, дэд бүтцэд холбогдох чухал эх үүсвэр болох, цаашлаад түрээсийн зардлаа хэмнэх, газраа эргэлтэд

оруулж өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж бий болгох, мөн зээл, санхүүгийн үйлчилгээг хүлээн авахад барьцаа болох зэргээр өрхийн амьжиргааг дэмжихэд олон талын ач холбогдолтой. Гэтэл судалгаанд хамрагдсан өрхүүдийн ердөө 57.2 хувь нь л өөрийн газар дээр амьдарч байгаагаас харвал эдгээр өрхөд хандсан газар олголтыг эрчимжүүлэхэд чиглэсэн ажлууд хийгдэх шаардлагатай байна. Түүнчлэн, зорилтот өрхүүдийн газрын асуудлыг шийдсэнээр тэдгээр нь амьдарч буй байршилдаа удаан амьдрах, шилжилт хөдөлгөөнөө багасгах, үүнтэй холбоотойгоор нэг ажлын байранд тогтвортой ажиллахад эерэгээр нөлөөлнө.

2. Хөдөлмөр эрхэлж байгаа гишүүдийн талаарх дүгнэлт

2022 онд ҮСХ-ноос Улаанбаатар хотын хөдөлмөр эрхлэлтийг насны бүлгээр ангилсан хувьтай энэхүү судалгааны үр дүнг харьцуулахад хөдөлмөр эрхлэлт бүх ангилалд доогуур түвшинд байна. Ялангуяа 15-24 насны залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн түвшин хамгийн бага байна.

Харин 25-34 болон 35-44 насны эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр түвшинд буюу тус бүр 70 гаруй хувьтай байна. Өөрөөр хэлбэл, 25-44 насны эрчүүд судалгаанд хамрагдсан өрхүүдийн гол ажиллах хүч нь юм. Эмэгтэйчүүдийн хувьд, хөдөлмөр эрхлэлтийн хамгийн өндөр түвшин нь 45-55 насны бүлэгт 46.8 хувь, удаах нь 35-44 насны бүлэг 45.2 хувьтай байна.

Хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 60 хувь нь байнгын ажилтай бөгөөд бусад нь улирлын чанартай түр ажил эрхэлдэг, мөн цалин хөлстэй тохиолдлын ажилтан болон дадлагажигч хийдэг байна. Ингэхдээ эдгээр иргэний хувьд ихэвчлэн барилга болон үйлчилгээний салбарт энгийн ажил, мэргэжлээр ажиллан, долоо хоногт дунджаар 51.35 цаг ажилладаг бөгөөд сарын дундаж цалин 946,078 төгрөг аж. Энэ нь 2023 оны 2 дугаар улирлын статистикаар зарлагдсан нийт дундаж цалингаас 50 хувиар, энгийн ажил, мэргэжлээр ажиллагчдынхаас 33 хувиар доогуур байна.

Судалгаанд хамрагдсан цалингийн орлоготой, 1-2 гишүүн нь хөдөлмөр эрхэлдэг өрхийн цалин хөлсний дундаж орлого 1 ажилчны дундаж цалин хөлсний орлого (2023 оны 2 дугаар улирлын статистикаар гарсан 1.89 сая төгрөг)-оос доогуур түвшинд байгаа нь эдгээр өрхийн гишүүдийн хөдөлмөрийн зах зээл дээрх үнэлэмж доогуур байгааг илтгэж байна.

Үүний зэрэгцээ нийт хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 48 хувь нь нийгмийн даатгалын шимтгэлийг огт төлдөггүй гэсэн судалгааны үр дүн гарчээ.

Эндээс харахад, судалгаанд хамрагдсан өрхийн нийт гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин улсын дунджаас бага байгаа боловч, иргэдийн насны ангилал болон хүйсээс хамаарч бүлэг тус бүрт хөдөлмөр эрхлэлтийн түвшин харилцан адилгүй байна. Тодруулбал, нийтлэгээр 15-24 насны залуучуудын хөдөлмөр эрхлэлт хангалтгүй байхад эрчүүдийн хувьд 25-44 насныхан, эмэгтэйчүүдийн хувьд 35-55 насныхан хамгийн өндөр хувьтайгаар хөдөлмөр эрхэлж байна. Түүнчлэн, хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд, ажил эрхэлж буй нь сайн зүйл боловч тэдгээр иргэдийн хувьд улирлын чанартай түр ажлын байранд ажилладаг, уртасгасан цагаар ур чадвар бага шаарддаг ажил хийж, цалин хөлс бага авдаг гэх ерөнхий дүр зураг ажиглагдаж байна. Мөн эдгээр иргэний тал орчим хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байгаа нь даатгалд төдийлөн ач холбогдол өгөхгүй байгааг, цаашлаад ирээдүйд учирч болзошгүй олон эрсдэлийг удирдан, даван туулахад хүндрэл үүсэж болзошгүйг харуулж байна.

Зөвлөмж:

- **Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих**–15-24 насны залуучуудын хөдөлмөр эрхлэлт хамгийн бага буюу анхаарах шаардлагатай байгаа тул нэн тэргүүнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх нь чухал юм. Түүнчлэн, боловсролын байгууллагын зүгээс мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах, ажлын байртай танилцах аялал, төрөл бүрийн мэргэжлийн залуучуудтай уулзалт, өдөрлөг зохиох гэх мэт өнөөгийн залуучуудын хэрэгцээ, сонирхолд нийцсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулахаас гадна ажил олгогчдын зүгээс албан ёсны гэрээ байгуулж ажиллуулах, нийгмийн даатгалд хамруулах, хийсэн ажилд нь тохирох ажлын хөлсийг цагт нь олгоход хариуцлагатай хандахын зэрэгцээ залуучуудыг сонсох, урам зоригийг нь хугалахгүй байх, дагалдуулан зааж сургах зэргээр ажлын байран дээр зөвлөн туслах нь тэдний тогтвортой хөдөлмөр эрхлэлтэд чухал түлхэц болох талтай.
- **Хөдөлмөрийн насны иргэдийн ур чадварыг нэмэгдүүлэх** – Судалгаанд оролцогчид ур чадвар дутмаг байдлаас улбаатай голчлон өндөр ур чадвар шаардахгүй энгийн ажил, мэргэжлээр ажиллаж байгаа тул цалин бага, ажлын цаг урттай байна. Иймд хөдөлмөрийн насны иргэдийн ур чадварыг хөгжүүлэх нь чухал бөгөөд энэ нь зөвхөн шинээр ур чадвар эзэмших ажилгүй иргэдэд хамаатай бус,

харин ч ажил хөдөлмөр эрхэлж буй иргэдэд эерэгээр нөлөөлөх талтай. Хэдийгээр ажил хийдэг боловч мэргэжлийн ур чадвараа тасралтгүй сайжруулах нь ажлын ангиллаа өсгөх, ажиллах нөхцөл, цалингаа нэмэгдүүлэх, мөн шинэ ур чадвар эзэмшин илүү таатай нөхцөлтэй салбарт ажиллах болон түр ажлын байрнаас тогтвортой орлоготой байнгын ажлын байр руу шилжих боломжийг хувь хүнд олгоно. Иймээс зорилтот өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг, тэр тусмаа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн ур чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагаануудыг төлөвлөн, зохион байгуулах хэрэгтэй. Ингэхдээ сургалтын хөтөлбөрийг байнга хөгжүүлэх, практиктай холбох, сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, сургалтыг иргэдэд аль болох ойр байршилд сонгож явуулбал үр дүнтэй байхыг ярилцлага, судалгааны оролцогчид онцолсон.

- **Хөдөлмөр эрхлэгч иргэдийг ажлын байранд тогтвортой ажиллахад нь дэмжих** – Ар гэрийн асуудал нь судалгаанд оролцогч иргэдэд нийтлэг тохиолдогоос гадна байнгын ажлын байртай иргэдийн ажлын цаг урт, цалин бага байгаагаас харвал цаашид тэднийг тогтвортой ажиллах талаар дэмжихдээ нийгмийн асуудалд нь эерэгээр хандах, цалин хөлсний үнэлэмж болон ажлын цагийн уян хатан нөхцөлийг санал болгох нь тэдэнд мэдэгдэхүйц дэмжлэг болно гэж үзэж байна. Үүний зэрэгцээ, одоогоор улирлын чанартай түр ажил, цалин хөлстэй тохиолдлын ажилтан, дадлагажигчаар ажиллаж байгаа иргэдийг ажлын байрандаа үндсэн ажилтан болоход нь дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.
- **Нийгмийн даатгалын ач холбогдлыг ухуулах** – Зорилтот өрхүүдийн хөдөлмөр эрхэлдэг гишүүд нь нийгмийн даатгалд хамрагдахгүй байх нь тухайн хүн өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болох, өвчлөх, үйлдвэрлэлийн осолд өртөх зэрэг урьдчилан таах боломжгүй эрсдэлд орвол орлого олох чадвар нь буурч, цаашлаад өрх нь орлогын эх үүсвэргүй болох эрсдэлтэй. Хэдийгээр иргэд эрхэлж буй ажил, ажил олгогчийн хандлага зэрэг олон зүйлээс шалтгаалан нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй боловч даатгалд даатгуулах нь хувь хүний шийдвэр болдог. Иймд эдгээр иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг ухуулан сурталчлах, даатгалд хамруулах ажлыг идэвхжүүлэх зайлшгүй шаардлага байна.

3. Иргэд хөдөлмөр эрхлэхгүй байгаагийн шалтгаан

Судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн 47.2 хувь нь хөдөлмөрийн насны иргэд байгаа бөгөөд тэдгээрийн 41 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн улсын дундаж түвшин болох 54 хувиас бага байгаа юм.

Хүйсийн хувьд, хөдөлмөрийн насны иргэдийн 54.9 хувь нь эмэгтэй, 45.1 хувь нь эрэгтэй боловч хөдөлмөр эрхлэлтийн хувьд эмэгтэйчүүдийнх 33.7 хувь, эрчүүдийн хөдөлмөр эрхлэлт 49.7 хувьтай байна. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдийн хувьд хөдөлмөрийн насны иргэдийн тоо эрчүүдээс олон боловч, хөдөлмөрийн насны гурван эмэгтэй тутмын хоёр нь ажил хөдөлмөр эрхлээгүй байна. Хөдөлмөр эрхэлдэггүй гол шалтгаан нь бусдыг асардаг, өөрөө эрүүл мэндийн асуудалтай болон суралцдаг гэсэн зайлшгүй шалтгаануудыг тодорхойлжээ. Гэсэн хэдий ч, хөдөлмөр эрхэлдэггүй гишүүдийн 47 хувь нь өмнө нь огт хөдөлмөр эрхэлж үзээгүй байгаа нь харьцангуй өндөр хувь юм.

Үүний зэрэгцээ, хөдөлмөр эрхлээгүй иргэдийн 5.9 хувь нь мэргэжил ур чадвар дутмаг, ажлын байрны шаардлагад нийцэхгүй, нас ахисан гэх зэргээр ажил олж чадахгүй байгаа бол 5.3 хувь нь хамт олонд дасдаггүй, ажил олгогчтойгоо таардаггүй, архины хамааралтай гэх зэрэг хувь хүний хандлагатай холбоотойгоор хөдөлмөр эрхлэх сонирхолгүй байдаг байна. Нөгөө талаас, ажил олгогчийн зүгээс тавьдаг нийтлэг шаардлагаас дипломтой байх, англи хэлний мэдлэгтэй байх болон ажлын хэт ачаалал даах зэргийг хамгийн бэрхшээлтэй нь гэж үзсэн.

Ажил хайж байгаа иргэд ихэвчлэн танил тал, найз нөхдөөсөө сураглаж ажил хайдаг бөгөөд дүүрэг, хорооны дэмжлэгтэйгээр хөдөлмөрийн насны иргэдийн 9.3 хувь нь түр ажлын байранд, 5 хувь нь байнгын ажлын байранд зуучлагджээ.

Ажилгүй байгаа иргэдийг 2023 оноос хорооны мэргэжилтэн бүртгэдэг болсон нь бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог нэмэгдүүлж байгаа хэдий ч мэргэжилтний халамжийн чиглэлийн ажлын ачаалал ихтэй, олон иргэн хариуцан ажилладагтай холбоотойгоор шинэ ажлын байрны захиалгыг бүртгэх, ажлын байрны сул орон тооны бааз үүсгэх, ажилд зуучлах ажил бараг хийгдэхгүй байна.

Дүгнэж хэлбэл, судалгаанд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлээгүй нь хөдөлмөр эрхэлдгээс илүү олон байна. Хөдөлмөр эрхлээгүй иргэдийн хувьд эрүүл мэндийн байдлаасаа болоод ажиллах боломжгүй, мөн хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүн эсвэл бага насны хүүхдээ асрах болон олон хүүхдээ харж, халамжлах хэрэгцээ шаардлагын улмаас

хөдөлмөр эрхлэх боломжгүй байна. Тэр тусмаа, ийнхүү асрахуйн ажил хийх гол үүрэг нь залуу эмэгтэйчүүдэд ногдож байгаа бөгөөд хүүхдээ асрах, ар гэрээ авч явах үүрэг хариуцлага нь тэдгээрийн хөдөлмөр эрхлэх боломжийг нь хязгаарлаж байна. Харин хөдөлмөр эрхлэх боломжтой ч ажиллах сонирхолгүй иргэд төдийлөн олон биш бөгөөд тэдгээрт мэргэжил, ур чадвар олгохоос илүү нэн тэргүүнд өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, алсын хараа, зорилгоор удирдуулах, хамт олонтой болох, бусадтай хамтран ажиллах зэрэгт дэмжсэн сэтгэл зүйн сургалт, зөвлөгөө хэрэгтэй юм. Ажил хайсан ч олж чадахгүй байгаа иргэдийн хувьд нас болон ажлын байранд тавигдах шаардлагад тэнцэхгүй байх зэргээр тохирох ажлын байраа олоход нэлээд бэрхшээл тулгарч байна. Эцэст нь, хөдөлмөр эрхлээгүй иргэдийн тал орчим хувь нь өмнө нь ажил эрхэлж үзээгүйгээс харахад энэ бүлгийнхний тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь салбарын байгууллагуудаас ихээхэн хүчин чармайлт шаардах талтайг онцолж байна.

Зөвлөмж:

- **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн үйлчилгээг сайжруулах** – Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ажлын байр бий болгохоос өмнө нэн тэргүүнд тэдгээрийн нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, нийгмийн харилцаанд орох суурь нөхцөлүүдийг шийдэхэд анхаарлаа хандуулах шаардлагатай. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүнээ асарч буй хөдөлмөрийн чадвартай иргэн тодорхой цагаар эсвэл бүтэн цагаар хөдөлмөр эрхлэх боломжтой болох юм.
- **Ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** – Хүнс тэжээлийн дэмжлэг тусалцаа үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг өрхүүд дунджаар 3-4 хүүхэдтэй бөгөөд ээжүүд гэртээ бага насны хүүхдүүдээ харах эсвэл цэцэрлэг, сургуульд нь зөөх зайлшгүй шаардлагатай байгаа учир тэдэнд гэрээсээ эсвэл гэрт ойр байршилд ур чадварт суралцах болон хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэхээс гадна ажлын уян хатан нөхцөлтэй ажлын байранд зуучлах, онлайн сургалт, худалдаа, ажлын байрны мэдээллээр хангаж ажиллах нь зохимжтой байна. Түүнчлэн, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг өрх толгойлсон эмэгтэйчүүд рүү чиглүүлж, тэдний хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагааг төлөвлөж явуулбал үр дүнтэй болох хандлагатай.
- **Хөдөлмөрийн биржийн хүртээмжийг нэмэгдүүлэх** – Иргэдийн хувьд тохирох ажлын байраа олоход нэлээд бэрхшээлтэй тулгарч байгаа

хэдий ч хороо болон дүүргээс ажлын байранд зуучлагдах байдал харьцангуй цөөн байгаа учир хувийн хөдөлмөрийн биржийг дэмжиж ажиллавал ажлын байрны мэдээлэл илүү хүртээмжтэй болох талтай байна. Ингэснээр иргэд байнгын болон түр ажлын байранд хурдан шуурхай зуучлагдахаас гадна өөрийн нөхцөл боломжид тааруулан цагийн ажил эрхлэх боломжтой юм. Түүнчлэн, хөдөлмөрийн биржүүдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бэрхшээлийн төрлийг харгалзан, тухайн иргэний хэрэгцээг нь тодорхойлсны үндсэн дээр тохирох ажлын байранд зуучлахад чиглүүлэх нь чухал билээ.

- **Сэтгэл зүй, нийгэмшихүйн сургалт, зөвлөгөө үзүүлэх** – Судалгааны үр дүнгээс харахад ажиллах хүсэл сонирхолгүй иргэд төдийлөн олон биш боловч үүнийг тоохгүй өнгөрвөл иргэдийн хөдөлмөр эрхлэх сонирхолгүй байдал лавширч, ажилгүйдэл гүнзгийрэх магадлалтай. Учир нь одоогийн байдлаар хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн бараг тал нь урьд нь ажил хөдөлмөр эрхэлж үзээгүй байгаа бөгөөд тэдгээрийн хувьд нийгмийн асуудлаа шийдсэн ч, хөдөлмөр эрхлэхгүй байх шийдвэр гаргахад хувь хүний хандлага нөлөөлж болзошгүй. Тиймээс хөдөлмөр эрхлээгүй иргэдийн сэтгэл зүйн байдлыг дүгнэх, өөрийгөө үнэлэх үнэлэмж, өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлэхээс гадна одоогийн нөхцөл байдалтайгаа эвлэрсэн, анхдагч хэрэгцээгээр хэрэгцээгээ хязгаарласан, хүрээлээсээ гарах дургүй иргэдэд сэтгэл зүйн оновчтой сургалт, зөвлөгөө зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь иргэдийг хөдөлмөрт бэлтгэх урьдач нөхцөл болно.

4. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд анхаарах асуудлууд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд төрөл бүрийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж ирсний дээр аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогчид ажлын байрыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй байдаг.

Судалгааны үр дүнгээс харахад, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдээс эмэгтэйчүүд, ахмадууд болон залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд нь иргэдэд харьцангуй танил боловч ерөнхийдөө хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажил, үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэг ойлголт сул, цаашлаад энэ төрлийн үйлчилгээнд хамрагдах боломжийн талаар итгэл, үнэмшил муу байна. Учир нь анхан шатанд ажиллаж буй хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүдийн ажлын ачаалал харилцан адилгүй, зарим

хорооны мэргэжилтний ачаалал маш их байдгаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд бага цаг зарцуулдаг, ялангуяа ажил олгогчдын ажлын байрны захиалгыг бүртгэх, бааз үүсгэх, зуучлах ажил хийхэд цаг нь хүрэлцдэггүй, энэ чиглэлд мэргэжилтний чадавх сул, суралцах цаг завгүй, цаашлаад албан тушаалтнууд байнга солигддог байна. Үүний дээр, төрөөс баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд нь анхан шатны нэгжийн судалгаан дээр үндэслэгддэггүй, хэрэгжих шатандаа дамжлага ихтэй, санхүүжилт нь уддаг, үйл ажиллагаа ихтэй боловч хэрэгжилтийн үр дүн нь тодорхой бус байх зэрэг хүндрэлүүд байдаг аж. Түүнчлэн, нэг орон нутагт төрийн болон дотоодын ТББ, ОУБ-ын хэрэгжүүлж буй ижил төстэй төсөл, хөтөлбөрүүд нь уялдаа, хамтын ажиллагаа сул байдгийг мэргэжилтнүүд онцолсон.

Мөн ажил олгогчдын зүгээс олгож буй ажлын байранд хэт өндөр шаардлага тавьдаг, иргэдтэй хуулийн дагуу гэрээ байгуулдаггүй эсвэл гэрээний үүргээ биелүүлдэггүй, ажлын цаг урт, ажлын үнэлгээ бага зэрэг асуудал нь иргэдэд тулгамдаж байна.

Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд маш цөөн өрх буюу судалгаанд хамрагдагчдын 6.3 хувь нь хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл эрхэлдэг бөгөөд өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэл эрмэлзэлтэй зарим өрхийн хувьд дэмжлэг хэрэгтэй ч, энэ чиглэлийн төсөл, хөтөлбөрт тавигдах шаардлага, нөөц болон оролцогчдын тоо хязгаарлагдмал байдлын улмаас хамрагдах боломжгүй байна.

Зөвлөмж:

- **Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний үйл ажиллагааг оновчтой болгох** – Төрийн байгууллагын хөдөлмөр эрхлэлтийн чиглэл дэх анхдагч нэгж болох хорооны мэргэжилтнүүдийн ажлын ачаалал харилцан адилгүй, дийлэнх мэргэжилтний ажлын ачаалал өндөр байгааг нэг мэргэжилтний хариуцан ажиллах иргэний тоог тогтоох замаар орон тоог нэмэгдүүлэх, ачааллыг жигдлэх, мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах нь оновчтой байна.
- **Төрөөс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт дээр анхаарах** – Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг төлөвлөх шатнаас эхлээд анхан шатны мэргэжилтнүүдийн дуу хоолойг сонсох нь иргэдийн хэрэгцээ, шаардлагад суурилсан үйл ажиллагааг төлөвлөхөд ихээхэн ач холбогдолтойгоос гадна хэрэгжих шатан дахь мэргэжилтнүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хэрэгжилтийн үр дүн сайжрах давуу талтай.

Үүнээс гадна мэргэжлийн удирдлагын байгууллагууд нь төсөл, хөтөлбөрийг саадгүй хэрэгжих боломжоор хангах, хэрэгжилтийн явцыг тогтмол хянах, үр дүнг олон нийтэд нээлттэйгээр мэдээлж байх нь чухал юм.

- **Салбарын байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах** – Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд нэг байршилд хэдэн хэдэн төсөл, хөтөлбөр зэрэг хэрэгждэг тул тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах, хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах нь зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлнө.
- **Аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах** – Нэг талаас төрийн байгууллагын зүгээс аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, зорилтот бүлгийн иргэдийг ажлын байраар хангахад нь дэмжлэг үзүүлэх, тэдгээр байгууллагын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд анхаарах, нөгөө талаас аж ахуйн нэгжүүд нь нийгмийн хариуцлагаа хүний нөөцийн бодлоготойгоо уялдуулан, ажилчдын нийгмийн асуудлыг шийдэх, ялангуяа ажлын цагийн уян хатан нөхцөлийг бий болгож ажиллавал тогтвортой хүний нөөцтэй болохоор байна.
- **Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих** – Иргэд өөртөө ажлын байр бий болгож, хувиараа хөдөлмөр эрхлэн, хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцох нь өрх гэрийн төдийгүй улс орны эдийн засагт чухал хувь нэмэртэй. Үүний зэрэгцээ байнгын асаргаа шаарддаг өрхийн гишүүнтэй, олон хүүхэд халамжилдаг хөдөлмөрийн чадвартай иргэдийн хувьд өдрийн турш зөвхөн тодорхой цаг хугацаагаар л өрхийн үйлдвэрлэлд зарцуулах нь зарим талаараа байнгын ажлын байраас ч илүү ач холбогдолтой. Ийнхүү хувийн бизнес эхлүүлэх нь хувь хүнээс ур чадвар төдийгүй хөрөнгө санхүү шаарддаг тул өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд байгууллагыг удирдах, борлуулалт хийх, санхүүгээ удирдах мэдлэг, ур чадвар олгох болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь тэдгээр иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чухал гарц юм.

5. Өрхийн орлогод нөлөөлж буй хүчин зүйлс

Судалгааны үр дүнгээс харахад, өрхийн орлого нь үндсэндээ цалин, тэтгэвэр, тэтгэмжийн орлогоос бүрдэж байгаа бөгөөд медиан утга нь 1,604,333 төгрөг байна. Нийт өрхийн тал хувь нь медиан утгаас бага, үлдэх тал хувь нь медиан утгаас өндөр орлоготой байгаа төдийгүй вариацийн

коэффициент 44.8 хувь байгаа нь өрхүүдийн орлогын хэмжээ ялгаа ихтэй болохыг илтгэж байна.

Ийнхүү ялгаа бүхий орлогод нөлөөлж хүчин зүйлс нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй, өрх толгойлсон эцэг, эхтэй, өрхийн тэргүүний ажил эрхлэлт болон хүйс, сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхэлж буй гишүүний тоо, бага насны хүүхдийн тоо зэрэг юм. Мөн загварчлалын үр дүнгээр тэтгэврийн насны гишүүний тоо нь орлогын хэмжээ болон орлогын өсөлтийн хэмжээнд нөлөөтэй, орлогын өөрчлөлтийн хэмжээ нь тэтгэмжийн орлогын өөрчлөлт, хөдөлмөрийн насны гишүүний тооноос хамаарч байгаа нь өрхийн орлого нь цалин, тэтгэмж, тэтгэврийн орлогоос бүрдэж байгааг баталж байна.

Цалингийн орлого өрхийн нийт орлогын 49.9 хувийг эзэлж байна. Нэгээс дээш тооны гишүүн нь ажил эрхэлдэг бол өрхийн цалин хөлсний орлого, нийт орлого төдийгүй нэг гишүүнд ногдох орлого нь нийт өрхийн дунджаас өндөр байна. Хөдөлмөр эрхэлдэг 2-3 гишүүнтэй, өөрийн бизнестэй цөөн тооны өрхийн хувьд орлого өндөртэй байна. Мөн өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг бол цалин хөлсний орлого, нийт орлого болон нэг гишүүнд ногдох тогтмол бус орлого зэрэг нь өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэггүй өрхийнхөөс өндөр байна. Түүнчлэн, эрэгтэй тэргүүнтэй өрхийн хувьд цалин хөлсний орлого, нийт орлого нь эмэгтэй тэргүүнтэй өрхийн орлогоос тус бүр өндөр байна.

Харин өрхийн нийт орлогын 36.3 хувийг эзэлж буй тэтгэмжийн орлогын тухайд, өрх толгойлсон эцэг, эхтэй өрхийн тэтгэмжийн орлого болон мөнгөн тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь хамтын амьдралтай өрхийнхөөс өндөр байна. Мөн өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэггүй бол тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь өндөр байна. Үүний зэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн тэтгэмжийн орлого, түүний нийт орлогод эзлэх хувь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнгүй өрхийнхөөс тус тус өндөр байна.

Бусад орлогыг авч үзвэл, өөрийн аж ахуйгаас болон бусдаас үнэгүй хэрэглэсэн бүтээгдэхүүний үнэлгээ зэрэг нь өрхийн нийт орлогын өөрчлөлтөд төдийлөн нөлөө үзүүлэхгүй байгаа боловч өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн бүтээгдэхүүний үнэлгээ нь өрх толгойлсон эцэг, эхтэй өрхөөс хамтын амьдралтай өрхөд өндөр, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй гишүүнгүй өрхөд хөдөө ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого өндөр байх хандлага илүү байна.

Эцэст нь, өрхийн хөдөлмөр эрхэлж буй гишүүн, тэтгэвэр авдаг ахмад настан болон бага насны хүүхдийн тоо, төрөөс хүлээн авдаг тэтгэмжийн

хэмжээ нэмэгдэхэд өрхийн орлого нэмэгдэж байгаа бөгөөд эдгээрээс нийт орлогод хамгийн их нөлөө үзүүлэх хувьсагч нь хөдөлмөр эрхэлж буй гишүүний тоо юм. Өөрөөр хэлбэл, өрхийн хөдөлмөр эрхэлж буй гишүүн олон байх нь өрхийн нийт орлогыг нэмэгдүүлэх хандлагатай байгаа тул хөдөлмөрийн насны гишүүн бүр ажил эрхлэхэд анхаарах шаардлагатай байна.

Зөвлөмж:

- **Хөдөлмөрийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх** – Өрхийн орлогод нөлөөлж буй хүчин зүйлс олон боловч хөдөлмөр эрхлэлт нь өрхийн орлогыг нэмэгдүүлэх, цаашлаад өрхийн амьжиргааг тогтвортойгоор сайжруулахад хамгийн их нөлөө үзүүлэхээр байна. Хэдийгээр хөдөлмөрийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зөв боловч, зорилтот өрхийн нөхцөл байдлыг харгалзан, хөдөлмөр эрхлэхэд нь саад болж буй нийгмийн асуудлуудыг авч үзэхгүйгээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжгүйг анхаарах хэрэгтэй. Нэг ёсондоо, зорилтот өрхийн нийгмийн асуудлыг шийдэхийн сацуу, тэдгээрийн боломж нөхцөлд тохирсон хөдөлмөр эрхлэлтийн хувилбаруудыг санал болгох замаар хөдөлмөрт бэлтгэн, ажиллах нөхцөлийг нь хангаснаар өрхийн хөдөлмөрийн насны иргэд хөдөлмөр эрхлэн, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, өрхийн орлогыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ бүхий олон улсын сайн туршлагаас суралцах нь:

Сүүлийн үед НҮБ, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудын ядуурлыг бууруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүд нь бэлэн мөнгөний дэмжлэгийг ядуурлаас гаргах хөтөлбөртэй хослуулан хэрэгжүүлэх болсон бөгөөд үүний гол төлөөлөгч болох БРАК олон улсын байгууллагын төгсөлтийн аргачлалыг хот, хөдөөгийн болон цаг уурын өөрчлөлт, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн нөхцөлд буй, мөн эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг төрөл бүрийн хүн амд зориулж, хөтөлбөртөө тохируулан хэрэгжүүлсэн туршлага бий.

Түүнчлэн БРАК нь Африк, Азийн янз бүрийн чадавхтай Засгийн газруудад уг аргачлалыг нийгмийн хамгааллын системтэй нь нэгтгэх талаар зөвлөх үйлчилгээ, техникийн дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд одоогоор Филиппин, Кени, Руанда, Лесото, Гвиней, Пакистан зэрэг улсуудын Засгийн газартай хамтран ажиллаж, аргачлалыг орон нутгийн нөхцөл байдалд тохируулан, үндэсний хөтөлбөртэй нь үр дүнтэйгээр нэгтгэж байна.

Мөн олон улсад бизнесийн байгууллагууд, томоохон аж ахуйн нэгжүүдэд уг аргачлалыг хүний нөөцийн бүрдүүлэлттэйгээ хослуулан хэрэглэх зөвлөгөөг ч өгч байна.

Энэхүү аргачлал нь хамгийн их ядууралд өртсөн, нийгэмдээ гадуурхагдсан, амьжиргаа доогуур гэр бүлүүдэд баталгаагүй орлогын эх үүсвэрээс илүү тогтвортой орлого бий болгох үйл ажиллагаанд шилжих боломжийг олгодог. Гол санаа нь ядуурлын урхинд орсон өрхүүдэд хязгаарлагдмал хугацаанд итгэл найдвар бий болгох “томоохон түлхэц” өгөх явдал юм. (Аргачлал нь хэрхэн хэрэгжиж, ямар үр дүн авчирдаг талаарх дэлгэрэнгүйг Этиоп, Гана, Гондурас, Энэтхэг, Пакистан, Перу орнуудад хийсэн тайлангуудаас харж болно (Abhijit Banerjee, Esther Duflo, et all, 2015).

Өмнө хэрэгжүүлсэн туршлага дээрээ үндэслэн БРАК нь уг аргачлалыг яг хэнд чиглүүлэн хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй болох талаар судлахыг хичээсэн байдаг (Adapting BRAC's Graduation Poverty Context in Bangladesh, 2021). Эцсийн дүндээ, ядууралд өртсөн өрх бүрт уг аргачлал зориулагдсан, харин тодорхой тооны өрхүүдийн нийтлэг онцлог, ядуурлын шалтгаанд тулгуурлан аргачлалыг тохируулах боломжтой гэж үзэж байгаа юм.

Манай орны хувьд ч, тус аргачлалыг хэд хэдэн орон нутагт хэрэгжүүлж үзсэн туршлага бий. Иймд цаашид энэхүү аргачлалын үр дүнг хэлэлцэж, өөрийн орны онцлог, ядууралд өртсөн өрхүүдэд тулгамдаж буй нийтлэг бэрхшээлийг арилгахад чиглэсэн загвар хөтөлбөрийг тохируулан боловсруулах боломжтой.

6. Өрхийн хөдөлмөрийн насны гишүүний ажил эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс

Хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөх хүчин зүйлийг тодруулахад, өрхийн гишүүний ажил эрхлэх эсэх нь боловсрол, нас, өрхийн гишүүний статус зэргээс хамаарч байна. Хан-Уул дүүрэгт амьдардаг, 45-55 насны, дипломын боловсролтой, өрхийн тэргүүний одоо ажил эрхлэх магадлал хамгийн өндөр буюу 0.69, Баянзүрх дүүрэгт амьдардаг, 45-55 насны, бакалаврын зэрэгтэй, өрхийн тэргүүний хувьд 0.56, Сонгинохайрхан дүүрэгт амьдардаг, 25-34 насны, мэргэжлийн боловсролгүй, ач, зээгийн хувьд одоо ажил эрхлэх магадлал хамгийн бага буюу 0.14 байна. Тодруулбал, хүмүүний идэр насанд гэр бүлээ тэжээн тэтгэх үүрэг хариуцлага нэмэгддэг учир тус бүлгийн иргэдэд хөдөлмөр эрхлэх хандлага их байгаагийн дээр энэ хандлага өрхийн тэргүүн, түүний эхнэр/нөхөрт илүү ажиглагдаж байна. Үүний зэрэгцээ, боловсролтой байдал нь ажил эрхлэлтэд эерэг нөлөө үзүүлж байгаа тул хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тул өрхийн гишүүний боловсролд анхаарах нь зайлшгүй юм.

Түүнчлэн, өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн сүүлийн нэг жилд ажил эрхлэх магадлалд шинжилгээ хийхэд дүүрэг, хороонд ажил хайгчаар бүртгүүлсэн байдал болон нийгмийн даатгалын төлөлтийн хэлбэр нь нөлөө үзүүлж байна. Пробит загварын үр дүнгээр, ажил хайгчаар бүртгүүлсэн, хувиараа нийгмийн даатгал төлдөг болон улсаас нийгмийн даатгалыг нь төлдөг гишүүний хувьд тууштай ажил эрхлэх магадлал нь харгалзан 0.49, 0.32 байна. Нийгмийн даатгал огт төлдөггүй хөдөлмөрийн насны гишүүдийн хувьд тууштай ажил хийх магадлал нь ажил хайгчаар бүртгүүлсэн бол 0.19, бүртгүүлээгүй бол 0.09 байна. Өөрөөр хэлбэл, иргэд ажил хайгчаар бүртгүүлснээр ажилд орох магадлал нь нэмэгдэж байгаа төдийгүй нийгмийн даатгалд хамрагдаагүй иргэд урт хугацаанд ажил эрхлэх магадлалтай байна. Иймд хөдөлмөрийн насны иргэдийг дүүрэг, хороонд ажил хайгчаар бүртгүүлэх, мөн иргэдэд нийгмийн даатгалын ашиг тусыг ухуулан сурталчлах нь чухал нөлөөтэй байна.

Зөвлөмж:

- **Зорилтот өрхийн гишүүдийн боловсролд анхаарах** – Судалгааны үр дүнг үзвэл, иргэдийн боловсролын түвшин нэмэгдэх тусам хөдөлмөр эрхлэх магадлал өндөр байгаа боловч судалгаанд оролцогчдын боловсрол эзэмшсэн байдал хангалтгүй байна. Тиймээс энэ бүлгийн иргэдэд боловсрол эзэмшихэд нь саад болж буй шалтгааныг тодруулсны үндсэн дээр түүнийг арилгахад чиглэсэн үйл ажиллагаануудыг төлөвлөн хэрэгжүүлж, боловсролын түвшингээ нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чухал алхам болно.
- **Гэр бүлийн харилцаа, өрхийн хөгжлийн сургалт, зөвлөгөө явуулах** – Өрх гэрээ тэтгэн тэжээх үүрэг хариуцлага нь хөдөлмөр эрхлэхэд чухал сэдэл болохыг бид судалгааны үр дүнгээс харж байна. Учир нь өрхөд гүйцэтгэх үүрэг өндөр буюу өрхийн тэргүүн, түүний эхнэр/нөхрийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин өрхийн бусад гишүүнээс өндөр байна. Нөгөөтээгүүр, уг үүрэг хариуцлагаа үл ойшоож, гэр бүлээ орхисон өрхийн тэргүүлэгчид нэлээд байна. Иймд хөдөлмөрийн насны иргэд бат бөх гэр бүлийг байгуулж, өрх гэрийнхээ өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлах нь ажил хөдөлмөр эрхлэхэд томоохон түлхэц болж байгаа тул иргэдэд гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харьцааны талаар эерэг хандлагыг төлөвшүүлэх нь зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.
- **Хөдөлмөрийн насны иргэдийг ажил хайгчаар бүртгэх** – Ажил хайгчаар бүртгүүлсэн иргэдийн хөдөлмөр эрхлэх магадлал өндөр

байгаагаас үзвэл зорилтот өрхийн хөдөлмөр эрхлээгүй гишүүдийг ажил хайгчаар бүртгэн, тохирох ажлын байрыг тасралтгүй санал болгох нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. Ингэхдээ хөдөлмөрийн насны иргэдийн, ялангуяа залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдал, ур чадварын үнэлгээг хийж, тохирох ажлын байр төдийгүй шаардлагатай тохиолдолд, ажилд зуучлахаас өмнө хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээнд хамруулах нь зөв билээ.

Эцэст нь дүгнэхэд, энэхүү судалгаагаар дэвшүүлсэн зорилгодоо хүрч, Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж, цаашид хөдөлмөр эрхлэлт төдийгүй, өрхийн амьжиргааг дэмжихэд анхаарах шаардлагатай асуудлуудыг тодорхойллоо. Ингэхдээ өрхийн ерөнхий шинж чанар, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөр эрхлээгүй шалтгаан зэргийг авч үзсэнээс гадна өрхийн орлогын хэмжээ, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судалснаар тус үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжуудыг санал болголоо.

Тус үйлчилгээнд хамрагдаж буй өрхүүдийн дийлэнх нь амьжиргаа доогуур, олон хүүхэдтэй, цөөнгүй өрх нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй, мөн энэхүү бүлэгт ажилгүйдлийн түвшин өндөр төдийгүй ажилгүйдлийн нийтлэг шалтгаан нь эрүүл мэндийн асуудал, асрахуйн ажил эрхэлдэг болон ажил олдохгүй байгаа гэх судалгааны үр дүнгүүд нь өмнө хийгдсэн судалгааны үр дүнтэй нийцэж байгаа боловч зарим үр дүн нь ялгаатай байна. Тухайлбал, Ц.Амартүвшин нарын “Хүнсний тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хамрагдалт ба ажил эрхлэлт” судалгаа нь хот, хөдөөг хамруулсан бөгөөд хөдөөд ажилгүйдлийн түвшин хотынхоос илүү байгааг онцолсны зэрэгцээ эрчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна гэсэн судалгааны үр дүнг танилцуулсан бол бидний судалгаагаар зөвхөн нийслэлийн дүүргүүдийг хамруулсан учир эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр зэрэг ялгаатай үр дүнгүүд ажиглагдаж байна. Мөн ядуурал нь ажилгүйдэлтэй холбоотой байх албагүй, харин бага цалинтай ажил, өрхийн тусгай хэрэгцээтэй (олон хүүхэдтэй, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт асран халамжлах гишүүдтэй том өрхүүд) холбоотой гэж үзсэн бол манай судалгааны хувьд ядууралд бага цалинтай ажил, өрхөд тулгамдаж буй нийгмийн асуудлууд нөлөөлж буйг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд өрхийн орлогогүй байдалд ажилгүйдэл, тэр тусмаа хөдөлмөрийн насны иргэдийн ажил эрхлэх боломж хязгаарлагдмал байгаа нь хамгийн ихээр нөлөөлж байна гэж тодорхойлогдсон. Ийм учраас бидний зүгээс

хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс, ялангуяа ажил эрхлэхэд саад болж буй асуудлуудыг илрүүлэхийг зорьсон.

Түүнчлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжууд хийгээд санал болгож буй сайжруулалтыг судлахдаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих одоогийн үйл ажиллагаануудын талаарх иргэдийн мэдлэг, ойлголт болон тэдгээрийн санал хүсэлт, мөн томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэргэжилтнүүдийн үнэлгээ ба цаашид анхаарах асуудлуудыг гүнзгийрүүлэн судалсан нь ололттой тал байлаа.

Иймд нийгмийн хамгааллын салбарын байгууллагууд, хөтөлбөр хэрэгжүүлэгч нар үйл ажиллагаагаа төлөвлөхдөө энэхүү судалгааны үр дүнг харгалзан үзэх нь зүйтэй юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Судалгаа, тайлан

- Л.Мөнхзул, Д.Нямсүрэн, Б.Бүжинлхам, Г.Амаржаргал, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн агуулга, үр дүнгийн үнэлгээ, УБ., 2023
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ, 2023
- Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгал, халамжийн статистик, 2022
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Монгол Улсын нийгмийн халамжийн үзүүлэлтүүд 2017-2021, 2022
- ХНХЯ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, АХБ, Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавх бэхжүүлэх нь, Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ ба хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, УБ., 2022
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Ур чадварын эрэлтийн судалгаа, УБ., 2022
- Б.Батбаатар, Н.Жаргалсайхан, Г.Мягмардулам, С.Хүрэл-Эрдэнэ, М.Ган-Эрдэнэ, У.Даваасүрэн, Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа, УБ., 2022
- Л.Мөнхзул, Д.Нямсүрэн, Б.Бүжинлхам, Г.Амаржаргал, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, санхүүжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ., 2022
- Т.Эрдэнэчулуун, Г.Энх-Амгалан, Г.Ганзориг, Ц.Цэрэндаваа, Монгол Улсад хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн ажлын байрны эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлох нь, УБ., 2021
- JICA, Японы ICNET компани, “Ковид-19” цар тахлын дараах Монгол Улсын нийгмийн хамгааллын салбар дахь хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл цуглуулах суурь судалгаа, 2021
- С.Мөнхчимэг, Нийгмийн халамжийн бодлогын хөдөлмөрийн зах зээл, ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөө, Монголбанк товхимол15, УБ., 2021

- НҮБ, Хүүхдийн сан, Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдлийн хэрэгжилтийг үнэлэх нь, 2021
- Б.Нарантулга, С.Зулпхар, Ч.Эрдэнэчимэг, С.Ганцэцэг, С.Наранцэцэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үр дүнгийн шинжилгээ, “Мөнхийн үсэг” ХХК, 2020
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Ажил олгогчоос ажилтанд тавих шаардлагын судалгаа, УБ., 2017
- Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Бүх нийтийн нийгмийн хамгаалал, Нийгмийн хамгааллыг өргөжүүлснээр хөгжилд үзүүлэх нөлөө

Хууль, эрх зүйн актууд

- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”, шинэчлэн батлагдсан, 2023.06.21
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөр батлах тухай, УБ., 2022.02
- Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗБТУАСА), Сангийн сайд, ҮСХ, 2018.12.31
- Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийг тооцох аргачлал, ҮСХ, 2019
- Нийгмийн зарим үзүүлэлтүүдийн маягт, ҮСХ, 2018
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, УИХ, 2017
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, УИХ, 2016
- Боловсролын статистик үзүүлэлт тооцох аргачлал, ҮСХ, 201
- Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал, ҮСХ, 2013
- Нийгмийн халамжийн тухай хууль, УИХ, 2012
- Монгол Улсын үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт, YAMAT-08, (ISCO-08), Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, 2010
- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2050”-ын үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтүүд, <https://sdg.1212.mn>

Гадаад хэл дээрх эх сурвалж

- Vu Thi Quynh Chi and Thai Thi Thai Nguyen, Analysis of the Factors Affecting the Household Income of Ethnic Groups in VoNhai District, Thai Nguyen Province, European Journal of Development Studies, 2023

- The State of Economic Inclusion Report, Adapting BRAC's Graduation Poverty Context in Bangladesh, Case study, 2021
- Unicef, Universal child benefits, 2020
- Stephen Kidd and Diloá Athias, The effectiveness of the graduation approach: What does the evidence tell us?, 2019
- CGAP, Graduating the poor, Completion report, 2018
- Hila Axelrad, Miki Malul and Israel Luski, Unemployment among younger and older individuals: does conventional data about unemployment tell us the whole story?, Journal for Labour Market Research, 2018
- Sanzidur Rahman, Factors Influencing Household Income in Poor Urban Slum Settlements in Bangladesh, Journal of Poverty Alleviation and International Development, 2017
- Steven F. Hipple, People who are not in the labor force: why aren't they working?, Beyond the Numbers, 2015
- Abhijit Banerjee, Esther Duflo, et al, A multifaceted program causes lasting progress for the very poor: Evidence from six countries, Development economics, 2015
- Ariel Fiszbein and Norbert R. Schady, Conditional Cash Transfers Reducing Present and Future Poverty, 2009
- Steven J. La Grow, Factors that Affect the Employment Status of Working-Age Adults with Visual Impairments in New Zealand, JVIB, September, 2004

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны асуумж

СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

“Сайн байна уу. Намайг гэдэг. Би хараат бус судлаачаар ажиллаж байгаа юм. Нээлттэй Нийгэм Форумас захиалсан “Хүнс тэжээлийн дэмжлэг” хөтөлбөрт хамрагддаг өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор Улаанбаатар хотын 9 дүүрэгт байршилтай хөтөлбөрт хамрагддаг 381 өрх, өрхийн сонгогдсон гишүүнээс судалгааг авч байна. Ярилцлагын хугацаа 30 минутаас хэтрэхгүй үргэлжилнэ. Таны хариултын нууцыг бид Монгол Улсын Статистикийн тухай, Хувь хүний нууцын тухай хуулиудын дагуу бусдад задруулахгүйгээр чандлан хадгалахаа баталж байна. Судалгааны үр дүнг судалгааны зорилгоос бусдаар ашиглахгүй бөгөөд судалгааны тайланд таны нэр, нас, хүйс болоод хувийн ямар нэг мэдээллийг дурдахгүй. Мөн Хүнс тэжээлийн дэмжлэг хөтөлбөрт хамрагдалтад бид нөлөөлөхгүй. Тиймээс энэхүү асуумжид үнэн зөв, бүрэн гүйцэд хариулахыг хүсэж байна. Бид таны яриаг хяналтын зорилгоор бичлэг болгон хадгална.

1. Та судалгаанд хамрагдахыг зөвшөөрч байна уу?

а) Тийм

б) Үгүй, өрхтэй дахин айлчлах хугацааг тохирно уу.

Та судалгаанд оролцохыг зөвшөөрч байвал дараах өгүүлбэрийг давтан хэлнэ үү.

Зөвшөөрлийн өгүүлбэр: Би судалгааны мэдээлэл, нөхцөлтэй бүрэн танилцлаа. Тиймээс би энэ судалгаанд сайн дураараа оролцож асуумжид үнэн зөв хариулахаа баталж байна.

2. Та уг судалгааны сонгогдсон гишүүн мөн үү?

а) Тийм

б) Үгүй, үгүй бол судалгаа авах хугацааг дахин төлөвлөнө үү.

Асуултуудыг дарааллын дагуу намайг асуухад та хариултаа хэлээд яваарай. Асуулттай холбоотой тодруулах зүйл гарвал санаа зоволтгүй асуугаарай. Одоо би танаас асуултаа асууж эхэлье.

ӨРХИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ - 1

3. Өрхийн хорооны код	4. Байршил буюу GPS	5. Судлаачийн нэр	6. Судалгаанд оролцогчийн утасны дугаар	7. Өрхийн тэргүүний нэр	8. Өрхийн ХЭБ-ийн тэргүүний нэр
.....
10. Судалгаанд оролцогчийн амьдарч буй дүүрэг		9. ХЭБ-ийн өрхийн тэргүүний регистрийн дугаарыг бичнэ үү.		12. Өрхийн нийт ам бүлийн тоо (Өрхөд бүртгэлтэй сүүлийн 6 сарын хугацаанд хамт амьдарч буй гишүүнийг оруулна)	
				
				13. Өрхийн 0-5 насны хүүхдийн тоо	
Багануур 4-р хороо Багахангай 1-р хороо Баянгол 23-р хороо Баянзүрх 23-р хороо Баянзүрх 35-р хороо Налайх 1-р хороо Сонгинохайрхан 7-р хороо Сонгинохайрхан 26-р хороо Сонгинохайрхан 41-р хороо Сүхбаатар 16-р хороо Хан-Уул 8-р хороо Чингэлтэй 16-р хороо		11. Танай оршин сууж буй газрын ээмшлийн хэлбэр аль нь вэ? 1. Өөрийн 2. Нийтийн эзэмшлийн 3. Албан газрын 4. Хүний газар, түрээсийн 5. Хөгжлийн 6. Бусад (тодруулна уу)		14. Өрхийн 6-14 насны хүүхдийн тоо	
				
				15. Өрхийн хөдөлмөрийн насны гишүүний тоо	
				
				16. Өрхийн тэтгэврийн насны гишүүний тоо	
				

17. Өрхөд хөгжлийн бэрхшээлтэй гишүүн байгаа юу?	Хөгжлийн бэрхшээлтэй гишүүний хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг сонгоно уу. /Хэдэн ч хариултыг сонгож болно/	Өрхийн тэргүүний гэрлэлтийн байдал	Өрхийн тэргүүний хүйс
1. Тийм 2. Үгүй	1. Харааны 2. Хэл ярианы 3. Хөдөлгөөний 4. Сэтгэцийн 5. Сонсголын 6. Бусад /тодруулна уу/	1. Огт гэрлээгүй 2. Гэрлэсэн: Батлуулсан 3. Гэрлэсэн: Батлуулаагүй / хамтран амьдардаг/ 4. Тусгаарласан 5. Цуцалсан 6. Бэлэвсэн	1. Эрэгтэй 2. Эмэгтэй
Өрхийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүний тоо			

ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

Зааварчилгаа: Өрхийн хөдөлмөр эрхэлдэг гишүүн бүрийн мэдээллийг авна уу.

22. Гишүүн өрхийн тэргүүнтэй ямар хамааралтай вэ?	23. Гишүүний хүйс	24. Гишүүний нас	25. Гишүүний боловсролын түвшин	26. Гишүүн сүүлийн 1 жилд хөдөлмөр эрхэлсэн үү?	27. Гишүүн сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхэлсэн үү?
---	-------------------	------------------	---------------------------------	---	---

<ol style="list-style-type: none"> 1. Өрхийн тэргүүн 2. Эхнэр/нөхөр 3. Хүү / Охин 4. Эцэг / Эх 5. Ах / Эгч / Дүү 6. Хадам эцэг / Хадам эх 7. Хүргэн / Бэр 8. Өвөг эцэг / Эмэг эх 9. Ач / Зээ / Гуч 10. Бусад төрөл төрөгсөд 11. Хамааралгүй 	<ol style="list-style-type: none"> 1. Эрэгтэй 2. Эмэгтэй 	<ol style="list-style-type: none"> 1. 15-24 2. 25-34 3. 35-44 4. 45-55 5. 56-60 	<ol style="list-style-type: none"> 1. Боловсролгүй /Бичиг үсэгт тайлагдаагүй/ 2. Боловсролгүй /Бичиг үсэгт тайлагдсан/ 3. Бага 4. Суурь 5. Бүрэн дунд 6. Мэргэжлийн боловсрол 7. Дипломын 8. Бакалавр 9. Магистр 10. Доктор 	<ol style="list-style-type: none"> 1. Тийм 2. Үгүй 	<ol style="list-style-type: none"> 1. Тийм 2. Үгүй
<p>28. Гишүүн сүүлийн хагас жилд дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн үү?</p>	<p>29. Гишүүн сүүлийн хагас жилд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамрагдаж, зөвлөгөө авсан уу?</p>	<p>30. Гишүүн сүүлийн хагас жилд дүүрэг, хорооны оролцоотой нийтийг хамарсан ажилд оролцсон уу?</p>	<p>31. Гишүүн сүүлийн хагас жилд дүүрэг, хорооноос зохион байгуулсан сургалт болон бусад үйл ажиллагаанд оролцдог уу?</p>	<p>32. Гишүүн дүүрэг, хорооны дэмжлэгтэйгээр түр ажлын байранд зуучлагдаж байсан уу?</p>	<p>33. Гишүүн дүүрэг, хорооны дэмжлэгтэйгээр байнгын ажлын байранд зуучлагдаж байсан уу?</p>

1. Тийм 2. Үгүй	1. Тийм 2. Үгүй	1. Тийм 2. Үгүй	1. Идэвхтэй оролцдог 2. Оролцдог 3. Оролцдоггүй	1. Тийм 2. Үгүй	1. Тийм 2. Үгүй
34. Гишүүн ажил, хөдөлмөр эрхэлж байсан уу?	35. Гишүүн сүүлийн 6 сар ажил олгогчтой уулзах, анкет бөглөх зэргээр ажил идэвхтэй хайсан уу?	36. Гишүүн аль хэлбэрийн ажилтан бэ?	37. Гишүүний ажилладаг байгууллагын хариуцлагын хэлбэрийг сонгоно уу.		
1. Өмнө нь ажил хийж байсан 2. Ажил хайж байгаа 3. Огт ажил хийж байгаагүй	1. Тийм 2. Үгүй	Цалин хөлстэй байнгын ажиллагч Цалин хөлстэй түр ажиллагч Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч Цалин хөлстэй дагалдан, мэргэшиж буй дадлагажигч Гэр бүлийн гишүүдэд хувь нэмрээ оруулагч Бусад (тодруулна уу)	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч Компани Хоршоо Төрийн өмчит, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар Төсөвт байгууллага Төрийн бус байгууллага Бусад (тодруулна уу)		
38. Гишүүний ажлын ангиллыг сонгоно уу.		39. Гишүүний ажил эрхэлж буй салбарыг сонгоно уу.			

<p>Менежер Мэргэжилтэн Техникч болон туслах / дэд мэргэжилтэн Контор, үйлчилгээний ажилтан Худалдаа, үйлчилгээний ажилтан Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч Зэвсэгт хүчний ажил, мэргэжил Энгийн ажил, мэргэжил</p>	<p>Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур Уул уурхай, олборлолт Боловсруулах үйлдвэрлэл Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа Барилга Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ Мэдээлэл, холбоо Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал Боловсрол Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа Урлаг, үзвэр, тоглоом, наадам Үйлчилгээний бусад үйл ажиллагаа Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа</p>
---	--

<p>40. Гишүүний сүүлийн 6 сарын дундаж цалингийн хэмжээг бичнэ үү.</p> <p>.....</p>	<p>41. Гишүүний 7 хоногт ажилладаг цагийг бичнэ үү.</p> <p>.....</p>	<p>43. Гишүүний хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан аль нь вэ? (Хэдэн ч хариултыг сонгож болно)</p>	
<p>42. Гишүүн нийгмийн даатгал төлдөг үү?</p>		<ol style="list-style-type: none"> 1. Энэ жилд цэргээс халагдсан 2. Энэ жилд сургууль төгссөн 3. Аав, ээж, гэр бүл, үр хүүхдээ дагаад шилжин суурьшсан 4. Хүүхдээ сургуульд зөөдөг 5. Гадаадад амьдарч байгаад ирсэн 6. Засан хүмүүжүүлэх газраас суллагдсан 7. Байгууллага татан буугдсан 8. Цомхотголд орсон 9. Улирлын чанартай ажил хийдэг болохоор 10. Мэргэжил, дадлага туршлага байхгүй 11. Мэргэжилд тохирох ажил олдохгүй 12. Ажил хайгаад олдохгүй байгаа 13. Байгалийн гамшиг, аюулт үзэгдэлд өртөж малгүй болсон (ган, зуд, үер) 14. Ажиллах сонирхолгүй байсан 	<ol style="list-style-type: none"> 15. Цалин бага, ажиллахтай холбоотой зардалдаа таардаг 16. Эрүүл мэндийн хувьд ажиллах боломжгүй 17. Сэтгэл зүйн дарамттай байдаг 18. Архины хамааралтай 19. Өмнөх ажлын байрны дарамтаас шалтгаалан хүнд санагддаг болсон 20. Халамж, тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөөрөө амьдрах боломжтой 21. Бага насны хүүхдээ хардаг 22. Байнгын асаргаа шаардлагатай гэр бүлийн гишүүнээ асардаг 23. Их, дээд сургуульд суралцдаг 24. Хөдөлмөрийн чадвараа алдсан 25. Хамт олон дунд ажиллахад төвөгтэй, дасдаггүй 26. Хөгжлийн бэрхшээлтэй 27. Жирэмсний амралттай байгаа 28. Бусад (тодруулна уу)
<ol style="list-style-type: none"> 1. Тийм, нийт цалингаасаа нийгмийн даатгал төлдөг 2. Тийм, цалингийнхаа тодорхой хувиас нийгмийн даатгал төлдөг 3. Тийм, хувиараа сайн дурын нийгмийн даатгал төлдөг 4. Тийм, улсаас нийгмийн даатгал төлж өгдөг 5. Үгүй, огт төлдөггүй 			

ӨРХИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ - 2

136. Өрхийн цалин хөлсний орлогын хэмжээг бичнэ үү. / сараар/	137. Өрхийн тэтгэврийн орлогын хэмжээг бичнэ үү. (сараар)	138. Өрхийн тэтгэмжийн орлогын хэмжээг бичнэ үү. /сар бүр авдаг/	139. Өрхийн тэтгэмжийн орлогын хэмжээг бичнэ үү. /1 жилд авдаг/	140. Өрхийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын хэмжээг бичнэ үү. / жилээр/
.....
141. Өрхийн хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын хэмжээг бичнэ үү. (жилээр)	142. Өрхийн бусад орлогын хэмжээг бичнэ үү. (жилээр)	143. Өрхийн гадаадаас ирсэн мөнгөн шилжүүлгийн хэмжээг бичнэ үү. (жилээр)	144. Өрхийн өөрийн аж ахуйгаас сүүлийн 1 жилийн хугацаанд хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээг дунджаар бичнэ үү.	145. Өрхийн сүүлийн 1 жилийн хугацаанд бусдаас үнэгүй хэрэглэсэн бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээг дунджаар бичнэ үү.
.....
146. Танай өрхийн гишүүд ямар аргаар ажил хайсан бэ? (Хэдэн ч хариултыг сонгож болно)			147. Ажил хайсан ч олдохгүй байгаа шалтгаан юу вэ? (Хэдэн ч хариултыг сонгож болно)	

<ol style="list-style-type: none">1. Зарын сонин худалдан авч холбогддог2. Интернэт сүлжээнд тавигдсан зараар холбогддог3. Танил, хамаатан, найз нөхдөөсөө сурагладаг4. Сонинд өөрөө зарлал өгсөн5. Дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс болон хөдөлмөр зуучлалын байгууллагад бүртгүүлдэг6. Ажил олгогч байгууллагад өргөдөл өгч, анкет бөглөж хандсан7. Дүүрэг, хорооны халамжийн ажилтнуудаас мэдээлэл авдаг8. Бусад (тодруулна уу)	<ol style="list-style-type: none">1. Ажлын байр байхгүй2. Нас тохирохгүй3. Мэдлэг болон ур чадвар шаардлагад нийцэхгүй4. Цалин хөлс бага байдаг5. Цалин хөлсөө тохиролцож чаддаггүй6. Хүйс болон гадаад төрх тохиороогүй7. Ажиллах цаг хэт урт8. Ажлын байрны нөхцөл муу9. Ажлын байранд тавигдах шаардлага өндөр10. Бусад (тодруулна уу)
148. Ажил олгогчийн зүгээс тавьдаг дараах нийтлэг шаардлагуудаас аль шаардлагыг ихэвчлэн хангахгүй байна вэ? /Хэдэн ч хариулыг сонгож болно/	149. Монгол Улсын Засгийн газраас 2022-2023 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар мэдэх үү?

<ol style="list-style-type: none"> 1. Мэргэжлийн диплом эсвэл мэргэшлийн үнэмлэхтэй байх 2. Тухайн чиглэлээр-с доошгүй жил ажилласан байх 3. Ажлын гүйцэтгэлээр цалинжих 4. Компьютер, техник хангамжууд дээр ажиллах чадвартай 5. Англи хэлний мэдлэгтэй 6. Ар гэрийн асуудал бага, ачаалал даах чадвартай байх 7. Харилцааны соёлтой, багаар ажиллах чадвартай байх 8. Шаардлагатай үед илүү цагаар ажиллах, томиллолтоор явах 9. Хувийн зохион байгуулалт сайтай байх 10. Бусад (тодруулна уу) 	<ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр 2. Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр 3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 5. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 6. Ногоон ажлын байр хөтөлбөр 7. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 8. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр 2019-2024 он 9. Хөтөлбөрүүдийн талаар огт мэдэхгүй байна 	
<p>150. Сүүлийн 6 сард хөдөлмөр эрхлэлтийг дэмжих олон улсын болон төрийн бус байгууллагын ямар төсөл, хөтөлбөрт хамрагдсан бэ?</p>	<p>152. Дүүрэг, хорооноос зохион байгуулдаг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт, үйл ажиллагаа нь оновчтой, тохиромжтой байж чаддаг уу?</p>	<p>153. Хөдөлмөр эрхлэхэд тулгамдаж буй бэрхшээлийг сонгоно уу. (Хэдэн ч хариулыг сонгож болно)</p>

.....	<ol style="list-style-type: none"> 1. Тийм, оновчтой, тохиромжтой байдаг 2. Зарим тохиолдолд оновчтой, тохиромжтой байдаг 3. Огт тохиромжгүй байдаг 4. Сургалт, үйл ажиллагааны талаар мэдэхгүй 	<ol style="list-style-type: none"> 1. Ажлын байр байхгүй 2. Асаргаа шаардлагатай гишүүнтэй 3. Бага насны хүүхэдтэй 4. Мэргэжлийн үнэмлэх, диплом байхгүй 5. Байнгын оршин суух хаяг, бүртгэлгүй 6. Цалин бага 7. Ажлын байрны шаардлага өндөр 8. Ажлын цаг урт, ар гэрийн байдал хүндрэлтэй 9. Ажлын анкет бөглөж өгдөг ч тодорхойгүй шалтгаанаар татгалзсан хариу өгдөг 10. Ажлын хамт олон, удирдлагын таагүй харьцаанаас болоод тогтвортой ажиллахад хүндрэлтэй 11. Бусад (тодруулна уу)
151. Таны амьдардаг хорооноос хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээр сүүлийн 1 жилд холбогдсон уу?		
<ol style="list-style-type: none"> 1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй 		

Судалгаанд хамрагдсан танд маш их баярлалаа.

Хавсралт 2. Фокус бүлгийн ярилцлагын асуулт

1. Ажлын байранд тавигдах шаардлага байна уу. Яагаад ажиллах хүн олдохгүй байна гэж үзэж байна вэ?
2. Цалин, хөлс, татвар, нийгмийн даатгал хөндөгдөнө. Цалин, үнэлгээг хэрхэн нэмэгдүүлэх вэ?
3. Ажлын байрны шаардлага хангахын тулд иргэн өөрөө, төр, бусад оролцогч талууд хэрхэн ажиллавал үр өгөөжтэй байх вэ?
4. Иргэн бүрийг мэргэжилтэй болгох нь чухал. Суралцаагүй үлдэж буй бүлэг байна уу? Ямар шалтгаанаар мэргэжилтэй болж чадахгүй байна вэ?
5. Мэргэшүүлэх сургалт, түүний чанар, үр өгөөж, дадал эзэмшиж буй байдал хэр үр өгөөжтэй байна вэ?
6. Мэргэжлийн чиг баримжаа олгох тогтолцоог оновчтой болгох арга юу вэ?
7. Хөдөлмөр зуучлалын оновчтой хувилбар юу вэ?
8. Бэлэн мөнгө өгөх нь үр дүнтэй биш байна гэсэн дүгнэлт гарч байна. Халамж, дэмжлэг ямар хэлбэрээр хүндээ очвол үр дүнтэй байна вэ?

Хавсралт 3. Экспертийн ярилцлагын асуумж

А) Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын экспертийн ярилцлагын асуумж

Судалгааны зорилго: ХЭБ үйлчилгээнд хамрагддаг иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд төрийн байгууллага, нийгмийн халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ОУБ, ТББ-уудын зүгээс ямар арга хэмжээ авч хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй байх боломжийг тодорхойлох зорилготой.

1. ТББ, ОУ-ын төлөөллийн аль нь вэ?
 - Монголын төрийн бус байгууллага
 - Олон улсын байгууллага
2. Оролцогчийн овог, нэр, байгууллага, албан тушаалыг дэлгэрэнгүй бичнэ үү.
3. Нийгмийн салбарт ажилласан жилийг бичнэ үү.
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажилласан жилийг тодруулан бичнэ үү.

5. ХЭБ-т хамрагддаг, хөдөлмөр эрхэлдэг иргэдэд таны хувьд ямар бэрхшээлтэй тал ажиглагддаг вэ?
- Оршин сууж буй хорооны ойр орчимд ажлын байр цөөн учир ажилдаа ирж очихдоо их цаг зарцуулдаг
 - Ихэвчлэн ур чадвар бага шаарддаг ажил хийдэг учир цалин багатай байдаг
 - Хөдөөнөөс шилжин ирсэн учир дасан зохицоход хугацаа шаарддаг
 - Ихэвчлэн үндсэн ажилтан биш байдаг
 - Ар гэрийн шалтгаанаас болоод ихэвчлэн бага цагаар, түр ажил хийдэг
 - Эрүүл мэндийн шалтгаанаас болоод ихэвчлэн бага цагаар, түр ажил хийдэг
 - Ажил олгогчийн зүгээс дарамт шахалт ихтэй байдаг
 - Нэг байгууллагад тогтвортой ажиллах нь бага байдаг
 - Нэмэлт орлого олох боломж бага байдаг
 - Бусад (тодруулах)
6. ХЭБ-т хамрагддаг, хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн чадвартай иргэдэд таны хувьд ямар бэрхшээлтэй тал ажиглагддаг вэ?
- Иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй
 - Оршин сууж буй хороонд нь ажлын байр байхгүй
 - Дүүрэг, хороонд ажил хайгчаар бүртгүүлээгүй
 - Дүүрэг, хорооноос зохион байгуулдаг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт, үйл ажиллагаанд хамрагддаггүй
 - Шилжиж ирсэн учир ажлын байрны мэдээлэл дутмаг
 - Идэвхтэй ажил хайдаггүй
 - Тусалж дэмжих ах, дүү хамаатан садан багатай
 - Бага насны хүүхдүүдээ хардаг
 - Асаргаа шаардлагатай өрхийн гишүүнтэй
 - Ихэвчлэн бага, дунд боловсролтой буюу мэргэжилгүй
 - Сэтгэл зүйн дарамттай (гэр бүлийн хүчирхийлэл ажиглагддаг)
 - Архины хамааралтай
 - Мэргэжил, ур чадвар дутмагаасаа болоод үндсэн ажилтнаар ажиллах сонирхолгүй
 - Ажлын байртай болсон ч тогтвор суурьшилтай ажилладаггүй
 - Өрхийн одоогийн орлогоо амьдралд хүрэлцээтэй гэж үздэг
 - Бусад (тодруулах)

7. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжиж буй үндэсний аль хөтөлбөртэй уялдан өмнө ажилласан болон одоо ажиллаж байна вэ?
- “Алсын хараа 2050” Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
 - Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, 2016-2025
 - Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, 2016-2025
 - Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө, 2021-2024
 - Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
 - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2021-2022 оны хөтөлбөр
 - Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 2021
 - Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр, 2019-2022
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, 2021
 - Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, 2017-2021
 - Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, 2016-2021
 - Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, 2019-2024
 - Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
 - Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр
 - Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
 - Ногоон ажлын байр хөтөлбөр
 - Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
 - Бусад (тодруулна уу)
8. Та хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, тогтолцооны оновчтой байдалд дүгнэлт, санал өгнө үү.
9. Танай байгууллагаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт ХЭБ-ийн өрхийн оролцоо хэр түвшинд байдаг вэ?
10. Хөдөлмөр эрхлээд, өрхийн орлого нь нэмэгдээд, амьжиргааны түвшин нь сайжраад ХЭБ-ээс гарсан өрх бий юу? Хэдэн өрх байна вэ?
11. Иргэдийн сэтгэл ханамж, сэтгэл зүйг судалдаг уу, ажилладаг уу? Сэтгэлгээг нь өөрчлөх үйл ажиллагаа явуулдаг уу?

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр өрхүүдийг хамруулсан төсөл хэрэгжүүлж буй байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн сайн талуудыг сонгоно уу.

№	Үзүүлэлт	ОУБ	ТББ	ТБ
1	Мэргэжлийн чиг баримжаа олгож чаддаг			
2	Хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзэлтэй болгодог			
3	Ажлын байр бий болгодог			
4	Өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлдэг			
5	Өрхийн гишүүдэд тохирох үйлчилгээ үзүүлж чаддаг			
6	Өрхийн гишүүн бүрт хүрч ажилладаг			
7	Мэдэхгүй			
8	Бусад (тодруулах)			

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр өрхүүдийг хамруулсан төсөл хэрэгжүүлж буй байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн дутагдалтай талуудыг сонгоно уу.

№	Үзүүлэлт	ОУБ	ТББ	ТБ
1	Тухайн үедээ хэрэгжээд өнгөрдөг			
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмждэггүй			
3	Нэг удаагийн дэмжлэг үзүүлдэг			
4	Цөөн буюу сонгогдсон өрхүүдэд л хэрэгждэг			
5	Хорооны үйл ажиллагаатай хамааралгүй явагддаг			
6	Үр дүнг нь мэдээлдэггүй			
7	Бэлэнчлэх сэтгэлгээг нэмэгдүүлдэг			
8	Мэдэхгүй			
9	Бусад (тодруулна уу)			

12. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд ямар хүчин зүйл хамгийн их нөлөөлж байна вэ?

- Иргэдийн сэтгэл зүйн байдал
- Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал (хямрал, инфляц гэх мэт)
- Ажил олгогч нарын ажлын байранд тавьж буй шаардлага
- Татвар
- Ажил олгогчийн зүгээс ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэдэг байдал
- Ажлын байрны олдоц
- Ажлын байрны аюулгүй, тав тухтай байдал, ажлын байрны харилцаа
- Цалин хөлсний хэмжээ
- Нас
- Ар гэрийн байдал, ачаалал даах чадвар
- Мэргэжлийн баримжаа олгох сургалт, сургалтын чанар, төлбөр
- Намын харьяалал

- Бусад (тодруулна уу)
 - Иргэдийн эрхээ мэддэг, үүргээ ухамсарладаггүй байдал
 - Иргэдийн идэвхгүй байдал
13. ХЭБ үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд ямар арга хэмжээ авбал илүү үр дүнтэй байх вэ?
- Иргэдийг сэтгэл зүйн сургалтад хамруулах
 - Ажил олгогчидтой хамтран ажиллах
 - Өрхийг өөрийн үйлдвэрлэлтэй болгох
 - Хагас цагийн ажлын байранд зуучлах
 - Гэрээсээ ажиллах боломжтой ажлын байрыг нэмэгдүүлэх, зуучлах
 - Дүүрэг, хорооны орчинд, ойр ажлын байрыг нэмэгдүүлэх
 - Бичиг баримтжуулах
 - Гэр бүлийг нь тогтвортой байлгахад анхаарах
 - Архидалттай тэмцэх
 - Өрхийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, сэдэлжүүлэх
 - Өрхтэй ажилладаг анхан шатны нэгжтэй илүү хамтран ажиллах / хэсэг, хороо/
 - Бусад (тодруулна уу)
14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх 35 хувьтай байна. Сэтгэцийн бэрхшээлтэй өрх 11 хувь, хөдөлгөөний бэрхшээлтэй 10 хувь, харааны 6 хувь, сонсголын бэрхшээлтэй 5 хувь гэж тооцогдсон. Энэ иргэд рүү чиглэсэн орлого, хөдөлмөр эрхлэлтийг нь нэмэгдүүлэхэд юуг анхаарах шаардлагатай гэж үзэж байна вэ?
15. 21. Хөдөлмөр зуучлалыг хэрхэн зохион байгуулбал хамгийн үр ашигтай вэ?(найдвартай, хялбар, хүртээмжтэй зэрэг)
16. 22. Иргэдийг мэргэжилтэй болгоход юуг анхаарах шаардлагатай вэ? (МСҮТ, ажлын байран дээр суралцаж, дадлагажаад мэргэжлийн үнэмлэх, дипломтой болох гэх мэт)

Б) Хороодын хөдөлмөр, халамжийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтний ярилцлагын асуумж

Судалгааны зорилго: ХЭБ үйлчилгээнд хамрагддаг иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд төрийн байгууллага, нийгмийн халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ОУБ, ТББ-уудын зүгээс ямар арга хэмжээ авч хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй байх боломжийг тодорхойлох зорилготой.

1. Дүүрэг, хороог сонгоно уу.
 - Багануур 4-р хороо
 - Багахангай 1-р хороо
 - Баянгол 23-р хороо
 - Баянзүрх 35-р хороо
 - Налайх 1-р хороо
 - Сонгинохайрхан 7-р хороо
 - Сонгинохайрхан 26-р хороо
 - Сонгинохайрхан 41-р хороо
 - Сүхбаатар 16-р хороо
 - Хан-Уул 8-р хороо
 - Чингэлтэй 16-р хороо
2. Уг ажлын байран дээр ажилласан жилийг бичнэ үү.
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажилласан жилийг тодруулан бичнэ үү.
4. Таны хариуцдаг өрхийн тоо хэд вэ?
5. Таны хариуцдаг иргэний тоо хэд вэ?
6. Иргэд аль асуудлаар илүү ханддаг вэ?
 - Хөдөлмөр эрхлэлтийн
 - Халамжийн
7. Та нэг сарын ажлынхаа хэдэн хувьд халамжийн ажлыг гүйцэтгэдэг вэ?
8. Та нэг сарын ажлынхаа хэдэн хувьд хөдөлмөр эрхлэлтийн ажлыг гүйцэтгэдэг вэ?
9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд хийгдэж буй ажлуудаа гүйцэтгэл, ачааллаа тооцон эрэмбэлнэ үү.
 - Мэдээллээр хангаж туслалцаа үзүүлэх
 - Нийтлэг үйлчилгээ, төсөл хөтөлбөрт хамруулах
 - Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих
 - Тайлан, судалгаа гаргаж хүргүүлэх
 - Ажлын байрны сул орон тооны бааз үүсгэх
 - Шинэ ажлын байрны захиалгыг бүртгэх
 - Ажил хайгчийг бүртгэх
 - Чиг үүрэг заагдаагүй бусад ажлыг гүйцэтгэх

10. ХЭБ-т хамрагддаг, хөдөлмөр эрхэлдэг иргэдэд таны хувьд ямар бэрхшээлтэй тал ажиглагддаг вэ?
- Оршин сууж буй хорооны ойр орчимд ажлын байр цөөн учир ажилдаа ирж очихдоо их цаг зарцуулдаг
 - Ихэвчлэн ур чадвар бага шаарддаг ажил хийдэг учир цалин багатай байдаг
 - Хөдөөнөөс шилжин ирсэн учир дасан зохицоход хугацаа шаарддаг
 - Ихэвчлэн үндсэн ажилтан биш байдаг
 - Ар гэрийн шалтгаанаас болоод ихэвчлэн бага цагаар, түр ажил хийдэг
 - Эрүүл мэндийн шалтгаанаас болоод ихэвчлэн бага цагаар, түр ажил хийдэг
 - Ажил олгогчийн зүгээс дарамт шахалт ихтэй байдаг
 - Нэг байгууллагад тогтвортой ажиллах нь бага байдаг
 - Нэмэлт орлого олох боломж бага байдаг
 - Бусад (тодруулах)
11. ХЭБ-т хамрагддаг, хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн чадвартай иргэдэд таны хувьд ямар бэрхшээлтэй тал ажиглагддаг вэ?
- Иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй
 - Оршин сууж буй хороонд нь ажлын байр байхгүй
